

---

# МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

---

Дугаар №13

Улаанбаатар хот  
2019 оны 6 дугаар сар

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:  
САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН  
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА

# АГУУЛГА

|                                                                  |           |
|------------------------------------------------------------------|-----------|
| <b>ӨМНӨХ ҮГ</b>                                                  | <b>7</b>  |
| <b>ТОЙМ</b>                                                      | <b>8</b>  |
| <b>1. МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН</b>                                 | <b>11</b> |
| <b>1.1 Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тойм</b>      | <b>11</b> |
| • Дэлхийн эдийн засаг                                            | 11        |
| • Дэлхийн санхүүгийн зах зээл                                    | 13        |
| <b>1.2 Монгол Улсын макро эдийн засгийн тойм</b>                 | <b>16</b> |
| • Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал                        | 16        |
| • Гадаад сектор                                                  | 21        |
| • Бодит сектор                                                   | 26        |
| • Мөнгө санхүүгийн сектор                                        | 34        |
| • Улсын төсөв                                                    | 36        |
| <b>2. САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА</b>                      | <b>43</b> |
| <b>2.1 Банкны салбарын төлөв байдал</b>                          | <b>43</b> |
| • Банкны салбар                                                  | 43        |
| • Макро зохистой бодлого, түүний хэрэгжилт                       | 50        |
| • Хадгаламжийн даатгал                                           | 51        |
| <b>2.2 Банкны бус санхүүгийн салбарын төлөв байдал</b>           | <b>53</b> |
| • Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо      | 53        |
| • Хөрөнгийн зах зээл                                             | 59        |
| • Даатгалын салбар                                               | 64        |
| • Зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллага          | 68        |
| • Хөдөө аж ахуйн бирж ба түүхий эдийн арилжаа                    | 68        |
| <b>3. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ</b>        | <b>71</b> |
| <b>3.1 Хууль, эрх зүйн орчинд гарсан өөрчлөлт</b>                | <b>71</b> |
| <b>3.2 Төлбөр тооцооны систем</b>                                | <b>73</b> |
| <b>3.3 Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаа</b> | <b>76</b> |

## ДҮРСЛЭЛҮҮД

|              |                                                                           |    |
|--------------|---------------------------------------------------------------------------|----|
| Дүрслэл 1.1  | Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл                                   | 11 |
| Дүрслэл 1.2  | АНУ-ын эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүд                                | 11 |
| Дүрслэл 1.3  | Евро бүсийн ажилгүйдлийн түвшин                                           | 12 |
| Дүрслэл 1.4  | БНХАУ-ын нүүрсний импорт (сая тонн)                                       | 13 |
| Дүрслэл 1.5  | Зарим түүхий эдийн үнэ                                                    | 13 |
| Дүрслэл 1.6  | Хөгжингүй улс орнуудын бодлогын хүү                                       | 14 |
| Дүрслэл 1.7  | Зарим хөрөнгийн захын индекс                                              | 14 |
| Дүрслэл 1.8  | Зарим хөгжингүй орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж | 14 |
| Дүрслэл 1.9  | Голлох валютуудын ам.доллартай харьцах ханш                               | 15 |
| Дүрслэл 1.10 | Импортын жилийн өсөлт                                                     | 16 |
| Дүрслэл 1.11 | Гадаадын шууд хөрөнгө оруулалт                                            | 16 |
| Дүрслэл 1.12 | Монгол Улсын улирлын ДНБ-ий жилийн өсөлт                                  | 17 |
| Дүрслэл 1.13 | Гадаад, дотоод цэвэр актив болон M2 мөнгө                                 | 17 |
| Дүрслэл 1.14 | Монгол Улсын санхүүгийн мөчлөг                                            | 17 |
| Дүрслэл 1.15 | Инфляцийн задаргаа (УБ хот)                                               | 18 |
| Дүрслэл 1.16 | Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл                                              | 21 |
| Дүрслэл 1.17 | Урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл                                         | 21 |
| Дүрслэл 1.18 | Урсгал тэнцлийн санхүүжилт                                                | 21 |
| Дүрслэл 1.19 | Санхүүгийн дансны бүтэц                                                   | 22 |
| Дүрслэл 1.20 | Гадаад худалдааны нөхцөлийн индекс                                        | 22 |
| Дүрслэл 1.21 | Нийт экспорт                                                              | 22 |
| Дүрслэл 1.22 | Нийт импорт                                                               | 23 |
| Дүрслэл 1.23 | Гадаад валютын ханш                                                       | 23 |
| Дүрслэл 1.24 | Гадаад валютын албан нөөц                                                 | 24 |
| Дүрслэл 1.25 | Эдийн засгийн өсөлтийн задаргаа                                           | 26 |
| Дүрслэл 1.26 | Бодит ДНБ, нийт зээлийн өсөлт, нийт зээлийн чанар                         | 26 |
| Дүрслэл 1.27 | Өрхийн хэрэглээ, нийт хэрэглээний зээл, хэрэглээний импортын өсөлт        | 26 |
| Дүрслэл 1.28 | Хөрөнгө оруулалт, бизнесийн зээл, хөрөнгө оруулалтын импортын өсөлт       | 27 |
| Дүрслэл 1.29 | Уул уурхайн салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар             | 27 |
| Дүрслэл 1.30 | Боловсруулах салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар            | 27 |
| Дүрслэл 1.31 | Барилгын салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар                | 27 |
| Дүрслэл 1.32 | Худалдааны салбарын үйлчилгээ, зээлийн өсөлт, зээлийн чанар               | 28 |
| Дүрслэл 1.33 | Бусад салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар                   | 28 |
| Дүрслэл 1.34 | Өрхийн орлого, зарлагын харьцаа                                           | 29 |
| Дүрслэл 1.35 | Өрхийн орлого зарлагын зөрүү, хэрэглээний зээлийн өсөлт                   | 29 |
| Дүрслэл 1.36 | Иргэдийн зээлийн ДНБ-д эзлэх хувь                                         | 29 |
| Дүрслэл 1.37 | Өрхийн өрийн дарамтын үзүүлэлтүүд                                         | 30 |
| Дүрслэл 1.38 | Иргэдийн зээлийн үлдэгдэл, чанар                                          | 30 |
| Дүрслэл 1.39 | Иргэдийн чанаргүй зээлийн хувь, валютын төрлөөр                           | 31 |
| Дүрслэл 1.40 | Орон сууцны үнэ, ипотекийн зээлдэгчдийн жилийн өөрчлөлт                   | 31 |
| Дүрслэл 1.41 | Аж ахуйн нэгж байгууллагын нийт өр төлбөр ба ДНБ-ий харьцаа               | 31 |
| Дүрслэл 1.42 | Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа                                        | 32 |
| Дүрслэл 1.43 | Бие даах чадварын коэффициент                                             | 32 |
| Дүрслэл 1.44 | Зохицуулалтын коэффициент                                                 | 32 |
| Дүрслэл 1.45 | Активын өгөөж                                                             | 32 |
| Дүрслэл 1.46 | Хувийн хэвшлийн зээл, зээлийн чанар                                       | 33 |
| Дүрслэл 1.47 | Хувийн салбарын өрийн дарамт                                              | 33 |
| Дүрслэл 1.48 | Мөнгөний үзүүлэлтүүд (жилийн өсөлтийн хувь)                               | 34 |
| Дүрслэл 1.49 | M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа                                      | 34 |
| Дүрслэл 1.50 | Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага                         | 34 |
| Дүрслэл 1.51 | Мөнгөний нийлүүлэлт болон мөнгөний үржүүлэгч                              | 35 |

|              |                                                                                  |    |
|--------------|----------------------------------------------------------------------------------|----|
| Дүрслэл 1.52 | Банкнудын хадгаламж болон зээлийн хүү                                            | 35 |
| Дүрслэл 1.53 | Банк хоорондын захын хүү                                                         | 35 |
| Дүрслэл 1.54 | Банк хоорондын захын хүүгийн хэлбэлзэх интервал                                  | 36 |
| Дүрслэл 1.55 | Нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн жилийн өөрчлөлт                    | 38 |
| Дүрслэл 1.56 | Нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэл                                               | 38 |
| Дүрслэл 1.57 | Монгол Улсын гадаад өрийн бүтэц                                                  | 38 |
| Дүрслэл 1.58 | Засгийн газрын нийт төлбөр, сая ам.доллар                                        | 41 |
| Дүрслэл 1.59 | Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөр, сая ам.доллар                          | 41 |
| Дүрслэл 2.1  | Банкны салбарын активын бүтэц                                                    | 43 |
| Дүрслэл 2.2  | Банкны салбарын пассивын бүтэц                                                   | 43 |
| Дүрслэл 2.3  | Банкны салбарын актив, пассив гарсан өөрчлөлт                                    | 44 |
| Дүрслэл 2.4  | Банкны салбарын эх үүсвэрийн жилийн өсөлт                                        | 44 |
| Дүрслэл 2.5  | Банкны салбарын актив, зээлийн жилийн өсөлт                                      | 44 |
| Дүрслэл 2.6  | Олгосон зээлийн жилийн өсөлт                                                     | 45 |
| Дүрслэл 2.7  | Салбаруудын зээлийн төвлөрөл                                                     | 45 |
| Дүрслэл 2.8  | Зээлийн чанарын үзүүлэлт, салбараар                                              | 45 |
| Дүрслэл 2.9  | Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн жилийн өсөлт                           | 46 |
| Дүрслэл 2.10 | Чанаргүй зээлийн харьцаа, валютын төрлөөр                                        | 46 |
| Дүрслэл 2.11 | Өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд                                                     | 47 |
| Дүрслэл 2.12 | Банкны салбарын ашигт ажиллагаа                                                  | 47 |
| Дүрслэл 2.13 | Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар                                   | 48 |
| Дүрслэл 2.14 | Хөрвөх чадварын үзүүлэлтүүд                                                      | 48 |
| Дүрслэл 2.15 | Банкуудын эрсдэлийн хүлээлтийн түвшин (2018, эрсдэлийн бүлгүүдээр)               | 49 |
| Дүрслэл 2.16 | Банкуудын эрсдэлийн хүлээлтийн түвшин (2019, эрсдэлийн бүлгүүдээр)               | 49 |
| Дүрслэл 2.17 | Даатгалын хураамжийн орлого                                                      | 51 |
| Дүрслэл 2.18 | Бүртгэлтэй банк бус санхүүгийн байгууллагын тоо                                  | 53 |
| Дүрслэл 2.19 | Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц                            | 54 |
| Дүрслэл 2.20 | Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар                        | 54 |
| Дүрслэл 2.21 | Банк ба ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү                                         | 55 |
| Дүрслэл 2.22 | Байгуулбал зохих болон байгуулсан эрсдэлийн сан /хувиар/                         | 56 |
| Дүрслэл 2.23 | Z индекс ба өгөөжийн стандарт хазайлт                                            | 56 |
| Дүрслэл 2.24 | Зардал, орлогын харьцаа (Жил бүрийн эхний улирлын байдлаар)                      | 57 |
| Дүрслэл 2.25 | Хөрвөх чадварын харьцаа (Жил бүрийн эхний улирлын байдлаар)                      | 57 |
| Дүрслэл 2.26 | Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо                                    | 57 |
| Дүрслэл 2.27 | Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар                            | 58 |
| Дүрслэл 2.28 | Хадгаламж, зээлийн хоршоодын өр төлбөр ба өөрийн хөрөнгө                         | 58 |
| Дүрслэл 2.29 | Хадгаламж, зээлийн хоршоодын өөрийн хөрөнгийн хүрэлцээ                           | 59 |
| Дүрслэл 2.30 | Хөрвөх чадварын харьцаа                                                          | 59 |
| Дүрслэл 2.31 | Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ                                                  | 60 |
| Дүрслэл 2.32 | Хөрвөх чадварын харьцаа                                                          | 60 |
| Дүрслэл 2.33 | Хувьцааны арилжааны дүн                                                          | 60 |
| Дүрслэл 2.34 | Зах зээлийн өгөөжийн тархалт                                                     | 61 |
| Дүрслэл 2.35 | Хувьцааны үнийн хэлбэлзэл                                                        | 61 |
| Дүрслэл 2.36 | IPO гаргасан компанийн тоо                                                       | 62 |
| Дүрслэл 2.37 | Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт | 62 |
| Дүрслэл 2.38 | Арилжааны төлбөр тооцоо                                                          | 63 |
| Дүрслэл 2.39 | Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч                                | 65 |
| Дүрслэл 2.40 | Давхар даатгалын хураамж, ам.долларын ханш                                       | 67 |
| Дүрслэл 2.41 | Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү              | 68 |
| Дүрслэл 2.42 | Батлан даалт гаргасан байдал болон санхүүжилтийн эх үүсвэр                       | 69 |
| Дүрслэл 3.1  | Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт                   | 73 |
| Дүрслэл 3.2  | Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт                 | 73 |
| Дүрслэл 3.3  | Картын гүйлгээний нэг өдрийн дундаж үзүүлэлт                                     | 74 |

## ХҮСНЭГТҮҮД

|              |                                                                    |    |
|--------------|--------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт 1.1  | Төсвийн орлогын гүйцэтгэл                                          | 17 |
| Хүснэгт 1.2  | Урсгал тэнцлийн алдагдлын санхүүжилт                               | 21 |
| Хүснэгт 1.3  | Монгол Улсын нийт гадаад өр                                        | 23 |
| Хүснэгт 1.4  | Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өөрчлөлт                          | 25 |
| Хүснэгт 1.5  | Бодит ДНБ-ий өсөлт (салбаруудаар)                                  | 26 |
| Хүснэгт 1.6  | Иргэдийн өр, орлогын харьцаа (2018 оны 4 дүгээр улирлын байдлаар)  | 30 |
| Хүснэгт 1.7  | Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба урьдчилсан гүйцэтгэл         | 36 |
| Хүснэгт 1.8  | Нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл                       | 36 |
| Хүснэгт 1.9  | Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл                   | 38 |
| Хүснэгт 1.10 | Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд          | 40 |
| Хүснэгт 2.1  | Банкуудын эрсдэлийн хүлээлтийн түвшин (эрсдэлийн бүлгүүдээр)       | 50 |
| Хүснэгт 2.2  | Нийт харилцах, хадгаламжийн даатгагдсан байдал                     | 51 |
| Хүснэгт 2.3  | Сангийн хөрөнгийн бүтэц (2018 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар) | 52 |
| Хүснэгт 2.4  | Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд      | 53 |
| Хүснэгт 2.5  | Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл  | 54 |
| Хүснэгт 2.6  | Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд     | 55 |
| Хүснэгт 2.7  | Орлого, зарлага, ашигт ажиллагаа                                   | 55 |
| Хүснэгт 2.8  | ББСБ-ын зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хангасан байдал          | 56 |
| Хүснэгт 2.9  | Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик үзүүлэлтүүд          | 58 |
| Хүснэгт 2.10 | Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо          | 64 |
| Хүснэгт 2.11 | Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ                        | 64 |
| Хүснэгт 2.12 | Даатгалын компаниудын хөрөнгө балансын зүйлээр                     | 65 |
| Хүснэгт 2.13 | Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөр, бүтээгдэхүүнээр    | 65 |
| Хүснэгт 2.14 | Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн арилжааны үнийн дүн         | 69 |

## ШИГТГЭЭ

|            |                                                                                                                                                             |    |
|------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Шигтгээ 1: | Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд, учирч буй эрсдэлүүд | 19 |
| Шигтгээ 2: | Монгол Улсын Засгийн газрын гадаад өр                                                                                                                       | 39 |
| Шигтгээ 3: | Банкуудын эрсдэлийн хүлээлтийн судалгаа                                                                                                                     | 48 |

## ӨМНӨХ ҮГ

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-өөс хэлэлцэж шийдвэрлэсний дагуу “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г хагас жил тутам боловсруулан олон нийтэд танилцуулдаг бөгөөд энэ удаа 13 дахь дугаарыг СТБЗ-өөс Та бүхэнд өргөн барьж байна.

Монгол Улсын нүүрсний эсспорт нэмэгдэж, түүхий эдийн үнэ өссөний зэрэгцээ хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, 2018 онд бодит ДНБ 6.9 хувиар өссөн бол 2019 оны 1 дүгээр улиралд 8.6 хувиар өсч шинжээчдийн таамгаас даваад байна.

2017 оноос эхлэн Монгол Улсын Засгийн газар Олон Улсын Валютын Сан (ОУВС)-тай хамтран “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд ОУВС-гийн гүйцэтгэх захирлуудын зөвлөлөөс тус хөтөлбөрийн эхний 5 шатны үнэлгээг дүгнэж, улмаар хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс ОУВС-гаас нийт 157.2 сая зээлжих тусгай эрх буюу 217.3 сая ам.долларын санхүүжилтийг хүлээн авч, энэ хэмжээгээр гадаад валютын орох урсгал нэмэгдэж, албан нөөцийг өсгөх боломжийг бүрдүүлэв. Түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой банкны салбарын активын чанарын үнэлгээ (АЧҮ)-г олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу гадаадын хөндлөнгийн аудитын компаниар амжилттай гүйцэтгүүлэв. Үнэлгээний үр дүнд Монголбанкнаас өөрийн хөрөнгийн дутагдалтай банкуудад өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх хугацаатай үүрэг өгч, шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр авч ажиллав. Тухайлбал, “Капитал банк” ХХК-ийн хувьд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлээгүйн дээр хадгаламж эзэмшигч, харилцагч болон мөнгөн төлбөрийн шаардах эрх бүхий этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдний анхны шаардлагаар гарган өгч чадахгүй болж, банкны заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх

чадвар, банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж чадахгүйд хүрч, цаашид хэвийн үйл ажиллагаа эрхлэх чадваргүй болсон тул Монголбанкнаас 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр тус банкныг албадан татан буулгах шийдвэр гаргаж, үйл ажиллагааг нь зогсоов. Уг шийдвэр нь Монгол Улсын банкны системд бүтцийн өөрчлөлт, сайжруулалт хийгдэж буйн илрэл боллоо гэж олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд эерэгээр үнэлсэн байна.

Санхүүгийн салбар нь итгэлцэл дээр оршин тогтнох бөгөөд түүний тогтвортой байдал нь санхүүгийн зах зээлд оролцогчдын үнэн зөв мэдээлэлд үндэслэсэн бодитой хүлээлтээс ихээхэн хамааралтай байдаг. Энэ ч утгаараа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь Монгол Улсын санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд санхүү, эдийн засгийн бодлогын асуудлыг тогтмол авч хэлэлцэхийн зэрэгцээ, олон нийтэд хүргэж буй мэдээллийн чанарыг сайжруулах, санхүүгийн талаарх иргэдийн суурь мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г тогтмол боловсруулан нийтэлсээр байна. Тус тайланг боловсруулахдаа албан ёсны эх сурвалж, статистикт үндэслэсэн нийт макро эдийн засаг, санхүүгийн салбарын нөхцөл байдал, хандлагын талаар харилцан уялдаа бүхий мэдээлэл өгөх зарчмыг баримталж байна.

Энэхүү тайлангийн агуулгыг цаашид сайжруулахад уншигч таны оролцоо, хувь нэмэр ихээхэн чухал тул тайлантай холбогдох аливаа саналаа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын албанд хаяглан, [fsc@mongolbank.mn](mailto:fsc@mongolbank.mn) цахим шуудангаар ирүүлэхийг хүсье. Таны саналыг хүлээж авахдаа бид үргэлж таатай байх болно.

## ТОЙМ

Хөгжиж буй орнуудын эдийн засгийн идэвхжил саарсан, түүнчлэн улс хоорондын технологи, гадаад худалдааны маргаан болон аж үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт буурсан зэргээс шалтгаалан 2019 оны 4 дүгээр сард ОУВС-гийн шинжээчид 2019 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар бууруулж, 3.3 хувиар өснө гэж үзжээ.

2018 онд АНУ-ын эдийн засгийн идэвхжил нэмэгдэн потенциал түвшнээсээ давж, ДНБ-ий өсөлт 2.8 хувьд хүрсэн байна. АНУ-ын ДНБ-ий 70 орчим хувийг бүрдүүлдэг хувийн хэрэглээ 2018 онд 2.6 хувиар өссөний зэрэгцээ аж үйлдвэрлэл 2018 онд 4.1 хувиар өсч эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Хятадын эдийн засгийн өсөлт 2018 онд саарч 6.6 хувьтай гарсан нь 1990 оноос хойших хамгийн бага үзүүлэлт боллоо. 2017 онд 6.9 хувиар өсч байсан хувийн хэрэглээ 2018 онд 7.3 хувиар өсч өсөлтийг дэмжсэн хэдий ч, үйлдвэрлэлийн салбар, үл хөдлөх хөрөнгийн салбар дахь хөрөнгө оруулалтын өсөлт саарч, экспорт, жижиглэн худалдааны салбарын өсөлт буурснаар эдийн засгийн өсөлт ийнхүү саарсан байна.

2018 оны I болон IV улиралд дэлхийн голлох хөрөнгийн захад уналт ажиглагдаж байсан бол 2019 оны эхний 4 сард голлох индексүүд өссөн үзүүлэлттэй байна. АНУ болон БНХАУ хооронд өрнөөд байгаа худалдааны маргааны сөрөг нөлөөллийн улмаас компаниудын ашигт үйл ажиллагаа буурсан, Холбооны нөөцийн банк (ХНБ)-наас бодлогын хүүгээ өсгөсөн, Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширсан зэрэг нь хөрөнгийн зах зээлд дарамт учруулж, 2018 оны IV улиралд голлох хөрөнгийн зах зээлийн индексүүд буурахад нөлөөлсөн юм. Харин 2019 оны I улиралд хөрөнгийн зах зээлийн индексүүд огцом өссөн нь АНУ-ын макро эдийн засгийн таатай нөхцөл байдал болон ХНБ-ны уян хатан бодлогоос

шалтгаалсан болохыг шинжээчид мэдэгдээд байна.

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2019 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 322.9 сая ам.долларын ашигтай гарч, ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 369.8 сая ам.доллараар өсчээ. Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 369.6 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 86.4 сая ам.доллараар буурсан (сайжирсан) үзүүлэлт юм. Санхүүгийн данс 2019 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 592.4 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 244.6 сая ам.доллараар өссөн үзүүлэлт боллоо. Үүнд багцын хөрөнгө оруулалтын орох урсгал голлох нөлөөг үзүүлжээ.

2019 оны 1 дүгээр улиралд бодит секторын идэвхжил нэмэгдэж, улирлын ДНБ өмнөх оны мөн үеэс 8.6 хувь өслөө.

M2 мөнгөний нийлүүлэлт 2019 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар өсч 19.9 их наяд төгрөгт хүрчээ. Энэхүү өсөлтийн 17.7 нэгж хувийг бусад хадгаламжийн өсөлт, 4.9 нэгж хувийг M1 мөнгөний өсөлт тус тус бүрдүүлж байна.

2019 оны 4 дүгээр сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 3506.7 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн хэмжээнээс 2.5 хувь буюу 85.4 тэрбум төгрөгөөр өссөн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 3132.0 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн хэмжээнээс 5.0 хувиар буюу 149.0 тэрбум төгрөгөөр давж биелжээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2019 оны 4 дүгээр сарын байдлаар 3708.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 2845.5 тэрбум төгрөгийн буюу 76.7 хувийн, улсын төсвийн зарлага 2732.2 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 2274.6 тэрбум төгрөгийн буюу 83.2 хувийн гүйцэтгэлтэй



гарлаа. Тайлант хугацаанд Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцэл 661.2 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 286.5 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Банкны салбарт 2019 оны 4 дүгээр сарын байдлаар нийт 13 банк, 1425 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Давхардсан тоогоор нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 3.2 сая, зээлдэгчдийн тоо 1.3 саяд тус тус хүрлээ. Банкны салбарын нийт активын хэмжээ 2019 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 4.7 их наяд төгрөгөөр өсч 33.5 их наяд төгрөг (ДНБ-ий 104.2 хувь)-т хүрэв. Нийт активын бүтцийг авч үзвэл 48.4 хувь нь зээл, 22.2 хувь нь мөнгөн хөрөнгө, 12.9 хувь нь Төв банкны үнэт цаас, 4.3 хувь нь Засгийн газрын үнэт цаас, үлдэх 12.2 хувь нь бусад хөрөнгө тус тус байна. Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ 2019 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар 1.6 их наяд төгрөгт хүрч, нийт зээлийн 9.1 хувийг эзэлж байгаа бол анхаарал хандуулах зээлийн хэмжээ 1.2 их наяд төгрөгт хүрч, нийт зээлийн 7.0 хувийг бүрдүүлж байна.

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 539 Банк бус санхүүгийн байгууллага, 282 Хадгаламж зээлийн хоршоо, 18 Даатгалын компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа хэдий ч банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын санхүүгийн салбарт эзлэх хувь хэмжээ харьцангуй бага (нийт санхүүгийн салбарын активын 5 орчим хувь) хэвээр байгаа юм.

Санхүүгийн салбарын үндсэн дэд бүтэц болох төлбөр тооцооны системийн хэвийн үйл ажиллагаа хангагдаж байгаа бөгөөд 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нэг өдөрт дунджаар 26.7 тэрбум төгрөгийн 110.0 мянган ширхэг бага дүнтэй гүйлгээ, Банк сүлжээ системээр 4.5 мянган ширхэг их дүнтэй гүйлгээ тус тус хийгдсэн байна.

Санхүүгийн системийн эрсдэлүүдийг цаг хугацааны (time dimension) болон системийн оролцооны (cross-sectional) гэсэн хоёр хэсэгт ангилж үздэг бөгөөд цаг хугацааны санхүүгийн эрсдэлүүд нь санхүүгийн мөчлөг дагаж үүсдэг. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж буйн үр дүнд 2019 оны 1 дүгээр улиралд санхүүгийн салбарын цаг хугацааны эрсдэл буураад байна.

Банкны салбарын эрсдэл даах чадварыг харуулдаг I зэрэглэлийн өөрийн хөрөнгө ба эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 2019 оны 4 дүгээр сарын байдлаар 14.3 хувь, нийт өөрийн хөрөнгө ба эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 17.3 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдээс тус бүр 5.3 нэгж хувиар өндөр байгаа юм. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь банкны системийн тогтвортой байдлыг илтгэдэг үндсэн үзүүлэлтүүдийн нэг бөгөөд харилцагчийн анхны шаардлагаар төлбөрийг түргэн гүйцэтгэх чадварыг илэрхийлдэг. 2019 оны 4 дүгээр сарын байдлаар банкны системийн хэмжээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 42.0 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар буурсан хэдий ч Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны доод хязгаарлалт (25 хувь)-аас 17.0 нэгж хувиар өндөр байна.



## МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН


### 1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

#### ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

Хөгжиж буй орнуудын эдийн засгийн идэвхжил саарсан, түүнчлэн улс хоорондын гадаад худалдааны бодлогын асуудал болон аж үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт буурсан зэргээс шалтгаалан 2019 оны 4 дүгээр сард ОУВС-гийн шинжээчид 2019 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар бууруулж, 3.3 хувиар өснө гэж үзжээ. Түүнчлэн хөгжингүй орнуудын 2019 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөхөөс 0.2 нэгж хувиар бууруулж 1.8 хувь, хөгжиж буй орнуудын өсөлтийн төсөөллийг 0.1 нэгж хувиар бууруулж 4.4 хувь тус тус болгосон байна.

#### Дүрслэл 1.1

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл




Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл, “Дэлхийн эдийн засгийн хандлага (World economic outlook update)” тайлан, 2019 оны 4 дүгээр сар.

2018 онд АНУ-ын эдийн засгийн идэвхжил нэмэгдэн потенциал түвшнээсээ давж, ДНБ-ий өсөлт 2.8 хувьд хүрсэн байна. АНУ-ын ДНБ-ий 70 орчим хувийг бүрдүүлдэг хувийн хэрэглээ 2018 онд 2.6 хувиар өссөний зэрэгцээ аж үйлдвэрлэл 2018 онд 4.1 хувиар өсч эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Түүнчлэн хөдөлмөрийн зах зээлийн идэвх

сайжирч, ажил эрхлэлт нэмэгдэн 2018 онд 12 дугаар сард 312,000 ажлын байр шинээр бий болсон бол 2019 оны 4 дүгээр сард 263,000 ажлын байр нэмэгдэн, ажилгүйдлийн түвшин 3.6 хувь болж 49 жилийн хамгийн бага түвшинд хүрч буураад байна. АНУ-д эдийн засгийн суурь үзүүлэлтүүд ийнхүү сайн хэвээр байгаа хэдий ч дэлхийн эдийн засгийн байдлаас шалтгаалан Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ нэмэгдүүлэх хурдацаа удаашруулж, 2019 онд нэг удаа өсгөх хүлээлттэй байна. Цаашид АНУ-ын Засгийн газраас татварыг бууруулсан бодлогын нөлөө саармагжихын зэрэгцээ дэлхийн эдийн засаг дахь тодорхой бус байдал нэмэгдсэнтэй холбоотойгоор АНУ-ын эдийн засгийн өсөлт аажмаар саарч, 2019 онд 2.3 хувь, 2020 онд 1.9 хувь болж буурах хүлээлттэй байна.

#### Дүрслэл 1.2

АНУ-ын эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүд



Эх сурвалж: Блүүмберг.


АНУ-ын эдийн засгийн идэвхжил нэмэгдсэний нөлөөгөөр суурь инфляци эрчимжиж, 2018 онд дунджаар 2.4 хувьтай гарсан нь Холбооны нөөцийн банк (ХНБ)-ны зорилтот түвшин 2 хувиас давсан үзүүлэлт болов.

Евро бүсийн эдийн засаг 2018 оны II улиралд 2.2 хувиар өссөн бол III болон IV улиралд өсөлт нь саарч харгалзан 1.6 хувь болон 1.2 хувьтай гарав. Үүнд Евро бүсийн ДНБ-ий 29 хувийг бүрдүүлдэг Герман, 21 хувийг эзлэх Франц, 16 хувийг бүрдүүлдэг Итали зэрэг орнуудын эдийн засгийн өсөлт саарсан нь голлон нөлөөлөв. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдсэнээр хөрөнгө оруулалт саарсан, гадаад худалдааны идэвхжил буурсан, байгаль орчны шинэ стандарт мөрдөгдөж эхэлсэн нь автомашины үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлсөн, зарим улс оронд улс төр, нийгмийн тогтворгүй байдал үүссэн зэрэг нь эдгээр орнууд төдийгүй Евро бүсийн эдийн засгийн өсөлт саарахад голлох нөлөө үзүүлжээ. ОУВС-гийн шинжээчдийн төсөөллөөр Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2019 онд 1.3 хувь, 2020 онд 1.5 хувь гарах хүлээлттэй байна. Евро бүсийн хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил харьцангуй сайн байснаар ажилгүйдлийн түвшин 2019 оны I дүгээр улиралд 7.8 хувь болж буурсны зэрэгцээ ажиллагсдын цалин үргэлжлэн өсч байгаа нь дотоод эрэлт, үнийн өсөлтийг дэмжиж байна. Гэвч инфляцийн бүрэлдэхүүнд багтах газрын тосноос бусад бараа бүтээгдэхүүнүүдийн үнэ буурснаас шалтгаалан Евро бүсийн инфляци 2019 оны 4 дүгээр сард 1.7 хувь буюу Европын төв банкны зорилтот түвшин (2%)-ээс доогуур түвшинд гарлаа.

Европын төв банк бодлогын хүүгээ өсгөхгүй байгаа нь санхүүгийн нөхцөл байдлыг таатай болгож буй хэдий ч, 2018 оны 12 дугаар сард уламжлалт бус мөнгөний тэлэх бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн актив худалдан авах хөтөлбөр (APP)-өө дуусгавар болгож байгаагаа зарласан байна.

### Дүрслэл 1.3

#### Евро бүсийн ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: Блүүмберг.


Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын эдийн засгийн өсөлт 2018 онд саарч 6.6 хувьтай гарсан нь 1990 оноос хойшхи хамгийн бага үзүүлэлт боллоо. 2017 онд 6.9 хувиар өсч байсан хувийн хэрэглээ 2018 онд 7.3 хувиар өсч өсөлтийг дэмжсэн хэдий ч, үйлдвэрлэлийн салбар, үл хөдлөх хөрөнгийн салбар дахь хөрөнгө оруулалтын өсөлт саарч, экспорт, жижиглэн худалдааны салбарын өсөлт буурснаар эдийн засгийн өсөлт ийнхүү саарсан байна. Аж үйлдвэрийн салбарын идэвхжлийг илтгэх Caixin PMI индекс үргэлжлэн буурч байгаа нь хэрэглэгчид, бизнес эрхлэгчдийн итгэл буурсныг илэрхийлж байна. Цаашид тус улсад хэрэгжүүлсэн төсөв, мөнгөний тэлэх бодлогын нөлөө саармагжихын зэрэгцээ дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэж буйтай холбоотойгоор БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2019 онд 6.3 хувьд, 2020 онд 6.1 хувьд хүрч саарах хүлээлттэй байна.

Хятадын Ардын Банк (ХАБ) заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хэмжээг 2018 онд 4 удаа бууруулж, том банкуудад 14.5 хувь, жижиг банкуудад 12.5 хувь болгосон байна. ХАБ 2019 он гарснаас хойш ЗБН-ийн хувь хэмжээг дахин 1 нэгж хувиар бууруулах шийдвэр гаргажээ. Энэ нь ойролцоогоор шинээр 116 тэрбум ам.долларын зээлийг жижиг, дунд бизнесүүдэд зориулан гаргах боломжийг олгож байгаа юм. Түүнчлэн сангийн тэлэх бодлогын хүрээнд 2 их наяд юанийн

татварын хөнгөлөлт үзүүлэх, орон нутгийн бондуудаар дамжуулан төсвийн тэлэх бодлого явуулах хүлээлттэй байна. АНУ, БНХАУ-ын хоорондын худалдааны зөрчил үргэлжилж, импортын бараа, үйлчилгээнд ногдуулах нэмэлт тарифууд 2019 оноос хэрэгжиж эхлэх эрсдэл үүсээд байна. Энэхүү нэмэлт тарифын нөлөөгөөр БНХАУ-ын өсөлт саарч, түүхий эдийн үнэ буурч болзошгүй бөгөөд хөгжиж буй орнуудын хөрөнгийн урсгалд хэрхэн нөлөөлөх нь тодорхой бус хэвээр байна.

### Дүрслэл 1.4

#### БНХАУ-ын нүүрсний импорт (сая тонн)




Эх сурвалж: Блүүмберг.

БНХАУ-ын хойд, зүүн бүсийн 28 мужид 2018 оны 8 дугаар сараас эхлэн Африкийн гахайн тэжээлээс гаралтай гахайн мялзан өвчин дэгдэж, 2018 оны 4 дүгээр улиралд гахайн махны үнэ огцом өссөн. Энэхүү мялзан өвчний нөлөөгөөр БНХАУ-ын гахайн махны үйлдвэрлэл 2019 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар буурч, дотоодын

махны хэрэглээг импортын бусад төрлийн махаар орлуулж эхэлсэн байна. Гахайн мялзан өвчнөөс үүдэн БНХАУ-д хүнсний үнийн инфляци эрчимжин 2019 оны 4 дүгээр сард 2.5 хувь хүрч сүүлийн 6 сарын хамгийн өндөр түвшинд хүрээд байна.

### Дүрслэл 1.5

#### Зарим түүхий эдийн үнэ




Эх сурвалж: Блүүмберг.

2019 оны эхэнд 55.95 ам.долларын түвшинд нээгдсэн нэг баррель Брент төрлийн газрын тосны үнэ 4 дүгээр сарын эцэст 72.06 ам.долларт хүрч оны эхнээс 29 хувиар өсөөд байна. ОПЕК-ын гишүүн бус орнуудын газрын тосны нийлүүлэлт 2019 онд дунджаар өдөрт 64.54 сая/баррель болох төсөөлөлттэй байна. Харин ОПЕК-ийн гишүүн орнуудын газрын тосны гарц 2019 оны 3 дугаар сарын байдлаар өдөрт 30.02 сая/баррель болж өмнөх сараас өдрийн 534 мянган/баррелиар буураад байна.

## ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн зарим томоохон улс орнуудын Төв банкууд 2019 он гарсаар бодлогын хүүгээ өөрчлөлгүй хэвээр хадгаллаа. Тухайлбал, АНУ-ын ХНБ 2015 оноос хойш бодлогын хүүгээ нийт 9 удаа (2018 онд 4 удаа) тус бүр 0.25 нэгж хувиар өсгөж 2.25 хувиас 2.50 хувьд хүргээд байсан бол 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар бодлогын хүүг


хэвээр хадгалах шийдвэр гаргасан байна. Түүнчлэн Японы төв банк, Английн төв банк, Европын төв банк, Хятадын төв банкууд 2018 оны 3 дугаар улирлаас хойш бодлогын хүүгээ өөрчлөөгүй бөгөөд бодлогын хүүнүүд нь харгалзан -0.1 хувь, 0.75 хувь, 0 хувь, 4.35 хувьтай байна.

**Дүрслэл 1.6****Хөгжингүй улс орнуудын бодлогын хүү (хувиар)**

Эх сурвалж: Блүүмберг.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн статистик болно.

2018 оны IV улиралд дэлхийн голлох хөрөнгийн захад уналт ажиглагдаж байсан бол 2019 оны эхний 4 сард голлох индексүүд өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2019 оны эхнээс S&P 500 индекс 17.4 хувиар, MSCI world индекс 15.8 хувиар, MSCI emerging индекс 12.9 хувиар, MSCI Europe индекс 15.8 хувиар, Hang Seng индекс 18.2 хувиар, Nikkei 225 индекс 13.8 хувиар тус тус өслөө.

**Дүрслэл 1.7****Зарим хөрөнгийн захын индекс**


Эх сурвалж: Блүүмберг.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн статистик болно. 2015.12.31=100.

АНУ болон БНХАУ хооронд өрнөөд байгаа худалдааны маргааны сөрөг нөлөөллийн улмаас компаниудын ашигт ажиллагаа буурсан, ХНБ-наас бодлогын хүүгээ өсгөсөн, Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширсан

зэрэг нь хөрөнгийн зах зээлд дарамт учруулж, 2018 оны IV улиралд голлох хөрөнгийн зах зээлийн индексүүд буурахад нөлөөлсөн юм. Харин 2019 оны I улиралд хөрөнгийн зах зээлийн индексүүд эргэн өссөн нь АНУ-ын макро эдийн засгийн таатай нөхцөл байдал болон ХНБ-ны уян хатан бодлогоос шалтгаалсан болохыг шинжээчид мэдэгдээд байна.

2019 оны I улиралд АНУ болон БНХАУ хооронд өрнөөд байсан худалдааны дайн намжих хүлээлт зах зээлд үүсээд байв. Гэвч АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп 2019 оны 5 дугаар сард БНХАУ-ын 200 тэрбум ам.долларын импортын бараа, бүтээгдэхүүний тарифыг 25 хувь болгож нэмэгдүүлж буй талаар мэдэгдсэнээр дэлхийн хоёр том эдийн засгийн хооронд өрнөж буй худалдааны маргаан улам хурцдаад байна.

**Дүрслэл 1.8****Зарим хөгжингүй орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж**

Эх сурвалж: Блүүмберг.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн статистик болно.

2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Англи улсын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын хүү оны эхнээс 0.092 нэгж хувиар буурч 1.185 хувьд, Герман улсын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын хүү 0.229 нэгж хувиар буурч 0.013 хувьд, Итали улсын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын хүү 0.187 нэгж хувиар буурч, 2.555 хувьд, Япон улсын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын хүү 0.043 нэгж хувиар буурч -0.04 хувьд тус тус хүрлээ.




2019 оны 3 дугаар сард АНУ-ын ХНБ-наас бодлогын хүүгээ 2.50 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргаснаар 2019 оны 3 дугаар сард АНУ-ын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөж 3 сарын хугацаатай Засгийн газрын бондын өгөөжөөс бага болж өгөөжийн муруй урвуу (inverted) хэлбэртэй болсон байна.

2019 оны эхнээс ам. долларын ханш еврогийн эсрэг 2.18 хувиар, Хятадын юанийн эсрэг 1.85 хувиар, Оросын рублийн эсрэг 6.95 хувиар тус тус суларсан бол Японы иений эсрэг 1.53 хувиар, Английн фунт стерлингийн эсрэг 2.29 хувиар, Швейцарь франкийн эсрэг 3.84 хувиар тус тус чангарлаа.

### Дүрслэл 1.9

#### Голлох валютуудын ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Блүүмберг.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаарх статистик болно.

## 1.2 МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


Гадаад секторын төлөвийг илэрхийлэгч гол үзүүлэлт болох төлбөрийн тэнцэл 2019 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 322.9 сая ам.долларын ашигтай гарлаа.

Гаалийн статистик мэдээгээр гадаад худалдааны тэнцэл 2019 оны эхний 4 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 202 сая ам.доллараар өсч 746 сая ам.долларын ашигтай гарсан. Үүнд импорт 12 хувиар буюу 184 сая ам.доллараар өссөн хэдий ч, экспорт 18 хувиар буюу 387 сая ам.доллараар өсч импортын өсөлтөөс давсан нь нөлөөлөв.

2019 оны эхний 4 сарын байдлаар гадаад худалдааны нийт эргэлт өмнөх оны мөн үеэс 15 хувийн өсөлттэй буюу 571 сая ам.доллараар өсч 4278 сая ам.долларт хүрсэн нь төсвийн орлого бүрдэлт, цаашлаад эдийн засгийн идэвхжилд эерэгээр нөлөөлж байна.

## Дүрслэл 1.10

## Импортын жилийн өсөлт



Эх сурвалж: Гааль, татварын ерөнхий газар.


Тэмдэглэл: Жил бүрийн эхний 4 сарын гүйцэтгэлийг ашиглав.

2019 оны эхний 4 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 19 хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 17 хувиар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 12 хувиар тус тус өсөв. Эдгээрээс хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортын өсөлт нь нийт импортын өсөлтийн 7 нэгж хувийг бүрдүүлжээ.

Нийт экспортыг голлох бүрэлдэхүүнээр авч үзвэл 2019 оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс уул уурхайн экспорт 18 хувиар, мал аж ахуйн экспорт 26 хувиар, аж үйлдвэрлэлийн экспорт 2 хувиар, газар тариалангийн экспорт 256 хувиар тус тус өсчээ. Эдгээрээс уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өсөлт нь нийт экспортын өсөлтийн 17 нэгж хувийг бүрдүүлж экспортын өсөлтөд голлох нөлөөг үзүүлэв.

## Дүрслэл 1.11

## Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр дүнгээр)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Томоохон компаниудын хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эргэн төлөлт хийгдсэн тул гадаадын шууд хөрөнгө оруулалт /цэвэр дүнгээр/ 2016 онд -4170.9 тэрбум ам.долларт хүрсэн.

\*-2019 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэл болно.


2019 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 70.3 хувиар өсч 592.4 сая ам.долларт хүрлээ. Санхүүгийн дансны гол үзүүлэлтийн нэг болох гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2019 оны эхний 4 сарын байдлаар 645.2 сая ам.долларт хүрчээ.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2015 онд 2.4 хувь, 2016 онд 1.2 хувь, 2017 онд 5.1 хувь, 2018 онд 6.9 хувийн өсөлттэй байсан бол 2019 оны эхний улиралд 8.6 хувийн өсөлттэй гарлаа.



### Дүрслэл 1.12

Улирлын ДНБ-ий жилийн өсөлт, 2010 оны үнээр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Уул уурхайн салбарын өсөлт эхний улиралд 14.5 хувьтай гарав. Харин уул уурхайн бус салбар мөн хугацаанд 6.8 хувиар өссөн ба үүний 2.2 нэгж хувийг бөөний болон жижиглэн худалдаа, 2.3 нэгж хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 1 нэгж хувийг бүтээгдэхүүний цэвэр татварын өсөлт тус тус бүрдүүлжээ.

### Хүснэгт 1.1

Төсвийн орлогын гүйцэтгэл (2019 оны 4 дүгээр сар, тэрбум төгрөг)

| Татварын төрөл                          | Төлөв. | Гүйц. | Зөрүү | Хувь |
|-----------------------------------------|--------|-------|-------|------|
| Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж   | 2 983  | 3 132 | 149   | 105% |
| Татварын орлого                         | 2 674  | 2 858 | 183   | 107% |
| Үүнээс:                                 |        |       |       |      |
| ААН-ийн орлогын албан татвар            | 486    | 564   | 78    | 116% |
| Нийгмийн даатгалын орлого               | 519    | 608   | 89    | 117% |
| Дотоодын барааны нэмэгдсэн өртгийн алба | 289    | 314   | 25    | 109% |
| Татварын бус орлого                     | 309    | 274   | -34   | 89%  |


Эх сурвалж: Сангийн яам.

2019 оны эхний 4 сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 3132.0 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 5.0 хувиар давж биеллээ.

Харин төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 76.7 хувийн гүйцэтгэлтэй буюу 2845.5 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 286.5 тэрбум төгрөгийн эерэг дүнтэй гарав

### Дүрслэл 1.13

Гадаад, дотоод цэвэр актив болон M2 мөнгө



Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын статистик болно.

M2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2019 оны 4 дүгээр сарын байдлаар 22.6 хувиар өсч 19.9 их наяд төгрөгт хүрлээ. Харин M1 мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.9 хувиар буюу 800.1 тэрбум төгрөгөөр өсч, мөнгөний нийлүүлэлтийн 18.4 хувь буюу 3.7 их наяд төгрөгтэй тэнцэж байна.

Санхүүгийн системийн эрсдэлүүдийг цаг хугацааны (time dimension) болон системийн оролцооны (cross-sectional) гэсэн хоёр хэсэгт ангилж үздэг. Цаг хугацааны санхүүгийн эрсдэлүүд нь санхүүгийн мөчлөг дагаж үүсдэг бөгөөд санхүүгийн мөчлөгийг таньж мэдэх нь санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, макро зохистой бодлого хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

### Дүрслэл 1.14

Монгол Улсын санхүүгийн мөчлөг



Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 1 дүгээр улирлын статистик болно.

2013 оны 4 дүгээр улирлаас хойш уналтын төлөвт шилжээд байсан Монгол Улсын санхүүгийн мөчлөг<sup>1</sup> 2016 оны 2 дугаар улирлаас сэргэж эхэлсэн бөгөөд 2018 оны 3 дугаар улиралд санхүүгийн мөчлөг 3.3 хувь, зээл ба ДНБ-ий харьцааны урт хугацааны трендээсээ зөрөх зөрүү 5.6 хувьд тус тус хүрсэн. Энэ нь санхүүгийн салбарт мөчлөгийн (цаг хугацааны) эрсдэл хуримтлагдаж байгааг илтгэж байв. Мөнгөний бодлогын хорооны 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар иргэдийн өрийн дарамтыг хязгаарлаж улмаар санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх зорилгоор банкнаас олгох иргэдийн хэрэглээний зээлд Өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоох, 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар ипотекийн бус иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байх шийдвэрүүдийг гаргаж, эдгээр шийдвэрүүд нь 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Үүний үр дүнд 2019 оны эхний улиралд шинээр олгосон зээлийн өсөлт саарч, улмаар санхүүгийн мөчлөг 2.3 хувь, зээл ба ДНБ-ий харьцааны урт хугацааны трендээсээ зөрөх зөрүү 3.6 хувьд хүрч тус тус буураад байна.

2019 оны 4 дүгээр сард улсын хэрэглээний үнийн индекс жилийн 7.0 хувиар, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс жилийн 7.8 хувиар тус тус өссөн байна. Дээрх хугацаанд Улаанбаатар хотын жилийн инфляцийг бүтцээр нь задлан авч үзвэл 1.6 нэгж хувийг мах, 0.6 нэгж хувийг махнаас бусад хүнсний бараа, 1.6 нэгж хувийг хувцас, бөс бараа, 2.0 нэгж хувийг орон сууц, ус, түлшний үнийн өөрчлөлт тайлбарласан бол үлдсэн 2.1 нэгж хувийг бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт бий болгожээ.

### Дүрслэл 1.15

#### Инфляцийн задаргаа (УБ хот)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын статистик болно.

<sup>1</sup> Монгол Улсын санхүүгийн мөчлөгийг зээл ба ДНБ-ий харьцааны зөрүү (гар), бодит зээлийн мөчлөг, орон сууцны үнийн мөчлөг зэрэг үзүүлэлтүүдийг нэгтгэж тооцсон болно. Аргачлалын талаар дэлгэрүүлэн Санхүүгийн тогтвортой байдлын тайлан №6-н 27 дугаар хуудаснаас танилцах боломжтой.

**Шигтгээ 1: Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд, учирч буй эрсдэлүүд**

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ)-аас 2017 онд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны 2 дахь удаагийн Харилцан үнэлгээг гүйцэтгэсэн бөгөөд тус үнэлгээгээр Монгол Улс техникийн хэрэгжилтийн 40 зөвлөмжөөс хангаагүй 5, хагас хангасан 15, дийлэнхийг хангасан 15, бүрэн хангасан 5 үзүүлэлттэй байсан бол үр дүнтэй байдлыг илэрхийлэх шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтээс 2 үзүүлэлтийг дунд зэрэг хангасан, харин 9 үзүүлэлтийг хангаагүй үр дүнтэй гарсан байна.

2017 оны 7 дугаар сард АНДББ-аас Монгол Улсын Харилцан үнэлгээний тайланг хэлэлцэж, улмаар Монгол Улсыг Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (Financial Action Task Force буюу FATF/ФАТФ)-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг (ОУХАХБ)-ийн эрчимтэй хяналтад авсныг зарлаж хугацаат үүрэг даалгавруудыг өгсөн билээ. Монгол Улс нэн түрүүнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль эрх зүйн орчноо өөрчлөх, улмаар Харилцан үнэлгээний тайлангаар хангалтгүй үнэлгээ авсан техникийн болон шууд хэрэгжилтийн үзүүлэлтүүдийг хангаж ажиллах үүрэг авсан юм. Монгол Улс ФАТФ, АНДББ-аас өгсөн үүрэг даалгавруудыг биелүүлэхгүй тохиолдолд эрчимтэй хяналтаас ФАТФ-ын “саарал жагсаалт”-д шилжиж олон улсын санхүүгийн захаас бүрэн тусгаарлагдах эрсдэлтэй юм.

Монгол Улсын үр дүнтэй байдлын шалгуур үзүүлэлтүүд үндсэндээ хангалтгүй дүн авсныг харгалзан үзэж Засгийн газраас шууд хэрэгжилтийн үзүүлэлтүүдийг сайжруулах зорилгоор 2018 оны 10 дугаар сар хүртэл хэрэгжүүлэх “Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдөр баталж 2018 оны 10 дугаар сар хүртэл хэрэгжүүлсэн билээ. Энэ хүрээнд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Терроризмтэй тэмцэх тухай хууль, Гаалийн тухай хууль, Шуудангийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр баталсан байна. Эдгээр нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлж, хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг мөн эрсдэлд суурилсны үндсэн дээр хийх, хуулийн нэр томъёоны тодорхойлолтуудыг олон стандартад нийцүүлэх, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг эрс чангатгахтай холбоотой заалтуудыг хуульд оруулсан байна.

Монгол Улс 2017 оны Харилцан үнэлгээний тайланд “хангаагүй” буюу “хагас хангасан” техникийн хэрэгжилтийн 20 үзүүлэлтийн үнэлгээг ахиулах хүсэлтийг АНДББ-д гаргаж, 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр техникийн үзүүлэлтийн биелэлтийн тайланг дагалдах мэдээ материалын хамт боловсруулан хүргүүлсэн юм.

Монгол Улс техникийн хэрэгжилтийн “дийлэнхийг хангасан” эсвэл “бүрэн хангасан” зөвлөмжийн тоо хамгийн багадаа 21-д хүргэх шаардлагатай юм. АНДББ-аас 2019 оны 5 дугаар сард ирүүлсэн тайланд дурдснаар Монгол Улсын хувьд техникийн хэрэгжилтийн

13 үзүүлэлтийн үнэлгээ ахиж, харин 1 үзүүлэлтийн үнэлгээ буурсныг мэдэгдсэний сацуу Монгол Улс шууд хэрэгжилтийн үзүүлэлтүүдээ тайлагнахыг үүрэг болгосон байна.

Монгол Улс ФАТФ-ын “саарал жагсаалт”-аас зайлсхийхийн тулд шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтээс хамгийн багадаа 6 үзүүлэлтийн хувьд дундаас дээш үнэлгээ авах шаардлагатай юм. Иймд дараах арга хэмжээг нэн даруй авах шаардлага тулгарч байна. Үүнд:

- Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.7, 4.1.8 болон 4.1.9-д заалтад заасан этгээдийн хяналт шалгалтын эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр МҮХАҮТ, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж хуулийн төсөл боловсруулж батлуулах;
- Засгийн газар Терроризмтой тэмцэх тухай хуульд Нэгдсэн үндэсний байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт өөрчлөлтийг тусган Улсын их хуралд өргөн барьж батлуулах;
- Засгийн газар, Монголбанк, Монголын банкны холбоо хамтран банкуудын гадаадын банк санхүүгийн байгууллагатай тогтоосон корреспондент банкны харилцааг өнөөгийн байгаа түвшингөөс дордуулахгүй байхад чиглэсэн бодлогын арга хэмжээг боловсруулж, батлуулах;
- Мөнгө угаахтай тэмцэх Үндэсний зөвлөл ФАТФ-ын 2019 оны 10 дугаар сарын уулзалтад Монгол Улсын тайланг бэлтгэх ажлын хэсгийг нэн яаралтай байгуулах;
- Засгийн газар, Монголбанк, СЗХ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн талаар олон нийтийн боловсрол, мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Монголбанк, СЗХ нь МУТСТ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх, чадавхжуулахад анхаарч ажиллах.
- Цагдаагийн ерөнхий газар, Улсын прокурорын ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Авилгатай тэмцэг газар, Тагнуулын ерөнхий газар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий нэгжийн үйл ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлж чадавхжуулахад анхаарч, өндөр дүнтэй мөнгө угаах гэмт хэрэгт онцгой анхааран ажиллах.

2019 оны 5 дугаар сард Монголбанкны Ерөнхийлөгч, ХЗДХЯ-ны сайдын хамтарсан тушаалаар Шууд хэрэгжилтийн үзүүлэлтүүдийг тайланг боловсруулах Ажлын хэсэг байгуулагдаад байна.

Монгол Улсын ОУХАХБ-ын эрчимтэй хяналтад байх хугацаа 2019 оны 10 дугаар сард дуусгавар болно. Эрчимтэй хяналт дууссанаар ФАТФ-аас юуны түрүүнд Монгол Улс Харилцан үнэлгээний тайлангаар хангалтгүй үнэлгээ авсан шууд хэрэгжилт дээр ахиц, дэвшил гарсан эсэхийг тогтоох юм. Үүний хүрээнд шууд хэрэгжилттэй холбоотойгоор өгсөн зөвлөмжийг Монгол Улс хэрхэн биелүүлснийг магадлахын сацуу ажиглалтын хугацаанд эхлүүлсэн буюу үргэлжлүүлэн авсан арга хэмжээнүүд дорвитой үр дүнд хүрсэн эсэхийг шалгах юм. Монгол Улсыг ахиц дэвшил гаргаагүй гэж үзвэл Монгол Улсын Засгийн газартай тусгайлсан хөтөлбөр тохирч “саарал жагсаалт”-д оруулах зөвлөмжийг ФАТФ-д хүргүүлнэ.


## ГАДААД СЕКТОР

### Нийт төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2019 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 322.9 сая ам.долларын ашигтай гарч, ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 369.8 сая ам.доллараар өсчээ. Санхүүгийн данс 592.4 сая ам.долларын ашигтай гарч өнгөрсөн оны мөн үеэс 244.6 сая ам.доллараар нэмэгдэв.

### Дүрслэл 1.16

Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл (сая ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк.

### Урсгал ба хөрөнгийн данс

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 369.6 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 86.4 сая ам.доллараар буурсан (сайжирсан) үзүүлэлт юм.

### Дүрслэл 1.17

Урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл




Эх сурвалж: Монголбанк.

Анхдагч орлогын дансны тэнцэл 111.3 сая ам.доллараар буурч -408.3 сая ам.долларт хүрсэн хэдий ч барааны худалдааны ашиг 214.5 сая ам.доллараар өсч 627.0 сая ам.долларт хүрсэн нь урсгал ба хөрөнгийн дансны алдагдал ийнхүү буурахад голлон нөлөөлжээ.

### Дүрслэл 1.18

Урсгал тэнцлийн санхүүжилт



Эх сурвалж: Монголбанк.

Харин хоёрдогч орлого болон хөрөнгийн дансны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

### Хүснэгт 1.2

Урсгал тэнцлийн алдагдлын санхүүжилт

| Огноо   | Зээлийн санхүүжилт | Зээлийн бус санхүүжилт | Гадаад валютын нөөц |
|---------|--------------------|------------------------|---------------------|
| 2010    | 20%                | 179%                   | -98%                |
| 2011    | 9%                 | 110%                   | 0%                  |
| 2012    | 10%                | 140%                   | -30%                |
| 2013    | 20%                | 79%                    | 39%                 |
| 2014    | 37%                | 112%                   | 24%                 |
| 2015    | 18%                | 89%                    | 28%                 |
| 2016    | 59%                | 156%                   | 3%                  |
| 2017    | 16%                | 242%                   | -126%               |
| 2018    | -4%                | 98%                    | 6%                  |
| 2019M4* | -45%               | 224%                   | -80%                |

Эх сурвалж: Монголбанк.


2018 оны 1 дүгээр улиралд урсгал тэнцлийн алдагдал ДНБ-ий 15.7 хувьтай тэнцэж байсан бол 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 13.1 хувь болж буурсан үзүүлэлттэй байна. Сүүлийн жилүүдэд урсгал дансны алдагдлыг зээлийн бус санхүүжилт, ялангуяа гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалаар голлон санхүүжүүлж байна.

### Санхүүгийн данс

Санхүүгийн данс 2019 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 592.4 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 244.6 сая ам.доллараар өссөн үзүүлэлт боллоо. Үүнд багцын хөрөнгө оруулалтын орох урсгал голлох нөлөөг үзүүлжээ.

#### Дүрслэл 1.19

Санхүүгийн дансны бүтэц (сая ам.доллар)<sup>2</sup>




Эх сурвалж: Монголбанк.

### Гадаад худалдаа

2019 оны 4 дүгээр сард экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 12 хувиар өссөн бол импортын үнийн индекс 1 хувиар буурч Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс (2012 оны 12 сарын суурьтай) 2.174 нэгж болж өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар сайжрав.

### Дүрслэл 1.20

Гадаад худалдааны нөхцөлийн индекс




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын статистик болно.

2019 оны эхний 4 сарын байдлаар экспорт өнгөрсөн оны мөн үеэс 18 хувиар өсөв. Үүнд зэсийн баяжмал 12 хувиар (3.5 нэгж хувь), чулуун нүүрс 22 хувиар (8.0 нэгж хувь) тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

### Дүрслэл 1.21

Нийт экспорт (жил бүрийн эхний 4 сарын байдлаар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.


Импорт өнгөрсөн оны мөн үеэс 12 хувиар өссөн бөгөөд гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 19 хувиар (7.4 нэгж хувь), хэрэглээний бүтээгдэхүүн 12 хувиар (3.4 нэгж хувь), нефтийн бүтээгдэхүүн 17 хувиар (3.2 нэгж хувь) тус тус өссөн үзүүлэлттэй байна.

<sup>2</sup> 2016 оны 2 дугаар улирлын гүйцэтгэл дээр Оюутолгойн далд уурхайн санхүүжилттэй холбоотойгоор тухайн компанийн авсан арилжааны зээл, тус компанийн хөрөнгө оруулагчдаа төлсөн зээлийн цэвэр дүнгээр засвар хийсэн болно.



### Дүрслэл 1.22

Нийт импорт (жил бүрийн эхний 4 сарын байдлаар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.


### Гадаад валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан дундаж ханш 2019 оны 4 дүгээр сард 2,634.9 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10 хувиар, гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон нэрлэсэн ханш (NEER) 3.2 хувиар тус тус суларсан, бодит үйлчилж буй ханш (REER) 2019 оны 3 дугаар сарын байдлаар 2.3 хувиар чангарсан байна<sup>3</sup>.

<sup>3</sup> Жигнэсэн дунджаар тооцсон нэрлэсэн болон бодит ханшийг гадаад худалдааны түнш орнуудтай хийсэн худалдааны жингээр жигнэж тооцдог болно.

### Дүрслэл 1.23

Гадаад валютын ханш (жилийн өөрчлөлтийн хувь)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын статистик болно. (+) Чангаралт (-) Сулралт

### Гадаад өр<sup>4</sup>

Монгол Улсын нийт гадаад өр (улсын болон хувийн секторыг нийтэд нь оруулснаар) сүүлийн 7 жил тасралтгүй өсч 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 6 хувиар буюу 1,609 сая ам.доллараар нэмэгдэж, 29.5 тэрбум ам.долларт хүрэв.

### Хүснэгт 1.3

Монгол Улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

| Үзүүлэлт                 | 2016Q1 | 2017Q1 | 2018Q1 | 2019Q1 | Өөрчлөлт |      |
|--------------------------|--------|--------|--------|--------|----------|------|
|                          |        |        |        |        | Дүн      | Хувь |
| Нийт гадаад өр           | 23 459 | 25 017 | 27 913 | 29 522 | 1 609    | 6%   |
| I. Засгийн газар         | 4 073  | 5 844  | 7 242  | 7 262  | 20       | 0%   |
| II. Төвбанк*             | 2 084  | 1 807  | 2 137  | 2 072  | -64      | -3%  |
| III. Банк                | 2 182  | 2 351  | 2 346  | 2 393  | 47       | 2%   |
| Богино хугацаат          | 444    | 741    | 769    | 780    | 12       | 2%   |
| Урт хугацаат             | 1 738  | 1 610  | 1 578  | 1 613  | 35       | 2%   |
| IV. Бусад сектор         | 3 787  | 7 473  | 7 954  | 8 385  | 431      | 5%   |
| Богино хугацаат          | 343    | 487    | 656    | 630    | -27      | -4%  |
| Урт хугацаат             | 3 444  | 6 986  | 7 297  | 7 755  | 458      | 6%   |
| V. Шууд хөрөнгө оруулалт | 11 333 | 7 541  | 8 234  | 9 409  | 1 176    | 14%  |

Эх сурвалж: Монголбанк.

<sup>4</sup> Энэхүү гадаад өрийн статистик мэдээллийг дэлхийн улс орнуудын Төв банкны жишгээр ОУВС-гийн "Гадаад секторын статистик боловсруулах 6 дугаар аргачлал"-д үндэслэн судалгаа, шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулсан статистик болно. Монгол улсын гадаад өрийн статистик нь Засгийн газар, Төв банк, Хадгаламжийн байгууллагууд, Бусад салбарын нийт гадаад өр болон Хөрөнгө оруулагчийн зээлийн нийлбэр дүн юм. Монголбанк нь дээрх аргачлалын шаардлагын дагуу өрийн үлдэгдлийн тооцоололд зах зээлийн үнэлгээний болон аккрузель суурийн зарчмуудыг ашигладаг тул бусад байгууллагуудаас бэлтгэн гаргаж буй тоон мэдээллүүдээс зөрүүтэй байж болно.



Гадаад өрийн бүтцийн хувьд авч үзвэл Төв банкны гадаад өр өнгөрсөн оны мөн үеэс 64 сая ам.доллараар буурч 2.1 тэрбум ам.долларт, Засгийн газрын гадаад өр 20 сая ам.доллараар өсч 7.3 тэрбум ам.долларт, бусад секторын гадаад өр 431 сая ам.доллараар өсч 8.4 тэрбум ам.долларт тус тус хүрчээ.


### Гадаад валютын албан нөөц (ГВАН)

2019 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар ГВАН өмнөх оны мөн үеэс 26 хувиар буюу 771.25 сая ам.доллараар өсч 3,751.5 сая ам.долларт хүрлээ. Улмаар гадаад валютын албан нөөцөөр импортын хэрэгцээг хангах түвшин 8.8 сард хүрч өсөөд байна.

Гэвч ГВАН-ийн одоогийн түвшин нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжид заасан 12 сарын импортын хэрэгцээг хангах түвшинд хүрээгүй хэвээр байна.

### Дүрслэл 1.24

Гадаад валютын албан нөөц



### Монгол Улсын зээлжих зэрэглэл

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг олон улсын зэрэглэл тогтоогч Фитч, Стандарт энд Пүүрс, Мүүдиз агентлагуудаас тогтоож байна.

Манай улсын зээлжих зэрэглэл<sup>5</sup> болон төлөв<sup>6</sup> 2015 оноос эхлэн буурч хөрөнгө оруулалтын хувьд өндөр эрсдэлтэй орны ангилалд багтаад байсан бол 2018 онд Мүүдиз, Фитч, Стандарт энд Пүүрс агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг тус бүр нэг шатаар ахиулсан юм. Харин 2019 он гарсаар зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг өөрчлөөгүй бөгөөд хамгийн сүүлд Мүүдиз агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр “Саал”-ээс “ВЗ” болгон дээшлүүлж төлөвийг “тогтвортой”, Фитч агентлаг 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдөр “В-” байсныг “В” болгон дээшлүүлж төлөвийг “тогтвортой”, Стандарт энд Пүүрс агентлаг 2018 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр “В-” байсныг “В” болгон дээшлүүлж төлөвийг “тогтвортой” гэж тус тус үнэлэв.

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд тайлант хугацаанд зээлжих зэрэглэлийг өөрчлөөгүй боловч, Монгол Улсын зээлжих зэрэглэлтэй холбоотой зарим хэвлэлийн мэдээ, мэдэгдэл гаргасан байна. Тухайлбал, Фитч агентлаг 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын банкны секторын талаар “Активын чанарын үнэлгээний нөлөөгөөр Монгол Улсын банкны салбар илүү хүчирхэг болно” гарчигтай хэвлэлийн мэдэгдэл гаргасан. Тус хэвлэлийн мэдэгдэлд Монгол Улсын банкны салбарт хийгдсэн активын чанарын үнэлгээний үр дүнд өөрийн хөрөнгийн дутагдалтай Капитал банкныг татан буулгасан нь банкны системд бүтцийн өөрчлөлт, сайжруулалт хийгдэж буйн илрэл боллоо гэж Фитч агентлагийн зүгээс дүгнэсэн байна.

Түүнчлэн Мүүдиз агентлаг 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдөр “Монгол Улс сүүлийн

<sup>5</sup> Тухайн улсын Засгийн газрын зээлийн чадварыг илэрхийлдэг ба худалдааны нөхцөлтэй авсан өр төлбөрөө хугацаанд нь, бүтнээр эргэн төлөх чадвартай эсэх мөн тус үүргээ биелүүлэх бэлэн байдлыг харуулдаг.

<sup>6</sup> Зээлжих зэрэглэлийн хандлагыг илтгэх бөгөөд “эерэг” төлөв нь зэрэглэл сайжрах боломжтойг, “сөрөг” төлөв нь зэрэглэл буурч болзошгүй эрсдэлтэйг илэрхийлнэ.

хугацаанд гаргасан ололт амжилтуудыг нь алдагдуулах эрсдэл бүхий гадаад болон дотоод сорилтуудтай тулгарч байна” гарчигтай хэвлэлийн мэдэгдэл гаргажээ.

### Хүснэгт 1.4

#### Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өөрчлөлт

| Огноо | Moody's |       | Fitch   |       | S&P     |       |
|-------|---------|-------|---------|-------|---------|-------|
|       | Үнэлгээ | Төлөв | Үнэлгээ | Төлөв | Үнэлгээ | Төлөв |
| 2005  | VI/18   |       | B+      | ●     |         |       |
|       | X/4     | B1    | ●       |       |         |       |
|       | XI/1    |       |         |       | B       | ●     |
| 2006  | XI/29   |       |         |       | B       | (+)   |
|       | XII/26  |       |         |       | B+      | ▲     |
| 2007  | XII/13  |       |         |       | BB-     | ▲     |
|       | IX/20   |       | B+      | (+)   |         | ●     |
| 2008  | VI/2    |       | B+      | ●     |         |       |
|       | XII/9   |       | B+      | (-)   |         |       |
|       | XII/19  |       |         |       | BB-     | (-)   |
| 2009  | I/18    |       | B       | ▼     |         |       |
|       | VI/10   | B1    | (-)     |       |         |       |
|       | X/30    | B1    | ●       |       |         |       |
|       | X/11    |       | B       | ●     |         |       |
|       | XI/20   |       |         |       | BB-     | ●     |
| 2010  | XI/23   |       | B+      | ▲     |         |       |
| 2011  | XII/19  |       |         |       | BB-     | (+)   |
| 2012  | X/29    |       |         |       | BB-     | ●     |
| 2013  | IV/16   |       |         |       | BB-     | (-)   |
|       | XII/13  |       | B+      | (-)   |         |       |
| 2014  | IV/29   |       |         |       | B+      | ▼     |
|       | V/26    | B1    | (-)     |       |         | ●     |
|       | VI/17   | B2    | ▼       | (-)   |         |       |
|       | XI/11   |       | B+      | (-)   |         |       |
| 2015  | IV/29   |       |         |       | B+      | (-)   |
|       | XI/03   |       |         |       | B       | ▼     |
|       | XI/04   |       | B       | ▼     |         | ●     |
|       | XI/24   |       | B       | ●     |         |       |
| 2016  | I/14    | B2    | (-)     | B     |         |       |
|       | III/31  | B2    | (-)     |       |         |       |
|       | IV/28   |       |         |       | B       | ●     |
|       | VI/21   |       | B       | ●     |         |       |
|       | VIII/19 |       |         |       | B-      | ▼     |
|       | VIII/26 | B3    | ▼       |       |         | ●     |
|       | XI/18   | Caa1  | ▼       | ●     |         |       |
|       | XI/21   |       | B-      | ▼     |         |       |
| 2017  | II/15   | Caa1  | ●       |       |         |       |
|       | II/20   |       | B-      | ●     |         |       |
|       | III/30  | Caa1  | ●       |       |         |       |
|       | IV/18   |       |         |       | B-      | ●     |
|       | XI/17   |       | B-      | (+)   |         |       |
|       | XI/30   | Caa1  | ●       |       |         |       |
| 2018  | I/18    | B3    | ▲       | ●     |         |       |
|       | IV/20   |       |         |       | B-      | ●     |
|       | VII/9   |       | B       | ▲     |         |       |
|       | XI/9    |       |         |       | B       | ▲     |

Зэрэглэлийн өөрчлөлт ▲▼  
Төлөв: (+)-эерэг; ●-тогтвортой, (-)-сөрөг

Эх сурвалж: Moody's, Fitch, S&P's, Монголбанк.


Уг хэвлэлийн мэдэгдэлд Мүүдиз агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээнд нөлөөлөх эдийн засгийн өсөлт болон төсвийн бат бэх байдал сүүлийн жилүүдэд сайжирсан, уул уурхайн салбарын гадаад хөрөнгө оруулалт болон хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрүүд Монгол Улсын гадаад валютын албан нөөцөд дэмжлэг болохоор байгаа боловч, 2019-2020 онд эдийн засгийн өсөлт саарч, олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурч болзошгүй байгаа нь эдийн засагт сорилтыг бий болгож байгаа талаар дурдсан байна.

## БОДИТ СЕКТОР

2019 оны 1 дүгээр улиралд бодит секторын идэвхжил нэмэгдэж, улирлын дотоодын нийт бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 8.6 хувь өслөө.

## Дүрслэл 1.25

Эдийн засгийн өсөлтийн задаргаа (%)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Банкны салбарын зээлийн багцад дийлэнх хувийг эзэлдэг уул уурхай, боловсруулах, барилга, худалдааны салбаруудын өсөлт эдийн засгийн өсөлтийн 5.4 нэгж хувийг бүрдүүлэв.

## Хүснэгт 1.5

ДНБ-ий бодит өсөлт (салбаруудаар)

|                                         | 2018         |            | 2019 I       |            |
|-----------------------------------------|--------------|------------|--------------|------------|
|                                         | Жилийн өсөлт | Эзлэх хувь | Жилийн өсөлт | Эзлэх хувь |
| 1 ДНБ-ий өсөлт                          | 6.9          | 6.9        | 8.6          | 8.6        |
| 2 Зээлийн багцад дийлэнх хувийг эзэлдэг | 5.3          | 2.4        | 12.5         | 5.4        |
| Уул уурхай                              | 5.1          | 1.1        | 14.4         | 3.5        |
| Боловсруулах                            | 15.7         | 1.0        | 2.6          | 0.2        |
| Барилга                                 | -5.0         | -0.2       | 6.4          | 0.1        |
| Худалдаа                                | 3.4          | 0.4        | 13.9         | 1.6        |
| 3 Бусад салбарууд                       | 5.7          | 2.5        | 5.6          | 2.4        |
| Бусад үйлчилгээ                         | 6.1          | 1.3        | 6.5          | 1.8        |
| Хөдөө аж ахуй                           | 4.5          | 0.6        | 2.1          | 0.1        |
| Тээвэр ба агуулах                       | 6.7          | 0.5        | 3.2          | 0.2        |
| Эрчим хүч                               | 8.2          | 0.1        | 3.2          | 0.1        |
| Мэдээлэл, холбоо                        | 4.0          | 0.1        | 11.6         | 0.2        |
| 4 Бүт. цэвэр татвар                     | 20.1         | 2.0        | 6.0          | 0.8        |


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Тухайлбал, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ харьцангуй өндөр түвшинд, эрэлт хэвийн хадгалагдсанаар уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтийг 3.5 нэгж хувиар тэтгэжээ. Мөн хөрөнгө оруулалтын шинжтэй машин, тоног төхөөрөмж, машины борлуулалт өссөнөөр худалдааны салбар

эдийн засгийн өсөлтөд 1.6 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэв. Харин бусад салбаруудын өсөлт эдийн засгийн өсөлтийн 2.4 нэгж хувийг бүрдүүлэв.

## Дүрслэл 1.26

Бодит ДНБ, нийт зээлийн өсөлт, нийт зээлийн чанар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

## Өрхийн хэрэглээ

Өрхийн хэрэглээ тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар өсч, нийт эрэлтэд 2.7 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэв.

## Дүрслэл 1.27

Өрхийн хэрэглээ, нийт хэрэглээний зээл<sup>6</sup>, хэрэглээний импортын өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Өрхийн орлого зарлагаас давахгүй байгаа, мөн Монголбанкнаас банкуудын хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаа болон хугацаанд хязгаарлалт тавьснаас шалтгаалж хэрэглээний импортын өсөлт удааширч, хэрэглээний зээлийн өсөлт буурсан байна.




### Худалдааны салбар

Нефть, уул уурхай, газар тариалангийн тоног төхөөрөмж худалдаалдаг аж ахуй нэгж байгууллагын борлуулалт огцом нэмэгдэж, худалдааны салбар тайлант улиралд 13.9 хувиар өсчээ. Хэдийгээр худалдааны салбарын өсөлт өндөр байгаа ч тус салбарын зээлийн өсөлт саарч байна.

#### Дүрслэл 1.32

Худалдааны салбарын үйлчилгээ, зээлийн өсөлт, зээлийн чанар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

### Бусад салбарууд

Бусад салбарууд тайлант улиралд 5.6 хувиар өссөн байна. Үүнд санхүү, даатгалын зуучлалын үйлчилгээний идэвхжил, интернэтийн үйлчилгээ, үүрэн утасны холбооны орлого нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

#### Дүрслэл 1.33

Бусад салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.


## Өрхийн сектор

Өрхийн төсөв, санхүүгийн байдал эрүүл, тогтвортой байх нь банкны салбар төдийгүй нийт санхүүгийн системийн тогтвортой байдалд чухал ач холбогдолтой байдаг.

Эдийн засгийн өсөлттэй уялдан өрхийн орлого нэмэгдсэн хэдий ч сүүлийн 13 улирлын туршид өрхийн дундаж зарлага, орлогоосоо давсан үзүүлэлттэй байна. Өрхийн бодит орлого өсөх нь өрхийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэн, амьжиргааны түвшинг өсгөх, улмаар зээлийн эргэн төлөлтийн чадавхыг сайжруулах эерэг нөлөөтэй байдаг. Улсын хэмжээнд өрхийн улирлын дундаж бодит орлого<sup>8</sup> 2019 оны эхний улиралд өнгөрсөн оны мөн үеэс 4.6 хувиар, нэрлэсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 11.3 хувиар тус тус өслөө. Өрхийн нэрлэсэн орлогын өсөлтийн 5.2 нэгж хувийг цалин хөлс, 1.3 нэгж хувийг тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговрын орлого, 2.6 нэгж хувийг мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлогын өсөлт тус тус бүрдүүлж байна.

### Дүрслэл 1.34

#### Өрхийн орлого, зарлагын харьцаа




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Хэдийгээр эдийн засгийн идэвхжилтэй уялдан ийнхүү өрхийн орлого нэмэгдсэн ч

өрхийн зарлага мөн тэлж, иргэд хэрэглээгээ зээлээр санхүүжүүлэх хандлагатай байна. 2019 оны эхний улирлын байдлаар өрхийн нэрлэсэн зарлага өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар өсчээ.

### Дүрслэл 1.35

#### Өрхийн орлого, зарлагын зөрүү




Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо.

Өрхийн өрийн дарамт нэмэгдэж байна. Банкны салбараас иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 2019 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 27.9 хувиар нэмэгдэж, 9.1 их наяд төгрөгт хүрлээ.

### Дүрслэл 1.36

#### Иргэдийн зээлийн ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк.


Хэрэглээний зээлийн өсөлтийн нөлөөгөөр 2016 оноос эхлэн иргэдийн зээл ба ДНБ-ий харьцаа өсөх хандлагатай байгаа бөгөөд 2019 оны эхний улирлын эцэст тус харьцаа 35.4

<sup>8</sup> Инфляци = 5.7 хувь

хувьд хүрээд байна. Хэрэглээний зээл<sup>9</sup> 2019 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 1267.4 тэрбум төгрөг буюу 30.7 хувиар өсч 5400.2 тэрбум төгрөгт хүрчээ. Гэвч 2019 оны эхний улиралд өрхийн хэрэглээний зээл, ДНБ-ий харьцаа өмнөх оны эцсээс 1 нэгж хувиар буурч 16 хувьд хүрсэн байна.

### Дүрслэл 1.37

#### Өрхийн өрийн дарамтын үзүүлэлтүүд



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Тэмдэглэл: \*Нэг өрхөд ногдох иргэдийн зээлийн өрийн үлдэгдлийг улсын дундаж өрхийн жилийн орлогод харьцуулж тооцов;

Өрхийн өр орлогоосоо хурдтай өсч байгаагаас шалтгаалан өрхийн өрийн дарамт сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байлаа. Тухайлбал, 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар нэг өрхөд ногдох өрийн хэмжээ 9.7 саяд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өссөн үзүүлэлт болсон юм. Харин 2019 оны 1 дүгээр улиралд нэг өрхөд ногдох өрийн хэмжээ 9.3 сая төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 3.3 хувиар буурсан байна.

### Хүснэгт 1.6

#### Иргэдийн өр, орлогын харьцаа (2018 оны 4 дүгээр улирлын байдлаар)

| Зээлийн төрөл | Өр, орлогын харьцааны тархалт |            |             | Дундаж өр, орлогын харьцаа |
|---------------|-------------------------------|------------|-------------|----------------------------|
|               | 70 хувиас бага                | 70-90 хувь | 90-100 хувь |                            |
| Цалин         | 80%                           | 17%        | 3%          | 54%                        |
| Тэтгэвэр      | 2%                            | 1%         | 97%         | 99%                        |
| Хэрэглээ      | 71%                           | 3%         | 14%         | 56%                        |
| Нийт          | 64%                           | 12%        | 23%         | 62%                        |


Эх сурвалж: Монголбанк

2018 оны 4 дүгээр улирлын байдлаар хэрэглээний зээлтэй иргэдийн хувьд татварын дараах орлогынхоо дунджаар 62 хувийг зээлийн төлбөрт зарцуулж байгаа нь өрхийн өрийн дарамт өндөр байгааг илтгэж байна. Дээрх өр, орлогын харьцааг зээлийн төрлөөр задалж үзвэл цалингийн зээлийн хувьд 54 хувь, тэтгэврийн зээлийн хувьд 99 хувь, хэрэглээний бусад зээлийн хувьд 56 хувь тус тус байна.

Банкны салбарын иргэдийн чанаргүй зээлийн хувь хэмжээ 2019 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өсч 3.1 хувьд хүрсэн байна.

### Дүрслэл 1.38

#### Иргэдийн зээлийн үлдэгдэл, чанар



Эх сурвалж: Монголбанк, Тэнхлэг зууч ХХК.


Нийт иргэдийн зээлийн 98.4 хувийг төгрөгийн зээл, үлдсэн хувийг гадаад валютын зээл бүрдүүлж байна. 2019 оны 4 дүгээр сард иргэдийн гадаад валютын чанаргүй зээлийн хувь огцом өсч, өмнөх оны мөн үеэс 10.0 нэгж хувиар нэмэгдэн 18.2 хувьд хүрээд байна. Түүнчлэн төгрөгийн чанаргүй зээл 255.7 тэрбум, гадаад валютын чанаргүй зээл 27.2 тэрбум төгрөгт хүрлээ.

<sup>9</sup> Цалин, тэтгэврийн зээлийг оруулж тооцов.



**Дүрслэл 1.39**

**Иргэдийн чанаргүй зээлийн хувь, валютын төрлөөр**




Эх сурвалж: Монголбанк.

ҮСХ-ноос мэдээлснээр орон сууцны үнэ 2019 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар, Тэнхлэг зууч ХХК-ийн мэдээлснээр 3.2 хувиар тус тус өсөв.

**Дүрслэл 1.40**

**Орон сууцны үнэ, ипотекийн зээлдэгчдийн тооны жилийн өөрчлөлт**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 1 дүгээр улирлын статистик болно.

2019 оны 4 дүгээр сард ипотекийн зээлийн нийт зээлдэгчдийн тоо 94146 хүрч өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өссөн дүнтэй байна.

## Хувийн сектор


2017 оны эцэст 203.5 хувьд хүрээд байсан аж ахуйн нэгжүүдийн<sup>10</sup> нийт өр төлбөр болон ДНБ-ий харьцаа эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаа, төлбөрийн чадвар сайжирснаар 2018 оны эцэст 161.6 хувь болж буураад байна.

Түүнчлэн эдийн засгийн өсөлт нэмэгдсэнтэй холбоотойгоор 2016 оны эцэст 244 хувь байсан өр төлбөр ба эдийн өмчийн харьцаа тасралтгүй буурсаар 2018 оны эцэст 142 хувьд хүрчээ.

Тус хугацаанд эдийн өмчийн хэмжээ харьцангуй тогтвортой байсан ч нийт өр төлбөрийн хэмжээ буурсан нь өр төлбөр ба эдийн өмчийн харьцаа ийнхүү буурах үндсэн шалтгаан болсон.

**Дүрслэл 1.41**

**Аж ахуйн нэгж байгууллагын нийт өр төлбөр ДНБ-ий харьцаа\***




Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*Жил бүрийн эцсийн байдлаар.


Бие даах чадварын коэффициент нь аж ахуйн нэгж байгууллагууд санхүүгийн хувьд хэр зэрэг бие даасан байгааг илтгэдэг чухал үзүүлэлт юм.

<sup>10</sup> Улсын хэмжээнд 95414 аж ахуйн нэгжийн 2018 оны 4 дүгээр улирлын тайланг Сангийн яам баталгаажуулж авсан бөгөөд эдгээр тайланд үндэслэн тооцсон болно.

**Дүрслэл 1.42****Өр төлбөр, эздийн өмчийн харьцаа**


Эх сурвалж: Сангийн яам.

Манай аж ахуйн нэгжүүдийн хувьд энэхүү үзүүлэлт 2015 оноос хойш тасралтгүй өсч, 2018 оны эцэст 41.3 хувьд хүрсэн хэдий ч олон улсад дагаж мөрдөгддөг зохистой түвшин (60 хувь)-ээс бага байна.

**Дүрслэл 1.43****Бие даах чадварын коэффициент**


Эх сурвалж: Сангийн яам.

Зохицуулалтын коэффициент нь аж ахуйн нэгжүүдийн өөрийн эх үүсвэрийн нэгж төгрөг тутамд ноогдож байгаа эргэлтийн хөрөнгийн хэмжээг харуулдаг үзүүлэлт юм. Манай аж ахуйн нэгжүүдийн хувьд тус коэффициент 2014 оноос хойш өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2017 оны эцэст 65.8 хувь байсан аж ахуйн нэгжүүдийн зохицуулалтын коэффициент 2018 оны эцэст 14.4 нэгж хувиар өсч, 80.2 хувьд хүрээд байна.

**Дүрслэл 1.44****Зохицуулалтын коэффициент**

Эх сурвалж: Сангийн яам.

2016 оны эцэст -3.5 хувьд хүрээд байсан аж ахуйн нэгжүүдийн активын өгөөж 2017 оноос эхлэн сайжирч 2018 оны эцэст 2.4 хувьд хүрээд байна. Харин аж ахуйн нэгж байгууллагуудын татварын өмнөх ашиг (алдагдал) 2017 оноос 9.0 хувиар буурч 2018 оны эцэст 3.1 их наяд төгрөгт хүрчээ.

**Дүрслэл 1.45****Активын өгөөж**


Эх сурвалж: Сангийн яам.

2019 оны 4 дүгээр сарын эцэст санхүүгийн байгууллагуудаас авсан хувийн хэвшлийн зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар өсч, 8.2 их наяд төгрөгт хүрлээ.

Нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувийн хэвшлийн зээлийн хэмжээ 2010 оноос хойш буурсаар байгаа бөгөөд 2019 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар 40.3 хувьтай байна.

### Дүрслэл 1.46

#### Хувийн хэвшлийн зээл, зээлийн чанар



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн статистик нь 2019 оны 4 дүгээр сарын статистик болно.

Харин хувийн хэвшлийн чанаргүй зээл болон хувийн хэвшлийн нийт зээлийн харьцаа энэ оны 4 сарын байдлаар 20.1 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 6.5 нэгж хувиар эрс өсчээ.

Хувийн салбарын өрийн дарамтыг хувийн секторын дотоод зээл (арилжааны банкнуудаас авсан) ба гадаад өр төлбөрийн ДНБ-д эзлэх хувиар төлөөлүүлэн хэмжиж болно. 2005 оноос хойш гадаад өрийн дарамт хурдтай өссөөр байгаа бөгөөд 2016 оны 2 дугаар улиралд хувийн салбарын гадаад өр ДНБ-ий 70.7 хувь хувьд хүрч огцом өссөн юм.


Үүнд 2016 оны 2 дугаар улиралд томоохон компаниуд хөрөнгө оруулагчаас авсан зээлээ эргэн төлөх зорилгоор олон улсын банк,

санхүүгийн байгууллагуудаас зээл авсан болон төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларсан нь нөлөөлсөн. Харин 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар хувийн салбарын гадаад өр ба ДНБ-ий харьцаа 66.4 хувьд хүрээд байна.

Хувийн салбарын дотоод өр (санхүүгийн байгууллагуудаас авсан зээл) ба ДНБ-ий харьцаа сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байгаа бөгөөд 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар тус харьцаа 24.2 хувь байна.

### Дүрслэл 1.47

#### Хувийн салбарын өрийн дарамт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.


Тэмдэглэл: \*Хувийн секторын санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн өрийн үлдэгдэл ба нэрлэсэн ДНБ-ий харьцаа (жилийн ДНБ); \*\*Хувийн салбарын гадаад өрийг Монголбанкны гадаад өрийн статистик дахь бусад салбаруудын гадаад өрийн дүнгээр төлөөлүүлэн авсан (хадгаламжийн байгууллагын өрийг оруулаагүй болно).

## МӨНГӨ САНХҮҮГИЙН СЕКТОР

М2 мөнгөний нийлүүлэлт 2019 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар өсч 19.9 их наяд төгрөгт хүрчээ. Энэхүү өсөлтийн 17.7 нэгж хувийг бусад хадгаламжийн өсөлт, 4.9 нэгж хувийг М1 мөнгөний өсөлт тус тус бүрдүүлж байна.

## Дүрслэл 1.48

Мөнгөний үзүүлэлтүүд (жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын статистик болно.

М1 мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.9 хувиар буюу 800.1 тэрбум төгрөгөөр өсч, нийт мөнгөний нийлүүлэлтийн 18.4 хувь буюу 3.7 их наяд төгрөгтэй тэнцэж байна. М1 мөнгийг бүрдүүлж буй төгрөгийн харилцах өмнөх оны мөн үеэс 805.5 тэрбум төгрөгөөр өссөн бол хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 5.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

М2 мөнгийг байршуулалт талаас нь харвал дотоод цэвэр актив (ДЦА) М2 мөнгөний дийлэнх буюу 93 хувь, харин гадаад цэвэр актив (ГЦА) 7 хувийг тус тус бүрдүүлж байна. М2 мөнгөний өсөлтийн 17.3 нэгж хувийг ГЦА-ын өсөлт, үлдсэн 5.3 нэгж хувийг ДЦА-ын өсөлт тус тус тайлбарлаж байна. ГЦА-ын өсөлт нь Төв банкны гадаад цэвэр активын өсөлтөөр, харин ДЦА-ын өсөлт нь хадгаламжийн байгууллагын олгосон зээлийн өсөлтөөр тус тус тайлбарлагдаж байна.

## Дүрслэл 1.49

М2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын статистик болно.

2019 оны 4 дүгээр сарын байдлаар дотоод цэвэр авлагын жилийн өөрчлөлт 7.1 хувьтай байна. Үүний 11.4 нэгж хувийг иргэдийн зээл, 5.0 нэгж хувийг хувийн хэвшлийн зээл, 0.4 нэгж хувийг улсын байгууллагуудын зээлийн өсөлт, харин -9.1 нэгж хувийг Засгийн газрын зээл, -0.6 нэгж хувийг бусад санхүүгийн байгууллагуудын зээлийн бууралт тус тус бүрдүүлж байна.

## Дүрслэл 1.50

Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Монголбанк.

Гадаад валютын харилцах, хадгаламжийн М2 мөнгөнд эзлэх хувь хэмжээ 2016 оны эцсээс эхлэн буурах хандлагатай болсон. Тодруулбал, 2016 оны эцсийн байдлаар 34.7 хувь, 2017 оны

эцсээр 27.8 хувь, 2018 оны эцсийн байдлаар 27.2 хувь байсан бол, 2019 оны 4 дүгээр сард 26.4 хувьтай болжээ. Төгрөгийн харилцах, хадгаламж M2 мөнгөний 70.4 хувийг эзэлж байна.

### Дүрслэл 1.51

#### Мөнгөний нийлүүлэлт ба мөнгөний үржүүлэгч




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын статистик болно.

Мөнгөний үржүүлэгч<sup>11</sup> сүүлийн 4 жилийн дунджаар 4.2 нэгж байгаа бөгөөд 2019 оны 4 дүгээр сарын байдлаар 4.1 нэгжтэй тэнцүү байна.

### Дүрслэл 1.52

#### Банкнудын хадгаламж болон зээлийн хүү




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Ипотекийн зээлийн хүүг оруулж тооцсон. Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын статистик болно.

Инфляци зорилтот түвшинд хангагдаж, гадаад валютын нөөц нэмэгдэж, төгрөгийн ам.доллартай харьцах ханш харьцангуй тогтворжсон үед Монголбанкнаас эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор бодлогын хүүг шат дараатайгаар бууруулах арга хэмжээг 2017 оноос 2018 оны эцэс хүртэл авч хэрэгжүүлэв. Энэхүү бодлогын үр дүнд банкуудаас иргэд, компаниудад олгож буй зээлийн жигнэсэн дундаж хүү буурч, 2019 оны 4 дүгээр сарын байдлаар 17.5 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 нэгж хувиар буурсан байна.

### Дүрслэл 1.53

#### Банк хоорондын захын хүү




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2019 оны 4 дүгээр сарын статистик болно.

“Хүүний коридор” нэвтрүүлснээс хойш буюу 2013 оны 2 дугаар сараас 2016 оны 8 дугаар сар хүртэл хугацаанд богино хугацаат хэлцлийн хүүнүүд бодлогын хүүгээс +/-2 хувийн дотор хэлбэлзэж байсан. Гэвч 2016 онд хүүний коридорын дээд хязгаарыг бодлогын хүүгээс +3 нэгж хувь, доод хязгаарыг бодлогын хүүгээс -1 нэгж хувь болгон өөрчилсөн байна.

<sup>11</sup> Нөөц мөнгөний нэгж өсөлт нь хэдий хэмжээний нийт мөнгө (M2)-ний өсөлт бий болгосныг харуулах бөгөөд M2 мөнгө ба нөөц мөнгөний харьцаагаар тодорхойлогдоно.

**Дүрслэл 1.54****Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал\***

Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Хүүний жил бүр хэлбэлзэх интервалыг тухайн жилийн хамгийн их утгаас хамгийн бага утгыг хасч тооцов.

**УЛСЫН ТӨСӨВ****Нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл**

2019 оны 4 дүгээр сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 3506.7 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн хэмжээнээс 2.5 хувь буюу 85.4 тэрбум төгрөгөөр өссөн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 3132.0 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн хэмжээнээс 5.0 хувиар буюу 149.0 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

**Хүснэгт 1.7****Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг)**

| Нэгдсэн төсвийн орлого                       | Жилийн төлөвлөгөө | 2019 оны 4-р сар |       |        |
|----------------------------------------------|-------------------|------------------|-------|--------|
|                                              |                   | *                | **    | **/*   |
| Нийт орлого ба тусламжийн дүн                | 11 155            | 3 421            | 3 507 | 102.5% |
| Тогтворжуулалтын сан                         | 322               | 105.5            | 22    | 20.5%  |
| Ирээдүйн өв сан                              | 1 069             | 333              | 353   | 106.1% |
| Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн | 9 764             | 2983             | 3132  | 105.0% |
| I. Татварын орлого                           | 8 640             | 2 674            | 2858  | 106.9% |
| 1. Орлогын албан татвар                      | 2 080             | 731              | 809   | 110.6% |
| 1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар   | 1 240             | 486              | 564   | 116.0% |
| 1.2. Хувь хүний орлогын албан татвар         | 883               | 271              | 261   | 96.1%  |
| 2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж       | 1 689             | 519              | 608   | 117.1% |
| 3. Хөрөнгийн албан татвар                    | 140               | 50               | 42    | 84.0%  |
| 4. Нэмэгдсэн өртгийн албан татвар            | 2 321             | 598              | 600   | 100.4% |
| 5. Онцгой албан татвар                       | 838               | 265              | 277   | 104.7% |
| 6. Тусгай зориулалтын орлого                 | 12                | 5                | 5     | 102.8% |
| 7. Гадаад үйл ажиллагааны орлого             | 743               | 219              | 220   | 100.4% |
| 8. Бусад татвар, төлбөр, хураамж             | 816               | 287              | 297   | 103.4% |
| II. Татварын бус орлого                      | 1 125             | 309              | 274   | 88.8%  |
| 1. Нийтлэг татварын бус орлого               | 973               | 263              | 268   | 101.8% |
| 2. Хөрөнгийн орлого                          | 1                 | 0                | 0     | 194.6% |
| 3. Тусламжийн орлого                         | 150               | 45               | 5.7   | 12.6%  |

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*Төлөвлөгөө,

\*\*Урьдчилсан гүйцэтгэл.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого төлөвлөгөөнөөс ийнхүү давахад

Харин Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар бодлогын хүүний корридорын дээд хязгаар нь бодлогын хүүгээс +2 нэгж хувь, доод хязгаар нь -2 нэгж хувь дотор байхаар тэгш хэмтэйгээр буцаан тогтоосон байна.

2019 оны 4 дүгээр сарын байдлаар Монголбанкны бодлогын хүү 11.0 хувь, овернайт хүү 11.3 хувь, репо хүү мөн 11.1 хувь, банк хоорондын захын хүү 11.0 хувь, төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 11.0 хувь байна.

ААН-ийн орлогын албан татвар 77.9 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 88.8 тэрбум төгрөг, онцгой албан татвар 12.5 тэрбум төгрөгөөр тус тус давсан нь голлон нөлөөллөө.

Харин татварын бус орлого тайлант хугацаанд 88.8 хувийн гүйцэтгэлтэй буюу 34.5 тэрбум төгрөгөөр тасарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын өсөлтөд сөргөөр нөлөөлжээ.

**Хүснэгт 1.8****2019 оны эхний 4 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл, үндсэн бүрэлдэхүүнээр (тэрбум төгрөг)**

| Төсвийн орлого                               | УТ*  | ОНТ* | НДС* |
|----------------------------------------------|------|------|------|
| Нийт орлого ба тусламжийн дүн                | 2612 | 873  | 749  |
| Тогтворжуулалтын сан                         | 22   | 0    | 0    |
| Ирээдүйн өв сан                              | 353  | 0    | 0    |
| Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн | 2237 | 873  | 749  |
| I. Татварын орлого                           | 1911 | 339  | 547  |
| 1. Орлогын албан татвар                      | 564  | 244  | 0    |
| 1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар   | 564  | 0    | 0    |
| 1.2. Хувь хүний орлогын албан татвар         | 0    | 261  | 0    |
| 2. Нийгмийн даатгалын шимтгэл хураамж        | 0    | 0    | 547  |
| 3. Хөрөнгийн албан татвар                    | 0    | 42   | 0    |
| 4. Нэмэгдсэн өртгийн албан татвар            | 600  | 0    | 0    |
| 5. Онцгой албан татвар                       | 277  | 0    | 0    |
| 6. Тусгай үйл ажиллагааны орлого             | 5.4  | 0    | 0    |
| 5. Гадаад худалдааны орлого                  | 220  | 0    | 0    |
| 6. Бусад татвар                              | 244  | 53   | 0    |
| II. Татварын бус орлого                      | 326  | 534  | 202  |

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*УТ- Улсын төсөв, ОНТ- Орон нутгийн төсөв, НДС- Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан.



Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогод гадаад зах зээлийн нөлөөлөл харьцангуй их байдаг ба энэ нь төсвийн эмзэг байдалд шууд болон шууд бус байдлаар нөлөөлдөг.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 20 гаруй хувийг уул уурхайн салбарын орлого бүрдүүлдэг бөгөөд үүний дийлэнх хэсгийг зэс, нүүрс, алт зэрэг эрдэс бүтээгдэхүүнээс төвлөрүүлэх орлого эзэлдэг. Эдгээр гол эрдэс бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл нь төсвийн эмзэг байдалд нөлөөлж байна.

2019 оны төсвийн орлогын тооцоололд нэг тонн зэсийн үнийг 6272 ам.доллар байхаар тооцсон бол оны эхний 4 сарын гүйцэтгэлээр зэсийн үнэ тонн тутамд 6276 ам.долларт хүрсэн байна. Мөн баяжуулсан коксжих нүүрсний үнийг тонн тутамд 130 ам.доллар байхаар тооцсон бол оны эхний 4 сарын гүйцэтгэлээр БНХАУ-ын зах зээл дээрх баяжуулсан коксжих нүүрсний үнэ тонн тутамд 139 ам.долларт хүрээд байна.

### Улсын төсөв

Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2611.8 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн дүнгээс 1.5 хувиар буюу 39.7 тэрбум төгрөгөөр тасарчээ. Үүнд ААН-ийн орлогын албан татвар 77.9 тэрбум төгрөгөөр, онцгой албан татвар 12.5 тэрбум төгрөгөөр, ашигт

малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 10.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн хэдий ч, татварын бус орлого 85.7 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь нөлөөлжээ.

### Орон нутгийн төсөв

Орон нутгийн төсвийн орлого 873.0 тэрбум төгрөгт хүрч 3.2 хувиар буюу 28.9 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс дутуу төвлөрөв. Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлтийг орлогын ангиллаар авч үзвэл төлөвлөсөн дүнгээс татварын орлого 14.9 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 14.0 тэрбум төгрөгөөр тус тус тасарчээ.

### Нийгмийн даатгалын сангийн орлого

Нийгмийн даатгалын санд 748.9 тэрбум төгрөг төвлөрсний 547.1 тэрбум төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн орлого байгаа бол дотоод хандив тусламжийн орлогоор 201.8 тэрбум төгрөгийг бүрдүүлжээ. Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төлөвлөгөөнөөс 11.4 хувиар буюу 55.8 тэрбум төгрөгөөр илүү төвлөрчээ.

### Эрүүл мэндийн даатгалын сан

Эрүүл мэндийн даатгалын санд 162.8 тэрбум төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 20.7 хувиар буюу 27.9 тэрбум төгрөгөөр давж биелсэн үзүүлэлт боллоо.

## Төсвийн зарлагын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2019 оны 4 дүгээр сарын байдлаар 3708.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 2845.5 тэрбум төгрөгийн буюу 76.7 хувийн, улсын төсвийн зарлага 2732.2 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 2274.6 тэрбум төгрөгийн буюу 83.2 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Нэгдсэн төсвийн урсгал зардал 560.9 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 411.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Урсгал зардлын бараа үйлчилгээний зардлын

бүрэлдэхүүнд багтах цалин хөлс 37.9 тэрбум төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 316.8 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна. Бараа үйлчилгээний бусад зардлын дэлгэрэнгүй ангиллыг авч үзвэл бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 151.0 тэрбум, байр ашиглалттай холбоотой зардал 17.7 тэрбум төгрөг, норматив зардал 36.5 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь энэхүү дутуу гүйцэтгэлийн дийлэнх хувийг эзэлж байна.



**Хүснэгт 1.9****Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)**


| Нэгдсэн төсвийн зарлага           | Жилийн төлөвлөгөө | 2019 он 4-р сар |       |      |
|-----------------------------------|-------------------|-----------------|-------|------|
|                                   |                   | *               | **    | **/* |
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 12 058            | 3 708           | 2 845 | 77%  |
| Урсгал зардал                     | 8 496             | 3 039           | 2 478 | 82%  |
| 1. Бараа, үйлчилгээний зардал     | 4 135             | 1 508           | 1 154 | 77%  |
| 1.1. Цалин хөлс                   | 2 279             | 756             | 718   | 95%  |
| 1.2. Нийгмийн даатгал             | 0                 | 0               | 0     | 0%   |
| 1.3. Бараа, үйлчилгээний бусад    | 399               | 163             | 85    | 52%  |
| 2. Зээлийн үйлчилгээний төлбөр    | 866               | 286             | 250   | 87%  |
| 3. Татаас                         | 320               | 136             | 75    | 55%  |
| 4. Урсгал шилжүүлэг               | 3 176             | 1 108           | 999   | 90%  |
| Хөрөнгийн зардал                  | 3 404             | 724             | 313   | 43%  |
| Эргэж төлөгдөх цэвэр зээл         | 158               | -55             | 54    | -98% |
| Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл        | -2 294            | -725            | 287   | -40% |

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*Төлөвлөгөө,

\*\*Урьдчилсан гүйцэтгэл.

Бусад голлох зарлагын хувьд зээлийн үйлчилгээний төлбөр 36.5 тэрбум төгрөг, татаас 60.8 тэрбум төгрөг, урсгал шилжүүлэг 109.0 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна.

**Дүрслэл 1.55****Нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн жилийн өөрчлөлт**

Эх сурвалж: Сангийн яам.


Тэмдэглэл: 2019 оны эхний 4 сарын орлого, зарлагын гүйцэтгэлийн жилийн өөрчлөлт болно.

**Улсын болон орон нутгийн төсвийн зарлага**

Улсын төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүн 2274.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгийн 83.2 хувьтай тэнцүү гарлаа. Харин орон нутгийн төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүн 696.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 62.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Төсвийн тэнцэл**

2019 оны эхний 4 сард гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 135.6 тэрбум төгрөг, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 38.2 тэрбум төгрөг тус тус төлж, 376.7 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл авсан байна. Тайлант хугацаанд Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцэл 661.2 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 286.5 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

**Дүрслэл 1.56****Нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэл (жил бүрийн эхний 4 сарын байдлаар, тэрбум төгрөг)**


Эх сурвалж: Сангийн яам.

## Шигтгээ 2: Монгол Улсын Засгийн газрын гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өр 2018 оны жилийн эцсийн байдлаар 28.7 тэрбум ам.доллартай тэнцэж байгаа бөгөөд үүний 25 хувийг Засгийн газрын гадаад өр, 32 хувийг өр үүсгэх нөхцөлтэй гадаадын шууд хөрөнгө оруулалт, 7 хувийг Төв банкны өр, 8 хувийг хадгаламжийн байгууллагын өр, 28 хувийг бусад салбаруудын гадаад өр тус тус бүрдүүлж байна.

### Дүрслэл 1.57

Монгол Улсын гадаад өрийн бүтэц



Эх сурвалж: Сангийн яам.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан “Засгийн газрын өр”-ийн тодорхойлолтын хүрээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдэл 20,212 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 72.5 хувьтай тэнцэж байсан бол 2018 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оноос 1,257 тэрбум төгрөгөөр буурч 18,955 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 56.6 хувьтай тэнцэж байна.

### Гадаад үнэт цаас

Монгол Улсын Засгийн газрын зүгээс дэлхийн санхүүгийн зах зээл дээр анх 2012 онд 1.5 тэрбум ам.долларын Чингис бондыг арилжаалсан бол 2015 онд 161.2 сая ам.долларын ДимСам бонд, 2016 онд 500 сая ам.долларын Мазаалай бонд, 2017 онд 600 сая ам.долларын Хуралдай бонд, 2018 онд 800 сая ам.долларын Гэрэгэ бондуудыг тус тус арилжаалж, нийт 2,061.2 сая ам.долларын эх үүсвэрийг босгосон байна. Үүнээс Чингис, ДимСам, Мазаалай бондуудыг төсөл, хөтөлбөр болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан бол Хуралдай, Гэрэгэ бондуудыг гадаад бондын дахин санхүүжилт хийх зорилгоор арилжаалсан юм. Гадаад үнэт цаасны өрийн үйлчилгээний төлбөрт 2016-2018 онд нийт 1,386 сая ам.доллар /үүнээс үндсэн төлбөрт 660.3 сая ам.доллар, хүүгийн төлбөрт 725.7 сая ам.доллар/-ыг төлсөн байна.

### Гадаад зээл

Монгол Улсын Засгийн газар 2016-2018 онд олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудаас төсвийн зээлийн хүрээнд 1,106.3 сая ам.доллар, хөтөлбөрийн зээлийн хүрээнд 796 сая ам.доллар, арилжааны нөхцөлтэй 240 сая ам.доллар нийт 2,142.2 сая ам.доллар буюу 5,070.8 тэрбум төгрөгийг авч ашигласан байна.

### Засгийн газрын өрийн баталгаа

Монгол Улсын Засгийн газар 2012 оноос хойш нийт 11 зээллэгт баталгаа гаргасан бөгөөд Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 1.1 их наяд төгрөгт хүрч буураад байна. ХХБ-ны олон улсын зах зээл дээр гаргасан 500 сая ам.долларын үнэт цаасанд 2015 онд Засгийн газрын дотоод үнэт цаасыг барьцаалан Засгийн газрын баталгаа гаргасан байна. Харин 2016 оны 6 дугаар сараас хойш шинээр өрийн баталгаа нэмж гаргаагүй байна.

### Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн шинжилгээ

Зардал, эрсдэлийн шинжилгээний цар хүрээ нь өрийн удирдлагатай холбоотой бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоог тодотгон харуулах чухал ач холбогдолтой байдаг. Зардал эрсдэлийн үзүүлэлтүүдийн 2018 оны жилийн эцсийн байдлаарх үр дүнг Хүснэгт 1.10-т харууллаа.

#### Хүснэгт 1.10

##### Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд

| Эрсдэлийн үзүүлэлт         |                                                    | Гадаад зээл | Дотоод зээл | Нийт зээл |
|----------------------------|----------------------------------------------------|-------------|-------------|-----------|
| Өрийн багцын зардал        | Хүүгийн төлбөрийн ДНБ-д эзлэх хувь                 | 2.3         | 0.6         | 2.9       |
|                            | Жигнэсэн дундаж хүү                                | 3.6         | 12.2        | 4.3       |
| Дахин санхүүжилтийн зардал | АТМ (жил) эргэн төлөгдөх дундаж хугацаа            | 8.4         | 5.0         | 8.2       |
|                            | Богино хугацаанд төлөгдөх өр /нийт өрд эзлэх хувь/ | 2.2         | 10.6        | 2.7       |
|                            | Богино хугацаанд төлөгдөх өр /ДНБ-д эзлэх хувь/    | 1.7         | 0.5         | 2.2       |
| Хүүгийн түвшний эрсдэл     | АТР (жил) хүү шинэчлэгдэх дундаж хугацаа           | 7.7         | 5.0         | 7.6       |
|                            | 1 жилд тогтмолжуулах өр /нийт өрд эзлэх хувь/      | 13.0        | 10.6        | 12.8      |
|                            | Тогтмол хүүтэй зээл ба бонд /нийт өрд эзлэх хувь/  | 88.3        | 100.0       | 89.0      |
| Ханшийн эрсдэл             | Гадаад валютуарх өр /нийт өрд эзлэх хувь/          |             |             | 92.7      |
|                            | Валютын нөөцөд эзлэх богино хугацаат өр төлбөр     |             |             | 5.9       |

Эх сурвалж: Сангийн яам.

### Өрийн багцын зардал


2018 оны жилийн эцсийн байдлаар өрийн багцын зардал ДНБ-ий 2.9 хувьтай тэнцэж байна. Задалж харвал Засгийн газрын гадаад өрийн зардал ДНБ-ий 2.3 хувь, харин дотоод өрийн зардал 0.6 хувь байна. Жигнэсэн дундаж хүүгийн хувь хэмжээ 2018 оны жилийн эцсийн байдлаар 4.3 хувьтай байна. Үүнээс гадаад өрийн жигнэсэн дундаж хүү 3.6 хувь, дотоод өрийн жигнэсэн дундаж хүү 12.2 хувь байна.

### Өрийн багцын эрсдэл-Дахин санхүүжилтийн эрсдэл

2018 оны жилийн эцсийн байдлаар дахин санхүүжилтийн эрсдэл харьцангуй бага түвшинд буюу нийт багцын хүрээнд эргэн төлөлтийн дундаж хугацаа (АТМ) 8.2 жил байна. 2021-2024 онд томоохон бондуудын эргэн төлөгдөх хугацаа дуусч дахин санхүүжилтийн эрсдэл нэмэгдэхээр байна. 2021 онд Мазаалай 500 сая ам.доллар, 2022 онд Чингис 1,000 сая ам.долларын үнэт цаасыг эргэн төлөх бол 2023-2024 онд Гэрэгэ, Хуралдай төслүүдийн хүрээнд арилжаалсан 1400 сая ам.долларыг хөрөнгө оруулагчдад эргэн төлнө.


Дүрслэл 1.58

Засгийн газрын нийт төлбөр, сая ам.доллар



Дүрслэл 1.59

Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөр, сая ам.доллар



Эх сурвалж: Сангийн яам.

### Өрийн багцын эрсдэл-Хүүгийн түвшний эрсдэл

Өрийн багц дахь хүү тогтмолжуулах дундаж хугацаа (АТР) 7.6 жил байна. Үүнээс гадаад өрийн хүү тогтмолжуулах дундаж хугацаа 7.7 жил байгаа бол дотоод өрийн хувьд 5 жил байна. Засгийн газраас 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулж, арилжааны нөхцөлтэй дотоод үнэт цаасны хэмжээг бууруулах ажлын хүрээнд дотоод үнэт цаасны арилжааг тодорхойгүй хугацаагаар зогсоож, 2018-2020 онд төлөгдөх нөхцөлтэй байсан өндөр хүүтэй нийт 370.5 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 2017 оны 11-12 дугаар сард хугацаанаас нь өмнө буцаан худалдан авснаар өрийн багцад эзлэх богино хугацаат дотоод үнэт цаасны эзлэх хувь эрс багассан нь нийт өрийн багцын хэмжээнд хүү тогтмолжуулах дундаж хугацаа нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн юм.

### Өрийн багцын эрсдэл-Валютын ханшийн эрсдэл

Засгийн газрын зүгээс дотоод үнэт цаасны арилжааг зогсоосон, зарим дотоод үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах замаар дотоод үнэт цаасны хэмжээг бууруулснаар гадаад валютаар илэрхийлэгдэх өрийн нийт өрд эзлэх хувь хэмжээ 2018 онд 92.7 хувьд хүрч 2016 оноос 15.9 нэгж хувиар өссөн. Өрийн багцыг валютын бүтцээр харвал Засгийн газрын өрийн 63 хувь нь ам.доллар, 17 хувь нь Зээлжих тусгай эрх, 15 хувь нь иен, 2 хувь нь бусад валютаас бүрдэж байна.

**Засгийн газрын 2019-2022 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичиг**

Сангийн яамнаас Өрийн удирдлагын тухай хуулийн 14.2-т заасны дагуу Засгийн газрын 2019-2022 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн төслийг боловсруулж, улмаар 2019 оны 6 дугаар сард УИХ-ын хуралдаанаар баталсан байна. Холбогдох стратегид дараах онцлох арга хэмжээнүүдийг тусгасан байна. Үүнд:

- Төсвийн сахилга батыг сайжруулах, санхүү мөнгөн хөрөнгийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлэх бодлогыг тууштай үргэлжлүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулж, шинээр зээллэг үүсгэх хэрэгцээг бууруулна.
- Гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал эрсдэлийн судалгааг тогтмол хийж, гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлж барагдуулах, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх арга хэмжээг авна.
- Дахин санхүүжилт хийхээс өөрөөр арилжааны нөхцөлтэй гадаад үнэт цаас гаргахаас татгалзана. Өрийн дахин санхүүжилтэд урт хугацаанд жигд төлөгдөх эх үүсвэрийг олж ашиглахыг эрмэлзэнэ.
- Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтэт технологийн ашигласан систем нэвтрүүлнэ.
- Олон Улсын санхүүгийн байгууллагуудаас санал болгож буй болзошгүй эрсдэлээс сэргийлэх зээлийн шугамыг ашиглах механизмыг нэвтрүүлнэ.
- Барих-шилжүүлэх концессын гэрээ байгуулах, вексель бичих зэрэг өрийн хэрэгслээр өр үүсгэхгүй байх бодлогыг баримтална.

## САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА

### 2.1 БАНКНЫ САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ


#### БАНКНЫ САЛБАР

##### Ерөнхий төлөв байдал

Банкны салбарт 2019 оны 4 дүгээр сарын байдлаар нийт 13 банк, 1425 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Давхардсан тоогоор нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 3.2 сая, зээлдэгчдийн тоо 1.3 саяд тус тус хүрлээ.

##### Дүрслэл 2.1

Банкны салбарын активын бүтэц (жил бүрийн 4 сарын байдлаар)



Эх сурвалж: Монголбанк.


Банкны салбарын нийт активын хэмжээ 2019 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 4.7 их наяд төгрөгөөр өсч 33.5 их наяд төгрөг (ДНБ-ий 104.2 хувь)-т хүрэв. Нийт активын бүтцийг авч үзвэл 48.4 хувь нь зээл, 22.2 хувь нь мөнгөн хөрөнгө, 12.9 хувь нь Төв банкны үнэт цаас, 4.3 хувь нь Засгийн газрын үнэт цаас, үлдэх 12.2 хувь нь бусад хөрөнгө тус тус байна.

Банкны салбарын активын бүтцийн гол өөрчлөлтүүдийг харвал сүүлийн 2 жилд эдийн засгийн нөхцөл байдал сайжирч банкуудын зээл олголт эргэн сэргэсэнээр нийт активт

ээлэх зээлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 1.8 нэгж хувиар өссөн байна. Засгийн газраас өрийг шат дараатайгаар бууруулах зорилт тавьж, энэ хүрээнд шинээр Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ) гаргаагүй бөгөөд өмнө гаргасан ЗГҮЦ-ны эргэн төлөлт хуваарийн дагуу хийгдсэнээр банкуудын тайлан тэнцэл дэх ЗГҮЦ-ны хэмжээ буурч 1.4 их наяд төгрөгт хүрчээ.

##### Дүрслэл 2.2

Банкны салбарын пассивын бүтэц (жил бүрийн 4 сарын байдлаар)



Эх сурвалж: Монголбанк.

Банкуудын тайлан тэнцэл дэх Төв банкны үнэт цаасны үлдэгдэл 2017 оны эцсээс эрчимтэй өссөөр тайлант сарын эцэст 4.3 их наяд төгрөгт хүрч, банкны салбарын активын 12.9 хувийг бүрдүүлж байна.

##### Эх үүсвэр


Банкны салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ 2019 оны 4 дүгээр сарын эцэст 29.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.0 хувиар өсжээ. Эх үүсвэрийн өсөлтөд банкуудын татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн хэмжээ 19.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны



мөн үеэс 3.7 их наяд төгрөгөөр буюу 22.6 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

### Дүрслэл 2.3

Банкны салбарын актив, пассивт гарсан өөрчлөлт (2018.04-2019.04)




Эх сурвалж: Монголбанк.

Банкны салбарын эх үүсвэрийн 66.9 хувийг иргэд аж ахуй нэгж, төрийн байгууллагуудаас татсан харилцах, хадгаламж, 20.1 хувийг банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, үлдэх 13.0 хувийг төслийн санхүүжилт, банкнаас гаргасан үнэт цаас зэрэг бусад төрлийн эх үүсвэрүүд тус тус бүрдүүлж байна. Банкны салбарын харилцах, хадгаламж тогтмол нэмэгдсэн, мөн нийт эх үүсвэрийн 20 орчим хувийг бүрдүүлдэг гадаад эх үүсвэр тогтвортой түвшинд байгаа нь харилцагчид, хөрөнгө оруулагчдын банкны салбарт итгэх итгэл хэвээр байгааг харуулж байна.

### Дүрслэл 2.4

Банкны салбарын эх үүсвэрийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк.


2019 оны 4 дүгээр сарын байдлаар банкны салбарын нийт харилцах, хадгаламжийн 77.2 хувийг төгрөгийн, 22.8 хувийг валютын харилцах, хадгаламж бүрдүүлж байна.

### Зээл

Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн, санхүүгийн зах зээлийн нөхцөл чангарсан, эдийн засгийн идэвхжил удааширснаар банкууд шинээр зээл олгох нь эрсдэлтэй гэж үзэн зээлээ хумьснаар санхүүгийн салбарын зээлийн багцын дийлэнх хувийг бүрдүүлдэг банкны салбарын зээлийн өсөлт 2014 оны 2 дугаар сараас буурч эхэлсэн юм.

### Дүрслэл 2.5

Банкны салбарын актив, зээлийн жилийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк.

Улмаар 2015 оны 5 дугаар сараас 2016 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд банкны салбарын зээлийн жилийн өөрчлөлт сөрөг утгатай байсан бол 2016 оны 6 дугаар сараас

эхлэн өсч, 2019 оны 4 дүгээр сарын байдлаар 21.1 хувьд хүрээд байна.

### Дүрслэл 2.6

#### Олгосон зээлийн жилийн өсөлт (салбараар)




Эх сурвалж: Монголбанк.

Нийт зээлийг салбарын ангиллаар авч үзвэл 2019 оны эхний 4 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад боловсруулах үйлдвэрлэлийн салбарын зээл 2 орчим хувиар буурсан бол бусад салбарын зээл өссөн байна. Тухайлбал, барилга, бөөний болон жижиглэн худалдааны салбарт шинээр олгосон зээлийн хэмжээ хамгийн өндөр өсөлттэй буюу харгалзан 60 хувь, 34 хувь байна.

2019 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдлийн 50.8 хувь нь уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилга, үл хөдлөх хөрөнгө, худалдаа зэрэг 5 салбарт төвлөрч байна. Эдгээр салбарын зээлийн хэмжээ харьцангуй өндөр байгаа нь нэг талаас уг салбаруудад олгосон зээлийн эргэн төлөлт сайн, нөгөө талаас зээлийн эрэлт хэрэгцээ өндөр байгаагаас нь шалтгаалж байна.

### Дүрслэл 2.7

#### Салбаруудын зээлийн төвлөрөл



| Голлох салбарууд         | Зээлийн өрийн үлдэгдэл (2019M4) | Өмнөх оны мөн үеэс гарсан өөрчлөлт |
|--------------------------|---------------------------------|------------------------------------|
| Бөөний/жижиглэн худалдаа | 15.1%                           | 0.6%                               |
| Үл хөдлөх хөрөнгө        | 11.1%                           | -1.9%                              |
| Барилга                  | 8.6%                            | -0.1%                              |
| Уул уурхай, олборлолт    | 7.7%                            | -0.1%                              |
| Боловсруулах үйлдвэрлэл  | 8.4%                            | -1.6%                              |
| Бусад                    | 49.2%                           | 3.2%                               |


Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Зээлийн багцад хамгийн өндөр жин эзэлж буй 4 салбарын зээлийн нийт дүнд эзлэх хувь.

Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ 2019 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар 1.6 их наяд төгрөгт хүрч, нийт зээлийн 9.1 хувийг эзэлж байгаа бол анхаарал хандуулах зээлийн хэмжээ 1.2 их наяд төгрөгт хүрч, нийт зээлийн 7.0 хувийг бүрдүүлж байна.

### Дүрслэл 2.8

#### Зээлийн чанарын үзүүлэлт, салбараар



| Голлох салбарууд               | Тухайн салбарын чанаргүй зээл/Нийт чанаргүй зээл (2019M4) |
|--------------------------------|-----------------------------------------------------------|
| Уул уурхай, олборлолт          | 22.4%                                                     |
| Бөөний болон жижиглэн худалдаа | 7.4%                                                      |
| Боловсруулах үйлдвэрлэл        | 21.8%                                                     |
| Барилга                        | 15.2%                                                     |
| Үл хөдлөх хөрөнгө              | 8.3%                                                      |


Эх сурвалж: Монголбанк.

2019 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 49.7 хувиар, анхаарал хандуулах зээлийн хэмжээ 25.5 хувиар тус тус өсчээ.

Банкны салбарт чанаргүй зээл үргэлжлэн нэмэгдэж байгаа нь уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэл зэрэг эдийн засгийн голлох салбаруудад сэргэлт удаан явагдаж байгаатай холбоотой юм. Уул уурхайн салбарт 434.9 тэрбум төгрөг, барилгын салбарт 296.2 тэрбум төгрөг, боловсруулах салбарт 424.3 тэрбум төгрөгийн чанаргүй зээл хуримтлагдсан нь нийлбэр дүнгээр банкны салбарын чанаргүй зээлийн 59.4 хувийг дангаараа бүрдүүлж байна.

### Дүрслэл 2.9

Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк.


Чанаргүй зээлийг зээлдэгчдээр нь ангилан авч үзвэл аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлт иргэдэд олгосон зээлтэй харьцуулахад муу байна. Тухайлбал, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн 15.9 хувь нь чанаргүй болж, нийт чанаргүй зээлийн 84.3 хувийг бүрдүүлж байна. Харин иргэдэд олгосон нийт зээлийн 2.8 хувь нь чанаргүй, 2.0 хувь нь хугацаа хэтэрсэн ангилалд багтаж байна.

Зээлийн чанарыг олгосон валютын төрлөөр нь харьцуулж үзвэл гадаад валютаар олгосон зээлийн чанар төгрөгөөр олгосон зээлтэй харьцуулахад муу байна. 2019 оны 4 дүгээр

сарын эцсийн байдлаар төгрөгийн чанаргүй зээлийн нийт төгрөгийн зээлд эзлэх хувь 8.3 хувь байхад валютын чанаргүй зээлийн нийт валютын зээлд эзлэх хувь 13.3 хувь буюу 5.0 нэгж хувиар өндөр байна.

### Дүрслэл 2.10

Чанаргүй зээлийн харьцаа (валютын төрлөөр)



Эх сурвалж: Монголбанк.


### Өөрийн хөрөнгө

Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн “Активын чанарын үнэлгээ”-ний үр дүнд үндэслэн банкууд эрсдэл даах чадвараа сайжруулах чиглэлд хүчин чармайлт гарган өөрийн хөрөнгөө 535.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд энэ нь банкны салбарт тогтвортой байдал хадгалагдахад чухал нөлөө үзүүлээ. 2019 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар банкны салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ 3.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 13.0 хувиар буюу 427.9 тэрбум төгрөгөөр өслөө.

Банкны салбарын эрсдэл даах чадварыг харуулдаг I зэрэглэлийн өөрийн хөрөнгө ба эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 2019 оны 4 дүгээр сарын байдлаар 14.3 хувь, нийт өөрийн хөрөнгө ба эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 17.3 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдээс тус бүр 5.3 нэгж хувиар өндөр байна.

### Дүрслэл 2.11

#### Өөрийн хөрөнгийн хүрэлцээ



Эх сурвалж: Монголбанк.


Капитал банкны нийт зээлийн багцын 81.2 хувь нь чанаргүйдэж, хадгаламж эзэмшигч, харилцагчдын мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар гарган өгөх чадваргүй болж, банкны заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангахгүй, хэвийн үйл ажиллагаа эрхлэх чадваргүй болсон тул Монголбанкнаас 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр тус банкныг албадан татан буулгах шийдвэр гаргаж, үйл ажиллагааг зогсоолоо. Капитал банк нь активын хэмжээгээр банкны системийн 1.1 хувийг бүрдүүлдэг, системийн нөлөө бүхий банк биш тул тус банкныг татан буулгаснаар банкны салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзэж байна.

#### Ашигт ажиллагаа

2019 оны эхний 4 сарын байдлаар банкны салбарын нийт ашиг 75.9 тэрбум төгрөгт хүрлээ. Чанаргүй зээлд байгуулсан зээлийн эрсдэлийн сангийн зардал нэмэгдсэн хэдий ч банкуудын зээл олголт эрчимжиж байгаатай холбоотойгоор банкуудын орлого нэмэгдэж, ашигт ажиллагаа эргэн сэргэлээ.

### Дүрслэл 2.12

#### Банкны салбарын ашигт ажиллагаа



Эх сурвалж: Монголбанк.

Ашигт ажиллагааны үзүүлэлт болох өөрийн хөрөнгийн болон активын өгөөж 2019 оны 4 дүгээр сард харгалзан 6.7 хувь, 0.7 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5, 4.4 нэгж хувиар тус тус өссөн дүнтэй байна.


#### Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь банкны системийн тогтвортой байдлыг илтгэдэг үндсэн үзүүлэлтүүдийн нэг бөгөөд харилцагчийн анхны шаардлагаар төлбөрийг түргэн гүйцэтгэх чадварыг илэрхийлдэг.

2019 оны 4 дүгээр сарын байдлаар банкны системийн хэмжээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 42.0 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар буурсан хэдий ч Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны доод хязгаарлалт (25 хувь)-аас 17.0 нэгж хувиар өндөр байна. Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа өндөр хэвээр хадгалагдахад банкууд татан төвлөрүүлсэн эх үүсвэрээ хөрвөх чадвар өндөр, эрсдэл багатай Төв банкны болон Засгийн газрын богино хугацаат үнэт цаасанд хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулсан нь голлон нөлөөлж байна. Түүнчлэн банкуудын нийт гадаад валютын позицод тавигддаг зохистой харьцааны үзүүлэлт 8.6 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон хязгаарлалт (+/-40.0 хувь) дотор байна.

Дүрслэл 2.13

Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар




Эх сурвалж: Монголбанк.

2019 оны 4 дүгээр сарын байдлаар банкуудын Төв банкны болон Засгийн газрын богино хугацаат үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 5.8 их наяд төгрөгт хүрч тогтвортой түвшинд хадгалагдсан хэвээр байна.

Дүрслэл 2.14

Хөрвөх чадварын үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \* (Банкны нөөц+ТБҮЦ)/(Харилцах+Хадгаламж).  
 \*\* (Банкны нөөц+ТБҮЦ+ЗГ-ын богино хугацаатай үнэт цаас)/(Харилцах+Хадгаламж).

### Шигтгээ 3: Банкуудын эрсдэлийн хүлээлтийн судалгаа

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд “Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах бөгөөд уг зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ” гэж заасан байдаг. Иймд Монголбанк нь банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангахтай холбогдуулан банк, санхүүгийн системд тулгарч буй эрсдэлийг тухай бүр тодорхойлж, үнэлж, эрсдэлийг бууруулах чиглэлд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх, үүрэгтэй байна.


2019 оны эхний хагас жилд Монголбанкнаас судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эм Эм Си Жи” ХХК-тай хамтран санхүүгийн системийн эрсдэлийг эрт үед нь илрүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлд цаашид авч хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын арга хэмжээг тодорхойлоход чухал ач холбогдолтой “Монгол Улсын арилжааны банкуудын эрсдэлийн хүлээлтийн судалгаа”-г хоёр дахь жилдээ зохион байгууллаа. Судалгааг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 14 банкны<sup>1</sup> эрсдэлийн удирдлагын газар, хэлтсийн захирлуудаас асуулга хэлбэрээр авсан. Судалгааны асуулгад тухайн банк болон нийт банкны салбарт түгээмэл учирдаг, голлох эрсдэлүүдийн (зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, хууль, дүрэм журам мөрдөх үйл ажиллагаатай холбоотой, байгууллагын нэр хүндэд тулгарах, стратеги төлөвлөгөөний биелэлттэй холбоотой, макро эдийн засгийн болон гадаад эрсдэл) түвшинг тодорхойлох, үнэлэх зорилготой тус бүр нь 1-5 оноогоор<sup>2</sup> үнэлэгдэх хариулт бүхий 40 хаалттай асуултууд багтсан болно.

<sup>1</sup> Тус судалгааг Капитал банкныг татан буугдахаас өмнө зохион байгуулсан болно.

<sup>2</sup> 1 оноо нь банк болон банкны салбарт учрах тухайн эрсдэлийн түвшин ихээхэн нэмэгдэх, 2 оноо нь бага зэрэг нэмэгдэх, 3 оноо нь өөрчлөгдөхгүй, 4 оноо нь бага зэрэг буурах, 5 оноо нь ихээхэн буурах хүлээлттэй байгааг илэрхийлнэ.


Дүрслэл 1.15

Банкуудын эрсдэлийн хүлээлтийн түвшин (2018, эрсдэлийн бүлгүүдээр)



Дүрслэл 1.16

Банкуудын эрсдэлийн хүлээлтийн түвшин (2019, эрсдэлийн бүлгүүдээр)



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Тэмдэглэл: Тойргийн төвөөс холдох тусам эрсдэлийн түвшин буурах хүлээлттэй байгааг илтгэнэ. Тухайн эрсдэлийн бүлэгт багтах асуултуудын хариулт оноонуудын энгийн дунджаар тухайн эрсдэлийн бүлэгт харгалзах оноог тооцсон болно.

Банкуудыг нийт активын хэмжээнээс нь хамааруулан том, дунд, жижиг гэсэн 3 бүлэгт хуваасан бөгөөд банкууд өөрсдийн болон нийт банкны салбарт тулгарах эрсдэлүүдийн талаар 2018 болон 2019 онд өгсөн үнэлгээ (оноо)-г эрсдэлийн төрлүүдээр дундажлан тооцож Дүрслэл 1.15-1.16-д харууллаа.

2018 оны хүлээлттэй (2018 онд хийгдсэн судалгааны үр дүнтэй) харьцуулахад судалгаанд оролцогчид 2019 онд банкны салбарын хувьд хөрвөх чадварын эрсдэл, дүрэм журам мөрдөх болон хууль эрх зүйн эрсдэл бага зэрэг буурна, харин байгууллагын нэр хүндэд тулгарах эрсдэл, зах зээлийн эрсдэл дунджаар бага зэрэг өснө гэж хүлээж байна.

Судалгааны үр дүнгээс харахад банкууд нийт банкны салбарт учрах байгууллагын нэр хүндэд тулгарахаас бусад өмнө дурдсан эрсдэлүүдийг 2019 онд дунджаар буурах эсвэл өөрчлөгдөхгүй гэж хүлээж байна. Банкны бүлгүүдээр авч үзвэл том банкуудын хувьд байгууллагын нэр хүндэд тулгарах эрсдэл болон зах зээлийн эрсдэлүүдийг 2019 онд дунджаар бага зэрэг өснө гэж үзжээ. Харин банкны бүх бүлгүүд бусад эрсдэлүүдийг 2019 онд дунджаар буурна эсвэл өөрчлөгдөхгүй гэж хүлээж байгаа үр дүн гарсан. Түүнчлэн банкууд ирээдүйд болох эрсдэлийг даван туулах бэлтгэл өөрийн банкны хувьд болон нийт банкны салбарын хэмжээнд сайн байгаа гэж үзсэн байна.

Судалгааны асуулгад хамгийн их болгоомжилж буй 3 эрсдэлийг банкуудаас асуусан бөгөөд банкууд зээлийн эрсдэл, макро эдийн засгийн эрсдэл болон дүрэм журам дагаж мөрдөхтэй холбоотой эрсдэлийг өнөөгийн байдлаар хамгийн том эрсдэл гэж тодорхойлжээ (Хүснэгт 2.1).



**Хүснэгт 2.1****Банкуудын эрсдэлийн хүлээлтийн түвшин (эрсдэлийн бүлгүүдээр)**

| № | Эрсдэлийн төрлүүд                              | Нийт | Том банкууд | Дундаж банкууд | Жижиг банкууд |
|---|------------------------------------------------|------|-------------|----------------|---------------|
| 1 | Зээлийн эрсдэл                                 | 93%  | 100%        | 67%            | 100%          |
| 2 | Макро эдийн засгийн эрсдэл                     | 64%  | 100%        | 67%            | 50%           |
| 3 | Дүрэм журам мөрдөх болон хууль эрх зүйн эрсдэл | 43%  | 100%        | 33%            | 25%           |
| 4 | Зах зээлийн эрсдэл (хүү, ханш)                 | 36%  | 0%          | 67%            | 38%           |
| 5 | Байгууллагын нэр хүндэд тулгарах эрсдэл        | 36%  | 0%          | 33%            | 50%           |
| 6 | Хөрвөх чадварын эрсдэл                         | 14%  | 0%          | 33%            | 13%           |
| 7 | Гадаад эрсдэл                                  | 14%  | 0%          | 0%             | 25%           |
| 8 | Стратегийн эрсдэл                              | 0%   | 0%          | 0%             | 0%            |

Эх сурвалж: Асуулгын үр дүн

Тэмдэглэл: Нийт судалгаанд оролцогчдын 93 хувь нь хамгийн их болгоомжилж буй 3 эрсдэлийн нэгээр зээлийн эрсдэлийг сонгосон гэсэн үг юм.

**МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Монголбанк нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж байна. Тухайлбал, иргэдийн хэрэглээний зээлийн өсөлтийг сааруулж, өрхийн өрийн дарамтыг хязгаарлах, улмаар банкны системд эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх зорилготой иргэдийн хэрэглээний зээлд Өр-орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоох, ипотекийн бус иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байх макро зохистой бодлогын арга хэмжээнүүд 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнээр 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар шинээр олгосон хэрэглээний зээлийн дундаж хугацаа 23 сар болж, 2018 оны эцэст 55 хувьд хүрээд байсан хэрэглээний зээлийн өсөлт 37 хувьд хүрч саарлаа.

Мөнгөний бодлогын хорооноос эдийн засгийн идэвхжил, цалингийн өсөлтийг харгалзан тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 60 хувиар шинэчлэн тогтоож, 2019

оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр шийдвэрлэлээ.

Гадаад валютын орлогогүй иргэн, ААН-д гадаад валютаар зээл олгох сэдлийг багасгах, улмаар зээлийн долларжилтыг бууруулах зорилгоор ханшийн эрсдэлтэй зээлдэгчдэд олгосон гадаад валютын зээлийн эрсдэлийн жинг 120 хувиас 150 хувь болгон нэмэгдүүлж, 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлснээр 2019 оны 1 дүгээр улиралд валютын зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 6.3 нэгж хувиар буурч 15 хувьд хүрээд байна. Үүнийг эдийн засгийн гол салбаруудаар задлан харвал, уул уурхайн салбар 55 хувиас 30 хувь, барилгын салбар 27 хувиас 19 хувь, худалдааны салбар 45 хувиас 28 хувь болж тус тус буурсан байна.

Хэрэглээний зээлийн хувьд авч хэрэгжүүлж буй макро зохистой бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор Монголбанк нь банкуудаас сар бүр “Өр, орлогын харьцаагаар ангилсан иргэдийн хэрэглээний зээлийн сарын мэдээ”-г авч нягтлан үзэхээс гадна газар дээрх хяналт шалгалтыг гүйцэтгэж байна.



## ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛ

### Ерөнхий төлөв байдал

Хадгаламжийн даатгалын тогтолцоо нь олон улсад шалгарсан, түгээмэл хэрэглэж байгаа даатгалын тогтолцоо бөгөөд банк, санхүүгийн салбарыг системийн хямралаас тодорхой хэмжээгээр сэргийлэх, жижиг хэмжээний хадгаламж эзэмшигчдийг хамгаалахад чиглэгддэг.

УИХ-аас 2013 онд банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоох зорилгоор “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийг баталсан бөгөөд 2018 онд тус хуулинд нэмэлт өөрчлөлт оруулаад байна.

### Хүснэгт 2.2

Нийт харилцах, хадгаламжийн даатгагдсан байдал

|                       | Данс эзэмшигчид |               | Дансны үлдэгдэл |               |
|-----------------------|-----------------|---------------|-----------------|---------------|
|                       | Мян.ш           | Хувь          | Тэрбум төг      | Хувь          |
| Даатгалд хамрагдсан   | 5 875           | 99.8%         | 5 165           | 23.0%         |
| Даатгалд хамрагдаагүй | 11              | 0.2%          | 17 114          | 77.0%         |
| <b>Нийт</b>           | <b>5 886</b>    | <b>100.0%</b> | <b>22 279</b>   | <b>100.0%</b> |

Эх сурвалж: Хадгаламжийн даатгалын корпораци.


2019 оны 4 дүгээр сарын байдлаар банкны систем дэх нийт 5.9 сая харилцах, хадгаламжийн данс эзэмшигч, 22.3 их наяд төгрөгийн дансны үлдэгдэл байгаа ба эдгээрийн харгалзан 99.8 хувь, 23 хувь нь хадгаламжийн даатгалд хамрагдаж байна.

### Хадгаламжийн даатгалын хураамжийн орлого

Хадгаламжийн даатгал нь банкуудын хадгаламжаас тогтмол хувь хэмжээгээр хураамж авч хуримтлуулан банкинд хүндрэл үүссэн үед тус хуримтлалаас харилцагчдын мөнгийг олгодог тогтолцоо юм.

### Дүрслэл 2.17

Даатгалын хураамжийн орлого



Эх сурвалж: Хадгаламжийн даатгалын корпораци.

Хадгаламжийн даатгалын хураамж нь эхлэлтийн, улирлын болон онцгой гэсэн 3 төрөлтэй байдаг. Хуульд зааснаар эхлэлтийн хураамж нь тухайн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний нэг хувьтай тэнцүү, онцгой хураамжийн дүн нь даатгагдах харилцах, хадгаламжийн 0.5 хувиас хэтэрдэггүй бөгөөд харин улирлын хураамжийн хувийг тухайн банкны эрсдэлийн түвшингээс хамааруулан тогтсон аргачлалын дагуу тооцдог.

ХДК 2013 оноос хойш 2019 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд банкны системийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкуудаас нийт 214.2 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлогыг татан төвлөрүүлжээ.

### Хадгаламжийн даатгалын сан

Хадгаламжийн даатгалын сан нь эхлэлтийн хөрөнгө, хадгаламжийн даатгалын хураамж болон хөрөнгө оруулалтын орлогоос бүрдэх бөгөөд эхлэлтийн хөрөнгийг Монголбанк, Сангийн яамнаас бүрдүүлсэн байдаг бол сангийн хөрөнгийг нэмэгдүүлдэг гол орлого нь хураамж болон хөрөнгө оруулалтын орлого юм.

Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгийн хэмжээ жил бүр өсөн нэмэгдсээр 2019 оны 4

дүгээр сарын эцсийн байдлаар 396.8 тэрбум төгрөгт хүрээд байна.

Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгийн нийт даатгагдсан хадгаламжид эзлэх хувь хэмжээ 2019 оны 4 дүгээр сарын байдлаар 7.7 хувь байна.

### Хүснэгт 2.3

#### Сангийн хөрөнгийн бүтэц (2019 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар)

| Сангийн бүтэц                    | 2013       | 2014      | 2015      | 2016      | 2017      | 2018      | 2019M4    | НИЙТ       |
|----------------------------------|------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|------------|
| Монгол банкнаас оруулсан хөрөнгө | 50         | -         | -         | -         | -         | -         | -         | 50         |
| Засгийн газраас оруулсан хөрөнгө | 35         | 7         | -         | -         | -         | -         | -         | 42         |
| Хөрөнгө оруулалтын орлого        | 2          | 14        | 24        | 30        | 41        | 23        | 13        | 158        |
| Хураамжийн орлого                | 19         | 33        | 27        | 32        | 36        | 43        | 24        | 214        |
| Хадгаламж банкны ЭХА             | 3          | 2         | 1         | 0         | 6         | -         | -         | 11         |
| Даатгалын нөхөн төлбөрийн дүн    | -          | -         | -         | -         | -         | -         | 42        | 42         |
| Нийт зардал                      | 0          | 2         | 3         | 4         | 5         | 8         | 45        | 68         |
| <b>Нийт дүн</b>                  | <b>105</b> | <b>52</b> | <b>48</b> | <b>58</b> | <b>72</b> | <b>69</b> | <b>-8</b> | <b>397</b> |

Эх сурвалж: Хадгаламжийн даатгалын корпораци.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А-96 дугаар тушаал, Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны 72 тоот тогтоолын дагуу Капитал банкны даатгагдсан харилцах, хадгаламж

эзэмшигчдэд нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн. Даатгалын нөхөн төлбөрийн нийт хэмжээ нь 2019 оны 4 сарын 19-ний өдрийн тооцооллоор 42.58 тэрбум төгрөг байсан бөгөөд үүнээс 2019 оны 5 сарын 17-ны байдлаар 33 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг Хаан банкаар дамжуулан олгоод байна.

Өнөөг хүртэл хадгаламжийн даатгалын сангийн бүтцийн гол хэсгийг хураамжийн орлого бүрдүүлсэн хэвээр байгаа боловч цаашид өсөлт нь тогтворжиж, хөрөнгө оруулалтын орлогын өсөлтийн эзлэх хувь нэмэгдэх хандлагатай байна. 2015 оны 12 дугаар сарын байдлаар хадгаламжийн даатгалын санд эзлэх хөрөнгө оруулалтын орлого 19 хувьтай байсан бол энэ харьцаа 2016 оны эцэст 26 хувь, 2017 онд 33 хувь, 2018 онд 36 хувь, 2019 оны 4 сарын эцсийн байдлаар 40 хувь болж өссөн байна.

## 2.2 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО


#### Банк бус санхүүгийн байгууллагын өнөөгийн байдал

##### Ерөнхий төлөв байдал

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 539 ББСБ Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

##### Дүрслэл 2.18

Бүртгэлтэй банк бус санхүүгийн байгууллагын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо 2013 оноос хойш эрчимтэй өсөж байсан бол сүүлийн жилүүдэд өсөлт нь харьцангуй саарах хандлагатай байна. 2019 оны эхний улирлын байдлаар ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өсчээ.

ББСБ-уудын 2018 оны жилийн эцэс болон 2019 оны 1 дүгээр улирлын байдлаарх санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг Хүснэгт 2.4-т хураангуйлан харууллаа.

##### Хүснэгт 2.4

Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

| №  | Үндсэн үзүүлэлтүүд                                  | 2018      | 2019Q1    |
|----|-----------------------------------------------------|-----------|-----------|
| 1  | ББСБ-ын тоо                                         | 539       | 539       |
| 2  | Хувьцаа эзэмшигчдийн тоо                            | 4 875     | 6 921     |
| 3  | Ажиллагсдын тоо                                     | 2 784     | 2 820     |
| 4  | Салбар нэгжийн тоо                                  | 230       | 220       |
| 5  | Харилцагчдын тоо                                    | 1 601 749 | 1 664 902 |
| 6  | Нийт актив                                          | 1 284.9   | 1 395.5   |
|    | Банкны салбарт эзлэх хувь                           | 3.9%      | 4.2%      |
| 7  | Нийт зээлийн өрийн үлдэгдэл                         | 869.2     | 975.5     |
|    | Банкны салбарт эзлэх хувь                           | 4.9%      | 5.4%      |
| 8  | Нийт эзэмшигчдийн өмч                               | 977.4     | 1 061.4   |
|    | Банкны салбарт эзлэх хувь                           | 30.0%     | 31.7%     |
| 9  | Итгэлцлийн үйлчилгээний өглөг                       | 57.6      | 66.1      |
| 10 | Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл | 151.0     | 148.5     |
|    | Үүнээс:                                             |           |           |
|    | Богино хугацаат зээл                                | 85.3      | 69.7      |
|    | Урт хугацаат зээл                                   | 65.7      | 78.8      |
| 11 | Төслийн зээлийн санхүүжилт                          | 17.8      | 18.1      |
| 12 | Нийт орлого                                         | 259.5     | 75.4      |
| 13 | Нийт зардал                                         | 158.4     | 44.4      |
| 14 | Тайлант үеийн ашиг                                  | 101.1     | 31.0      |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт 539 ББСБ-ын 91.5 хувь нь зээл, 28.8 хувь нь гадаад валютын арилжаа, 5.8 хувь нь хөрөнгө оруулалт, 5.8 хувь нь итгэлцлийн үйлчилгээ, 4.5 хувь нь цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 4.3 хувь нь факторингийн үйлчилгээ, 3.3 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 1.7 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна.

### Хүснэгт 2.5

#### Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл

| № | Үйл ажиллагааны нэр төрөл                                                       | 2018 | 2019Q1 |
|---|---------------------------------------------------------------------------------|------|--------|
| 1 | Зээл                                                                            | 491  | 493    |
| 2 | Гадаад валютын арилжаа                                                          | 153  | 155    |
|   | Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг                          | 47   | 46     |
| 3 | Итгэлцлийн үйлчилгээ                                                            | 29   | 31     |
| 4 | Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх                  | 31   | 31     |
| 5 | Факторингийн үйлчилгээ                                                          | 21   | 23     |
| 6 | Төлбөрийн баталгаа гаргах                                                       | 18   | 18     |
| 7 | Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ                                | 23   | 24     |
| 8 | Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх                      | 9    | 9      |
| 9 | Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах                                                 | 3    | 3      |
|   | Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа | 0    | 0      |


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Нийт хөрөнгө

2019 оны 1 дүгээр улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар өсөж 1395.5 тэрбум төгрөгт хүрсний 1344.1 тэрбум төгрөг нь эргэлтийн хөрөнгө байна.

### Дүрслэл 2.19

#### Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар зээлийн багц нийт хөрөнгийн 69.9 хувь буюу 975.5

тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны жилийн эцсээс 12.2 хувиар өссөн дүнтэй байна. Энэхүү өсөлтийн 10.7 нэгж хувь нь хэвийн зээлийн өсөлт, 0.8 нэгж хувь нь хугацаа хэтэрсэн зээлийн өсөлт, 0.7 нэгж хувь нь чанаргүй зээлийн өсөлтөөр тайлбарлагдаж байна.

### Дүрслэл 2.20

#### Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.


2019 оны 1 дүгээр улиралд чанаргүй зээлийн хэмжээ 89.1 тэрбум төгрөгт хүрэв. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2018 оны жилийн эцсээс 0.4 нэгж хувиар буурч 9.1 хувьд хүрсэн. Эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй сайжирч банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн чадавх нэмэгдсэн, зах зээл дэх банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн нийлүүлэлт өссөн, зээлийн жигнэсэн дундаж хүүгийн түвшин буурсан зэрэг эерэг өөрчлөлтүүд чанаргүй зээлийн хэмжээ буурахад нөлөөллөө.

### Зээлийн хүү

2019 оны 1 дүгээр улиралд ББСБ-уудын зээлийн жигнэсэн дундаж хүү 3.4 хувьтай байсан бол ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулахад хүүгийн зөрүү сарын 2.0 хувь байв.

## Дүрслэл 2.21

Банк ба ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү (%)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

## Нийт эх үүсвэр ба Эзэмшигчдийн өмчийн бүтэц

Эзэмшигчдийн өмчийн 2019 оны 1 дүгээр улирлын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.8 хувиар өссөн байна. 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт эх үүсвэрийн 23.9 хувийг өр төлбөр, 76.1 хувийг эзэмшигчийн өмч тус тус эзэлж байна.

## Хүснэгт 2.6

Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

| Үзүүлэлтүүд                        | 2015  | 2016  | 2017  | 2018    | 2019Q1  |
|------------------------------------|-------|-------|-------|---------|---------|
| Нийт актив                         | 623.2 | 787.2 | 969.2 | 1 284.9 | 1 395.5 |
| Нийт зээлийн өрийн үлдэгдэл        | 391.2 | 478.2 | 638.0 | 869.2   | 975.5   |
| Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч | 623.2 | 787.2 | 969.2 | 1 284.9 | 1 395.5 |
| Нийт өр төлбөр                     | 199.0 | 208.7 | 211.0 | 307.5   | 334.1   |
| Эзэмшигчдийн өмч                   | 424.2 | 578.5 | 758.2 | 977.4   | 1 061.4 |
| Үүнээс:                            |       |       |       |         |         |
| Хувьцаат капитал                   | 308.5 | 440.5 | 595.4 | 740.8   | 832.4   |
| Бусад өмч                          | 12.0  | 6.1   | 6.6   | 10.6    | 16.2    |
| Сангууд                            | 0.3   | 0.5   | 0.4   | 0.5     | 0.7     |
| Хуримтлагдсан ашиг/алдагдал        | 102.0 | 130.4 | 155.1 | 224.6   | 211.4   |
| Хоёрдогч өглөг                     | 1.4   | 1.0   | 0.7   | 1.0     | 0.8     |
| Нийт орлого                        | 156.1 | 193.4 | 195.9 | 259.5   | 75.4    |
| Нийт зарлага                       | 109.7 | 134.4 | 129.1 | 158.4   | 44.4    |
| Татварын дараах цэвэр ашиг         | 46.4  | 59.0  | 66.8  | 101.1   | 31.0    |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Санхүүгийн зохицуулах хорооноос ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гарган хэрэгжүүлж байгаа ба 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар хувь нийлүүлсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 186.9 тэрбум төгрөгөөр буюу 28.9 хувиар өссөн байна

## Орлого, зарлага, ашигт ажиллагаа

Тайлант хугацаанд ББСБ-ын салбар нийт 75.4 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 32.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт орлогын 84.1 хувийг хүүгийн орлого, 13.2 хувийг хүүгийн бус орлого тус тус эзэлж байна. Харин ашигт ажиллагааны гол үзүүлэлт болох активын өгөөж (ROA) 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 2.5 хувь байна.

## Хүснэгт 2.7

Орлого, зарлага, ашигт ажиллагаа (тэрбум төгрөг)

| № | Үзүүлэлтүүд                       | 2019Q1 |
|---|-----------------------------------|--------|
| 1 | Нийт орлого                       | 75.4   |
|   | Хүүгийн орлого                    | 63.4   |
|   | Хүүгийн бус орлого                | 9.9    |
|   | Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 2.1    |
| 2 | Нийт зардал                       | 44.4   |
|   | Хүүгийн зардал                    | 6.0    |
|   | Хүүгийн бус зардал                | 25.5   |
|   | Болзошгүй эрсдэлийн зардал        | 8.5    |
|   | Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 0.6    |
| 3 | Орлогын татварын зардал           | 3.7    |
| 4 | Татварын дараах цэвэр ашиг        | 31.0   |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

## ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлт

Тусгай зөвшөөрөл эзэмшигч ББСБ-ын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын дагуу системийн түвшинд тооцож, үр дүнг Хүснэгт 2.8-д харууллаа.

**Хүснэгт 2.8****ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлтүүд**

| №           | Үзүүлэлт                                                            | ББСБ-ын тоо | Эзлэх хувь    |
|-------------|---------------------------------------------------------------------|-------------|---------------|
| 1           | Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо                      | 476         | 88.3%         |
| 2           | Нэг зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо                 | 48          | 8.9%          |
| 3           | Хоёр зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо                | 11          | 2.0%          |
| 4           | Гурван зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо              | 2           | 0.4%          |
| 5           | Дөрвөн зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо              | 0           | 0.0%          |
| 6           | Тав ба түүнээс дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо | 2           | 0.4%          |
| <b>НИЙТ</b> |                                                                     | <b>539</b>  | <b>100.0%</b> |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.


2019 оны 1 дүгээр улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 539 ББСБ-ын 88.3 хувь нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан бол 8.9 хувь нь 1 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 2.0 хувь нь 2 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 0.4 хувь нь 3 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 0.2 хувь нь 5-аас дээш харьцаа үзүүлэлтийг хангаагүй ажилласан байна.

**ББСБ-ын эмзэг байдал**

ББСБ-ын эрсдэл, тогтворгүй байдлыг чанаргүй зээлийн харьцаа ба Z индекс гэсэн хоёр аргаар голчлон тооцдог.


ББСБ нь олгосон зээлийг хугацаа, чанар, эргэж төлөгдөх магадлалыг нь харгалзан ангилах замаар зээлийн эрсдэлийн санг тооцож байгуулдаг. Санхүүгийн зохицуулах хорооноос зээлийн эрсдэлийн санг байгуулах хувь хэмжээг зээлийн ангилал тус бүр дээр тогтоож өгсөн байдаг. Тухайн ББСБ байгуулбал зохих эрсдэлийн сангаа байгуулсан эсэхээс нь хамааран ББСБ чанаргүй зээлээ нөхөх, эрсдэлээс хамгаалах чадвартай эсэхийг нь тодорхойлдог.

ББСБ-ын салбарын хувьд 2019 оны 1 дүгээр улиралд уг харьцаа 101.5 хувь гарсан буюу байгуулвал зохих эрсдэлийн санг бүрэн байгуулсан, эрсдэлийг 101.5 хувиар нөхөх чадамжтай байна.

**Дүрслэл 2.22****Байгуулбал зохих болон байгуулсан эрсдэлийн сан /хувиар/**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Z индекс нь банк бус санхүүгийн байгууллагын дампуурах магадлалыг харуулдаг ба активын өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг активын өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог.

**Дүрслэл 2.23****Z индекс ба өгөөжийн стандарт хазайлт**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй байдал их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. ББСБ-ын салбарын Z индекс өмнөх оны жилийн эцсээс 0.1 ээр буурч 28.1 болжээ.


ББСБ-уудын зардал ба орлогын харьцаа тайлант улиралд 41.9 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 3.8 нэгж хувиар буурчээ. Өөрөөр хэлбэл ББСБ-ууд 100 төгрөгийн орлого



олохын тулд дунджаар 42 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм. Тайлант улиралд ББСБ-уудын зээлийн хүү буурсны зэрэгцээ зардал ба орлогын харьцаа буурсан нь ББСБ-уудын үр ашигт байдал нэмэгдэж буйг харуулж байна.

#### Дүрслэл 2.24

Зардал, орлогын харьцаа (Жил бүрийн эхний улирлын байдлаар)




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийг, нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа буюу хөрвөх чадварын харьцаа тайлант улиралд 24.5

хувь байна. Мөнгөн хөрөнгийн хэмжээ хэт их байх нь хөрөнгөө үр ашигтай зарцуулж, үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж чадахгүй байгааг харуулах бол, хэт бага байх нь тухайн байгууллага хөрвөх чадвар муутайг илэрхийлдэг.

#### Дүрслэл 2.25

Хөрвөх чадварын харьцаа (Жил бүрийн эхний улирлын байдлаар)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Хадгаламж, зээлийн хоршооны өнөөгийн байдал


#### Ерөнхий төлөв байдал

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 282 хадгаламж, зээлийн хоршоо СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа ба тэдгээрийн 178 ХЗХ нь Улаанбаатар хотод, 104 ХЗХ нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.7 хувиар өсч 211.7 тэрбум төгрөгт хүрэв.

#### Дүрслэл 2.26

Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.


**Хүснэгт 2.9****Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)**

| №  | Үндсэн үзүүлэлтүүд                            | 2019Q1 |
|----|-----------------------------------------------|--------|
| 1  | ХЗХ-дын тоо                                   | 282    |
| 2  | Гишүүдийн тоо                                 | 66 296 |
| 3  | Нийт актив                                    | 211.7  |
|    | Банкны салбарт эзлэх хувь                     | 0.6%   |
| 4  | Нийт зээлийн өрийн үлдэгдэл                   | 157.6  |
|    | Банкны салбарт эзлэх хувь                     | 0.9%   |
| 5  | Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл                | 6.0    |
|    | Банкны салбарт эзлэх хувь                     | 0.3%   |
| 6  | Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл | 151.0  |
|    | Банкны салбарт эзлэх хувь                     | 1.2%   |
| 7  | Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл       | 32.2   |
|    | Банкны салбарт эзлэх хувь                     | 1.0%   |
| 8  | Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл            | 16.2   |
| 9  | Бусад өр төлбөр                               | 13.5   |
| 10 | Нийт орлого                                   | 12.6   |
| 11 | Нийт зардал                                   | 12.2   |
| 12 | Тухайн үеийн ашиг, алдагдал                   | 0.5    |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

**Зээлийн чанар**


Тайлант хугацаанд салбарын нийт зээлийн үлдэгдлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 33.6 хувиар өсч 157.6 тэрбум төгрөгт хүрсэн ба нийт зээлийн багцын 93.7 хувийг хэвийн, 2.5 хувийг хугацаа хэтэрсэн, 3.8 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.8 нэгж хувиар буурч 3.8 хувьд хүрчээ.

**Дүрслэл 2.27****Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар (тэрбум төгрөг)**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

**Өр төлбөр ба өөрийн хөрөнгө**

ХЗХ-дын өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.2 тэрбум төгрөг буюу 3.7 хувиар буурсан бол өр төлбөрийн хэмжээ 12.7 тэрбум төгрөг буюу 7.6 хувиар өсчээ.

**Дүрслэл 2.28****Хадгаламж, зээлийн хоршоодын өр төлбөр ба өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 39.8 хувиар өсч 151.0 тэрбум төгрөгт хүрч нийт эх үүсвэрийн 71.3 хувийг эзэлж байна. Үүний 148.1 тэрбум төгрөг буюу 98.1 хувь нь хугацаатай хадгаламж бол 2.9 тэрбум төгрөг буюу 1.9 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

**Ашигт ажиллагаа**

2019 оны 1 дүгээр улиралд ХЗХ-дын нийт орлого 12.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 29.3 хувиар өссөн бол нийт зардал 30.8 хувиар өсч 12.2 тэрбум төгрөгт хүрчээ. Улмаар тайлант хугацаанд нийт цэвэр ашгийн хэмжээ 0.45 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.01 тэрбум төгрөгөөр буюу 2.0 хувиар буурав.


**ХЗХ-дын эрсдэл ба эмзэг байдал**

ХЗХ-дын эрсдэл, эмзэг байдлыг үнэлэхдээ тэдгээрийн тогтвортой байдлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг шинжлэх шаардлагатай.

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар өөрийн хөрөнгийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа буюу өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт өмнөх оны мөн үеэс 2.4 нэгж хувиар буурч 15.2 хувьд хүрчээ.

### Дүрслэл 2.29

Хадгаламж, зээлийн хоршоодын өөрийн хөрөнгийн хүрэлцээ (Жил бүрийн I улирлын байдлаар)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.


Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.8 нэгж хувиар буурч 3.8 хувьд хүрсэн ч чанаргүй зээлийн ангилал дахь муу зээлийн дүн 60.4 хувьд хүрч зээлийн эрсдэлийн сангийн зардлыг нэмэгдүүлсэн байна.

Харин байгууллагын хөрвөх чадварыг илэрхийлэх үзүүлэлтүүд болох мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа, богино хугацаат хөрөнгө оруулалтын зээл болон нийт хөрөнгийн харьцааг тооцон Дүрслэл 2.30-д үзүүлээ. Эдгээр үзүүлэлтүүд нь хадгаламж

эзэмшигч болон хөрөнгө оруулагч хөрөнгөө татах үед тухайн санхүүгийн байгууллага өөрийн хөрөнгөө мөнгөн хөрөнгөд хэр түргэн хөрвүүлэх боломжтойг харуулдаг. ХЗХ-дын хувьд сүүлийн 5 жилийн хугацаанд нийт мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа дунджаар 17.4 хувьтай байсан бол тайлант улиралд 21.4 хувьтай байна.

### Дүрслэл 2.30

Хөрвөх чадварын харьцаа (Жил бүрийн I улирлын байдлаар)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Харин богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 78.0 хувьтай байсан бол тайлант улиралд тус үзүүлэлт 74.4 хувьтай байна.


## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

### Ерөнхий төлөв байдал

Санхүүгийн зах зээл, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түвшинг хэмжихдээ зах зээлийн хэмжээ, хүртээмж, үр ашигт байдал, тогтвортой байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг ашигладаг.


### Зах зээлийн хэмжээ

Үнэт цаасны зах зээлийн эдийн засагт эзлэх хувийг зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-гээр илэрхийлэх ба 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2456.5 тэрбум төгрөгт хүрч 2018 оны нэрлэсэн ДНБ-ий 7.6 хувьтай тэнцэж байна.

**Дүрслэл 2.31****Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.


Хөрвөх чадварын түвшин нь хувьцааны зах зээлийн эргэц, хурдыг илэрхийлэх бөгөөд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын тухайн зах зээлд хөрөнгө оруулах сонирхол нь хөрвөх чадварын түвшнээс хамаарч байдаг.

**Дүрслэл 2.32****Хөрвөх чадварын харьцаа**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Манай улсын хувьд хөрвөх чадварын түвшин маш бага байдаг хэдий ч сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар зах зээлийн хөрвөх чадварын үзүүлэлт 1.8 хувь байгаа ба энэ нь өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар өссөн дүн юм. Хөрвөх чадварын харьцаа ийнхүү өсөхөд хувьцааны арилжааны дүн өмнөх оны эцсээс 2.5 дахин өссөн нь нөлөөллөө. Хэдийгээр бага дүнтэй хэдий ч хөрвөх чадварын түвшин сайжирч байгаа нь үнэт цаасны зах зээлд оролцох олон нийтийн сонирхол нэмэгдэж буйг харуулж байна.

Тайлант улиралд Монголын Хөрөнгийн Бирж болон Монголын Үнэт Цаасны Биржээр дамжуулан нийт 44.4 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн ба энэ нь өмнөх оны мөн үеэс 26.7 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт боллоо.

**Дүрслэл 2.33****Хувьцааны арилжааны дүн**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Харин хувьцааны арилжааны дүнг 2018 оны жилийн эцсийн нэрлэсэн ДНБ-д харьцуулахад 0.14 хувьтай байна.

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны бүртгэлд төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой болон хувийн нийт 307 хувьцаат компани бүртгэлтэй байгаа ба зах зээлийн үнэлгээгээр эхний 10-т жагсаж буй компаниудын нийт үнэлгээ зах зээлийн 75.4 хувийг бүрдүүлж байна.

Харин зах зээлийн төвлөрлийг хэмждэг үзүүлэлт болох Херфиндалын индексийг хувьцаат компаниудын зах зээлийн үнэлгээг ашиглан тооцоход тайлант улиралд 1219.1 байна. Херфиндалын индекс нь 1500-аас бага утга авсан тохиолдолд тухайн зах зээл харьцангуй өрсөлдөөнт хэлбэртэй байдаг бол 1500-2500 хүртэлх утга нь бага зэрэг төвлөрсөн, 2500-аас дээш утга нь төвлөрөл ихтэй байгааг харуулдаг.

### Зах зээлийн үр ашигт байдал

Хөрөнгийн зах зээлийн үр ашигт байдлыг хэмждэг нэг үзүүлэлт нь хувьцааны үнэ зах зээлийн хөдөлгөөнийг хэрхэн дагаж буйг хэмждэг үзүүлэлт байдаг. Уг үзүүлэлт нь тайлант хугацаанд тохиосон ханшийн өөрчлөлтийн хэдэн хувь нь ижил чиглэлд өөрчлөгдсөнийг хэмждэг бөгөөд 50-100 хүртэлх хувиар үнэлэгддэг.

Уг үзүүлэлт өндөр байх нь хувьцааны хөдөлгөөн зах зээлийг даган савласан байж болзошгүйг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл хувьцааны арилжаанд оролцож буй олон нийт, хөрөнгө оруулагчид тухайн байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээлэлд суурилах бус зах зээлд дэгдсэн цуурхал, арилжааны талаарх хүлээлт дээр суурилан арилжаанд оролцох үед зах зээл дээрх хувьцааны үнэ байгууллагын үйл ажиллагаанаас үл хамааран зах зээлийг даган нэг чиглэлд өөрчлөгдөж байдаг бөгөөд уг сул талыг энэхүү үзүүлэлт илэрхийлдэг.

2019 оны 1 дүгээр улиралд Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдсан нийт хувьцааны 54.9 хувийнх нь ханш нэг чиглэлд өөрчлөгдсөн буюу зах зээлийг бүхэлд нь хамарсан ерөнхий мэдээлэлд өртөн, арилжаалагдаж буй хувьцааны ханш ижил чиглэлд савлах эрсдэл бага байгааг харуулж байна.


### Зах зээлийн тогтвортой байдал

Хувьцааны зах зээлийн өгөөжийн тархалт нь зах зээлийн тогтвортой байдлын үзүүлэлт болдог. Зүүн тийш хэвийсэн тархалтын график нь тухайн зах зээлийн өгөөж бууралттай байсан тохиолдол олон байсныг харуулдаг бөгөөд зах зээлийн тогтворгүй байдлыг илэрхийлдэг.

Монгол Улсын хувьцааны зах зээлийн өгөөжийг 2005 оны 1 дүгээр сараас 2019 оны 3 дугаар сарыг хүртэлх ТОП-20 индексийн утгыг ашиглан тооцож, өгөөжийн тархалтыг Дүрслэл 2.34-г харууллаа.

### Дүрслэл 2.34

#### Зах зээлийн өгөөжийн тархалт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Хувьцааны үнийн хэлбэлзэл нь тухайн улс орны хувьцааны зах зээлийн тогтвортой байдлыг илтгэх гол үзүүлэлт юм.

### Дүрслэл 2.35

#### Хувьцааны үнийн хэлбэлзэл



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Монголын хувьцааны үнийн хэлбэлзлийг ТОП-20 индексээр төлөөлүүлж Дүрслэл 2.35-д харуулав. 2018 оны 1 дүгээр улиралд хувьцааны үнийн хэлбэлзэл 9.9 хувьтай байсан бол 2019 оны 1 дүгээр улиралд 5.2 нэгж хувиар буурч 4.7 хувьд хүрчээ. Хувьцааны үнэ хэт өндөр хэлбэлзэлтэй байх нь тухайн хувьцааны зах зээл өндөр эрсдэлтэй байгааг харуулдаг байна.

Монголын хөрөнгийн бирж” ХК 1991 онд байгуулагдаж 1992 онд МХБ – ээр дамжуулан 475 улсын өмчит компанийг хувьчилсан түүхтэй хэдий ч үүнээс хойш 13 жилийн дараа буюу 2005 онд “Монгол шилтгээн” ХК МХБ-ээр дамжуулан анхдагч зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлсэн нь Монголын анхны IPO


гаргасан тохиол болсон юм. 2005 оноос хойш 2019 оны 1 дүгээр улирал хүртэл 14 жилийн хугацаанд нийт 25 компани IPO гаргаж нийт 129.3 тэрбум төгрөгийн хөрөнгийг анхдагч зах зээлээс татан төвлөрүүлсэн байна. Үүнээс харахад хөрөнгийн зах зээлд IPO гаргаж буй компаниудын тоо нь манай улсын зах зээлийн хөгжлийн чухал үзүүлэлт болоод байна.

2019 оны эхний улиралд нийт 2 компани 15.3 тэрбум төгрөгийг анхдагч зах зээлээс татан төвлөрүүлжээ. Сүүлийн үед анхдагч зах зээлийн арилжааны захиалга өндөр дүнгээр давж биелэх болсон нь иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл нэмэгдэж, энэхүү салбарт хөрөнгө оруулах сонирхол нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж

болох юм. Хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох идэвх, сонирхол нэмэгдэх нь цаашид зах зээл тогтвортойгоор өсөн дэвжихийн үндэслэл мөн юм.

### Дүрслэл 2.36

#### IPO гаргасан компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

## Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн үзүүлэлтүүд


### Бүртгэлтэй компани

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 307 хувьцаат компани бүртгэлтэй байгаагаас төрийн өмчийн оролцоотой 19, төрийн өмчит 31, хувийн өмчит 257 компани байна.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувийн өмчит компаниудын дийлэнх нь өмч хувьчлалаар үүсэн бий болсноос үүдэн компанийн хувьцааны хяналтын багц цөөн тооны нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрсөн нь зах зээл дэх нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлдөг. Хувьцаат компанийн хяналтын багц цөөн тооны хөрөнгө оруулагчдын гарт төвлөрсөн нь компанийн засаглалыг доройтуулж, дотоод мэдээлэл эзэмшигч этгээд үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж, улмаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж байна. Энэ нь зах зээлийн хөрвөх чадварыг бууруулах үндсэн шалтгаан болж байна.

### Дүрслэл 2.37

#### Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Олон улсын туршлагаас үзэхэд компанийн засаглалыг хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан, хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээ сонгосон болон санхүүгийн тайлангаа төрийн эрх бүхий байгууллага, олон нийтэд мэдээлсэн байдал, ногдол ашиг тараалт, нийгмийн хариуцлага гэсэн үзүүлэлтүүдээр голчлон авч үздэг.

2018 оны жилийн эцсийн байдлаар 26 компани 146.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг тарааж, 130 компани санхүүгийн тайлангаа



олон нийтэд нээлттэй мэдээлж, 138 компани хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан байна.

### Зах зээлийн дэд бүтэц

2019 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 54 компани СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт

цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 19 компани үйл ажиллагаа явуулж байна. Харин хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 12 этгээд байна.

### Үнэт цаасны зах зээлийн төлбөр, тооцооны үзүүлэлтүүд

“Арилжааны төлбөр тооцоо” ХХК 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар анхдагч зах зээлийн арилжааны 15.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий хувьцааны төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн. Хоёрдогч зах зээлд Засгийн газрын үнэт цаасны 5.1 тэрбум, хувьцааны 28.9 тэрбум төгрөгийн арилжааны тооцоог тус тус хийж гүйцэтгэв.


Мөн үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөрөөс “ХААН банк” ХХК 2.3 тэрбум, “Хас банк” ХХК 1.9 тэрбум, “Худалдаа хөгжлийн банк” ХХК 2.6 тэрбум, “Голомт банк” ХХК 2.6 тэрбум төгрөгийн гүйлгээг тус тус хийжээ.

Тус хугацаанд төвлөрсөн хадгаламжид шинээр нийт 418,905 данс нээгдсэнээс, дотоодын иргэн 418,872, гадаадын иргэн 21, дотоодын аж ахуйн нэгж 11, гадаадын аж ахуйн нэгж 1 данс нээлгэсэн байна. 2012 оноос үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нээгдсэн дансны тоо эрс өссөн нь төрөөс

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх шийдвэр гаргасан нь голлон нөлөөлсөн.

### Дүрслэл 2.38

#### Арилжааны төлбөр тооцоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

## ДААТГАЛЫН САЛБАР

## Даатгалын салбарын ерөнхий мэдээлэл

## Ерөнхий төлөв байдал

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацаат даатгалын 1, давхар даатгалын 2 компани нийт 18 даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын зах зээлд нийт 2524 мэргэжлийн оролцогч оролцож байгаагаас зуучлагч 50, хохирол үнэлэгч 26, 2448 төлөөлөгч Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байна.

## Хүснэгт 2.10

Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо (жил бүрийн эхний улирлын байдлаар)

| Үзүүлэлт                  | 2013         | 2014         | 2015         | 2016         | 2017         | 2018         | 2019         |
|---------------------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|
| Даатгагч                  | 17           | 17           | 17           | 17           | 17           | 18           | 18           |
| Даатгалын төлөөлөгч       | 3 178        | 3 260        | 3 340        | 3 091        | 2 893        | 2 573        | 2 448        |
| Даатгалын зуучлагч        | 20           | 30           | 37           | 40           | 42           | 43           | 50           |
| Даатгалын хохирол үнэлэгч | 14           | 20           | 27           | 31           | 29           | 28           | 26           |
| <b>Нийт</b>               | <b>3 229</b> | <b>3 327</b> | <b>3 421</b> | <b>3 179</b> | <b>2 981</b> | <b>2 662</b> | <b>2 542</b> |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

## Даатгагчийн хөрөнгө

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 327.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 69.3 тэрбум төгрөгөөр буюу 26.8 хувиар өссөн.

Сүүлийн 5 жилд даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт компаниудын хөрөнгийн хэмжээ 1.9 дахин нэмэгдсэн бол урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн хөрөнгийн хэмжээ 1.4 дахин нэмэгдсэн дүнтэй байна. 2019 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн, урт хугацааны болон давхар даатгалын компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад нэг компани 19.8 хувийн, эхний дөрвөн компани нийлээд 59.5 хувийн тус тус төвлөрөлтэй байв.

## Хүснэгт 2.11

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ (2019 оны I улирлын байдлаар, тэрбум төгрөг)

| №          | Даатгалын компаниуд       | Нийт хөрөнгийн хэмжээ | Эзлэх хувь    |
|------------|---------------------------|-----------------------|---------------|
| 1          | Үндэсний давхар даатгал   | 49.3                  | 15.0%         |
| 2          | Мандал даатгал            | 38.9                  | 11.9%         |
| 3          | Монгол даатгал            | 35.8                  | 10.9%         |
| 4          | Тэнгэр даатгал            | 23.9                  | 7.3%          |
| 5          | Бодь даатгал              | 21.4                  | 6.5%          |
| 6          | Хубилай давхар даатгал    | 20.5                  | 6.2%          |
| 7          | Ард даатгал               | 20.4                  | 6.2%          |
| 8          | Миг даатгал               | 16.2                  | 5.0%          |
| 9          | Практикал даатгал         | 15.8                  | 4.8%          |
| 10         | Номин даатгал             | 15.6                  | 4.7%          |
| 11         | Хаан даатгал              | 12.2                  | 3.7%          |
| 12         | Соёмбо даатгал            | 10.8                  | 3.3%          |
| 13         | Монре даатгал             | 9.4                   | 2.9%          |
| 14         | Нэйшнл лайф даатгал       | 9.1                   | 2.8%          |
| 15         | Амар даатгал              | 7.9                   | 2.4%          |
| 16         | Ган зам даатгал           | 7.2                   | 2.2%          |
| 17         | Улаанбаатар хотын даатгал | 7.2                   | 2.2%          |
| 18         | Мөнх даатгал              | 6.0                   | 1.8%          |
| <b>Дүн</b> |                           | <b>327.6</b>          | <b>100.0%</b> |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн 54.9 хувийг хөрөнгө оруулалтын дүн, 16 хувийг мөнгөн хөрөнгийн дүн, 9.2 хувийг үндсэн хөрөнгө, 4.9 хувийг даатгалын авлагын дүн, 15 хувийг бусад хөрөнгө, эх үүсвэрийн 48.5 хувийг нийт өр төлбөр, 51.5 хувийг эзэмшигчдийн өмч тус тус эзэлж байна.

Ердийн даатгалын компанийн эх үүсвэрийн 46 хувь буюу 113.9 тэрбум төгрөгийг нөөц сан (нөөц сангийн дүн болон орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн нийлбэр дүн) бүрдүүлж байгаа бол нийт хөрөнгийн 51 хувь буюу 126.1 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын дүн эзэлж байна.

### Хүснэгт 2.12

Даатгалын компаниудын хөрөнгө балансын зүйлээр (хувиар)

| №  | Үзүүлэлтүүд                                       | Ердийн даатгал | Урт хугацаат даатгал | Давхар даатгал |
|----|---------------------------------------------------|----------------|----------------------|----------------|
| 1  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө                   | 13%            | 1%                   | 30%            |
| 2  | Даатгалын авлагын дүн                             | 6%             | 0%                   | 0%             |
| 3  | Бусад санхүүгийн хөрөнгийн дүн                    | 6%             | 1%                   | 0%             |
| 4  | Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн                | 2%             | 0%                   | 0%             |
| 5  | Хөрөнгө оруулалтын дүн                            | 51%            | 70%                  | 68%            |
| 6  | Даатгалын хөрөнгийн дүн                           | 11%            | 0%                   | 0%             |
| 7  | Үндсэн хөрөнгө /Цэвэр/                            | 11%            | 27%                  | 1%             |
| 8  | Биет бус хөрөнгө /Цэвэр/                          | 0%             | 1%                   | 0%             |
| 9  | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 0%             | 0%                   | 0%             |
| 10 | Өр төлбөр                                         | 52%            | 24%                  | 38%            |
| 11 | Нөөц сан                                          | 46%            | 24%                  | 37%            |
| 12 | Эзэмшигчдийн өмч                                  | 48%            | 76%                  | 62%            |
| 13 | Хувь нийлүүлсэн хөрөнгө                           | 31%            | 66%                  | 43%            |
| 14 | Хуримтлагдсан ашиг                                | 10%            | -2%                  | 18%            |


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Даатгагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч дэх даатгалын нөөц сан 2015 оны 4 дүгээр улиралд 42.1 хувь, 2016 оны 4 дүгээр улиралд 44.6 хувь, 2017 оны 4 дүгээр улиралд 48.2 хувьд хүрч тогтвортой өссөн бол 2018 оны 4 дүгээр улиралд 44 хувь, 2019 оны 1 дүгээр улиралд 43.3 хувь болж буураад байна.

### Дүрслэл 2.39

Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Даатгалын хураамжийн орлого ба нөхөн төлбөр

Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 38.3 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнээс ердийн даатгалын компаниуд 37.9 тэрбум төгрөгийн, урт хугацааны даатгалын компани 417.6 сая төгрөгийн, давхар даатгалын компани 25.3 сая төгрөгийн хураамжийн орлого тус тус төвлөрүүлсэн байна.

2005 оноос 2014 он хүртэлх хугацаанд нийт хураамжийн орлого 99.2 тэрбум төгрөгөөр ялангуяа 2012 оноос эхлэн огцом өссөн байна. Үүнд 2012 онд “Жолоочийн албан журмын даатгалын тухай хууль” батлагдаж, хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор албан журмаар даатгуулах даатгуулагчдын тоо нэмэгдэж, мөн түүнчлэн албан журмын даатгалын өсөлтийг дагаж авто тээврийн хэрэгслийн даатгал өндөр өсөлттэй гарсан нь голлон нөлөөлжээ. Харин 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 12.6 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгожээ.

### Хүснэгт 2.13

Даатгалын хураамжийн орлого ба нөхөн төлбөр, бүтээгдэхүүнээр (тэрбум төгрөг)

| №  | Бүтээгдэхүүний хэлбэр                                                                                     | Нийт хураамжийн орлого | Нийт нөхөн төлбөр |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|-------------------|
| 1  | Гэнэтийн осол, эмчилгээний даатгал                                                                        | 5.2                    | 2.0               |
| 2  | Хөрөнгийн даатгал                                                                                         | 5.2                    | 0.7               |
| 3  | Авто тээврийн хэрэгслийн даатгал                                                                          | 6.4                    | 3.9               |
| 4  | Ачааны даатгал                                                                                            | 0.5                    | 0.2               |
| 5  | Барилга угсралтын даатгал                                                                                 | 6.5                    | 0.0               |
| 6  | Газар тариалангийн даатгал                                                                                | 0.0                    | 0.0               |
| 7  | Мал амьтдын даатгал                                                                                       | 0.0                    | 0.0               |
| 8  | Агаарын хөлгийн даатгал                                                                                   | 0.7                    | 0.0               |
| 9  | Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал                                                    | 0.1                    | 0.0               |
| 10 | Хариуцлагын даатгал                                                                                       | 3.2                    | 0.3               |
| 11 | Санхүүгийн даатгал                                                                                        | 0.6                    | 0.2               |
| 12 | Зээлийн даатгал                                                                                           | 0.3                    | 0.4               |
| 13 | Итгэлцлийн даатгал                                                                                        | 0.2                    | 0.0               |
| 14 | Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал                                                  | 0.1                    | 0.0               |
| 15 | Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | 0.0                    | 0.0               |
| 16 | Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал                                 | 1.2                    | 0.0               |
| 17 | Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал                                                                | 7.4                    | 4.8               |
| 18 | Амьдралын даатгал                                                                                         | 0.4                    | 0.1               |
| 19 | Давхар даатгал                                                                                            | 0.0                    | 0.0               |
|    | <b>Дүн</b>                                                                                                | <b>38.3</b>            | <b>12.6</b>       |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Даатгалын салбарын ашигт ажиллагаа

Даатгалын салбарын өөрийн хөрөнгийн өгөөжийг нэгдүгээр улирлаар харьцуулан харвал 2011 оны мөн үед хамгийн өндөр буюу 7.7 хувь байсан бол 2014 онд уг үзүүлэлт хамгийн доод цэгтээ хүртэл буурч -0.9 хувьд хүрсэн билээ. 2014 оноос хойш өөрийн хөрөнгийн өгөөжийн харьцаа өсөх хандлагатай байгаа бөгөөд тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар өссөнөөр 4.6 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжийн графикийн чиглэлд ижил төлөв ажиглагдаж байна. 2014 оны нэгдүгээр улиралд нийт хөрөнгийн өгөөж хамгийн доод цэгтээ буюу -0.4 хувьд хүрсэн хэдий ч дараагийн жилүүдэд сэргэж эхэлсэн. Тайлант улиралд нийт хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өсөж 1.7 хувь болсон байна.

### Даатгалын салбарын тогтвортой байдал

Даатгалын компаниудын үндсэн эрсдэл бол даатгалын тохиолдол гарах магадлал болон даатгуулагчид нөхөн төлбөр төлөх магадлал юм. Даатгалын компаниуд даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн түүхэн мэдээлэлд үндэслэн даатгалын эрсдэлийг тооцоолон даатгалын хураамжийн хувийг тогтоох замаар энэ эрсдэлээс үүсэх зардлыг нөхөхөөр төлөвлөдөг. Даатгалын эрсдэлийг онцлогоос нь хамааран даатгаж болох, даатгаж болохгүй гэж ангилна. Даатгалын эрсдэлд даатгуулагчийн гаргадаг ёс зүйгүй үйлдлүүд болон даатгалын компани даатгалын тохиолдол гаргах өндөр магадлалтай даатгуулагчийг даатгасны улмаас нөхөн төлбөрийн зардал өндөр гарахыг хэлнэ. Эдгээр эрсдэлийг багасгахын тулд даатгуулагчийн буруутай үйлдлээс болж даатгалын тохиолдол үүссэн болон даатгалын тохиолдол үүсэхэд ямар нэгэн байдлаар даатгуулагчаас шалтгаалсан бол даатгагч гэрээнд заасны дагуу нөхөн төлбөр олгохгүй байхаар тусгаж болохыг хууль эрх

зүйн хүрээнд зохицуулсан байдаг. Даатгалын шинэ гэрээ байгуулахдаа андеррайтинг хийж, хураамжийн хувийг нөхөн төлбөр олгоход хүрэлцэхүйц, оновчтой тогтоох нь даатгалын эрсдэлийг удирдахад чухал ач холбогдолтой юм.

Санхүүгийн зохицуулах хороо гүйцэтгэлд суурилсан хяналт шалгалтаас эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо руу шилжихээр холбогдох бодлогын баримт бичгүүдийг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөж эхлээд байна. Үүний хүрээнд даатгалын салбарын “Эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлал”, “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хэрэгжүүлэх журам” болон “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ыг батлан, 2019 оны нэгдүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдүүлж эхэллээ. Эдгээр журам, заавар, аргачлалыг мөрдүүлснээр даатгалын зах зээлийн оролцогчдын эрсдэлийг тооцох, удирдах тогтолцоо бүрдэх юм. “Эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлал” нь ердийн даатгал, урт хугацааны даатгал, давхар даатгалын компаниудын даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэхийг тодорхойлох бөгөөд энэхүү аргачлалд тооцогдож байгаа эрсдэлүүдээс өөрөөр тоон утгаар илэрхийлэгдэж болох эрсдэлийг мөн тооцох бололцоотой юм. Энэхүү аргачлалыг ашигласнаар цаашид тооцож болох эрсдэлийн төрлийг нэмэгдүүлэх, даатгалын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн хүрэлцээтэй болон үнэн зөв байдлыг бий болгох боломжтой болж байгаа юм.

Хөрвөх чадварын эрсдэлийн хувьд банк болон компаниуд нь богино хугацаанд санхүүгийн хэрэгцээтэй тулгарах нь бий. Энэ нь даатгалын компаниудын хувьд гэнэт их хэмжээний нөхөн төлбөрийн нэхэмжлэл үүсэх зэрэг богино хугацаанд санхүүгийн эх үүсвэр шаардлагатай үед төлбөрийн чадваргүй болох

эрсдэл юм. Энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс гадаадын зарим улс орнууд хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Тухайлбал: Швейцарийн “Swiss Re” давхар даатгалын компани нь хөрөнгийн чөлөөт урсгалыг хангалттай хөрвөх чадвартай байлгаж, тохиолдож болох гэнэтийн таагүй үйл явдлаас гарахад шаардлагатай боломжит мөнгөн хөрөнгийн санхүүжилтийг бий болгох бодлого баримталдаг байна. Тус давхар даатгалын компани нь группын толгой компани болон бизнесийн гурван нэгжийг төлөөлөх дөрвөн үндсэн хөрвөх чадварын санг бүрдүүлдэг байна.


Харин зах зээлийн эрсдэлийн хувьд хүүгийн хэлбэлзэл, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, үл хөдлөх хөрөнгийн үнийн индекс, валютын ханш гэх мэт макро хүчин зүйлс багтана. Монгол улсын даатгалын зах зээлийн хамгийн том тулгамдаж буй асуудал нь валютын ханштай холбогдох эрсдэл юм. Даатгалын компаниудын дийлэнх нь давхар даатгалаа гадны даатгалын компанид хийлгэдэг бөгөөд сүүлийн гурван жилд дунджаар 30 гаруй тэрбум төгрөгийг гадаад валют хэлбэрээр шилжүүлсэн бөгөөд тайлант улиралд давхар даатгалын зардал даатгалын нийт хураамжийн орлогын 32.6 хувийг эзэлж байна. Харин 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар энэхүү дүн нь 12.5 тэрбум төгрөг болж өссөн нь нийт хураамжийн орлогын 32.6 хувийг эзэллээ. Даатгалын салбар өргөжихийн хэрээр тус салбар дахь гадаад валютын гадагшлах урсгал нэмэгдэж байгаа нь салбарын тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлал бий болгож байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларч буй нь даатгалын компаниудад томоохон дарамт үүсгэх болсон.

Даатгалын салбар нь нийгэм, эдийн засагт учрах хүлээгдээгүй эрсдэлийг бууруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг хэдий ч, тус салбарын өөрийн тогтворгүй байдал, системийн эрсдэлийн түвшин нь эргээд

санхүүгийн тогтвортой байдалд томоохон нөлөө үзүүлдэг. Иймд манай орны хувьд үндэсний давхар даатгалын компанийг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчинг сайжруулан дэмжих шаардлага үүсч байгаа бөгөөд энэ нь цаашлаад гадаад валютын гадагшлах урсгалыг сааруулах, төгрөгийн тогтвортой байдлыг дэмжихэд чухал нөлөөтэй юм.

#### Дүрслэл 2.40

Давхар даатгалын хураамж, ам.долларын ханш




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Тайлант улиралд даатгалын компаниудын балансын хөрөнгийн 54.9 хувийг хөрөнгө оруулалтын дүн эзэлсэн ба үүний 91.7 хувийг хадгаламж, хадгаламжийн сертификат хэлбэрээр хийсэн хөрөнгө оруулалт бүрдүүлж байгаа юм. Хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасаарх хөрөнгө оруулалтаас даатгалын компаниуд 2019 оны 1 дүгээр улиралд нийт 20.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон нь даатгалын орлогын дүнгийн 29.7 хувийг эзэлжээ. Үүнийг задлан үзвэл ердийн даатгалын компаниудын хувьд хүүгийн орлого нь нийт даатгалын орлогын 22.2 хувь, урт хугацааны даатгалын компанийн 68.7 хувь, давхар даатгалын компанийн 90.7 хувийг бүрдүүлсэн байна.

Үүнээс дүгнэхэд урт хугацааны болон давхар даатгалын компанийн хувьд орлогын дийлэнх хувь нь хүүгийн түвшнээс, өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын хүүгийн орлогоос хамааралтай болох нь харагдаж байна. Манай улсын хувьд хүүгийн хэлбэлзэл тогтвортой байгаа тул энэ төрлийн эрсдэл харьцангуй бага байна.

#### Дүрслэл 2.41

Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.




## ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

Зээлийн батлан даалтын сан нь эргэлтийн хөрөнгийн, хөрөнгө оруулалтын, бичил зээлийн гэсэн 3 төрлөөр батлан даалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд нэг удаа гаргах батлан даалтын дээд хэмжээ нь 250.0 сая төгрөг байна. 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 4.8 тэрбум төгрөгийн зээлийн багцад 2.6 тэрбум төгрөгийн батлан даалтыг гаргасан бол хуримтлагдсан дүнгээр 101.1 тэрбум төгрөгийн зээлийн багцад 52.0 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна.

Зээлийн батлан даалтын сан нь 2019 оны 1 дүгээр улиралд гаргасан батлан даалтын 42.4 хувийг Худалдаа хөгжлийн банк, 34.6 хувийг Капитрон банк, 18.5 хувийг Төрийн банк, 2.3 хувийг Хаан банк, 2.2 хувийг Хас банкны зээлэнд тус тус гаргасан байна.

### Дүрслэл 2.42

Батлан даалт гаргасан байдал болон санхүүжилтийн эх үүсвэр



| №   | Үзүүлэлтүүд/ Хуримтлагдсан дүн       | 2019Q1  |
|-----|--------------------------------------|---------|
| 1   | Батлан даалтын хэмжээ                | 51 984  |
| 1.1 | Үүнээс: Хугацаа хэтэрсэн             | 1 079   |
| 1.2 | Чанаргүй                             | 7 305   |
| 2   | Батлан даалт гаргасан зээлийн хэмжээ | 101 050 |
| 2.1 | Үүнээс: Хугацаа хэтэрсэн             | 2 242   |
| 2.2 | Чанаргүй                             | 16 050  |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

## ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ БА ТҮҮХИЙ ЭДИЙН АРИЛЖАА

2013 оны 4 дүгээр сард биржээр дамжин зөвхөн нэг төрлийн түүхий эд буюу ямааны ноолуур арилжаалагддаг байсан бол 2018 оны 3 дугаар улирлын байдлаар бараа бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж 8 төрлийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалагддаг болсон. Үүнд: ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод ноос, бодын хөөвөр, мал бэлтгэл, хүнсний буудай болон тосны ургамал зэрэг багтдаг. Завод ноос нь адуу болон үхрийн, хонины, ямааны, сарлагийн, тэмээний гэж 5 ангилагддаг бол бодын хөөвөр нь сарлагийн, адууны, үхрийн гэсэн 3 ангилалд хуваагддаг.

Тайлант улиралд Хөдөө аж ахуйн биржээр нийт 33.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод

ноос, бодын хөөвөр арилжаалагдсан бөгөөд нийт арилжааг бүтцээр ангилан үзвэл 14 хувийг ямааны ноолуур, 4 хувийг хонины ноос, 79 хувийг завод ноос, 3 хувийг тэмээний ноос тус тус эзэлж байна.

### Хүснэгт 2.14

Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн арилжааны үнийн дүн

| Барааны нэр    | Арилжааны дүн/тэрбум төгрөг/ | Арилжааны дүн /хувь/ |
|----------------|------------------------------|----------------------|
| Ямааны ноолуур | 4.6                          | 14%                  |
| Хонины ноос    | 1.3                          | 4%                   |
| Завод ноос     | 26.2                         | 79%                  |
| Тэмээний ноос  | 1.0                          | 3%                   |
| Дүн            | 33.1                         | 100%                 |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.



## САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ

### 3.1 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн өмнөх дугаар гарч, олон нийтийн хүртээл болсноос хойших хугацаанд Монгол Улсын банк санхүүгийн салбарт хийгдэж буй хууль эрх зүйн шинэчлэлийг үргэлжлүүлж, санхүүгийн салбарын дэд бүтцийг бэхжүүлэх, эрсдэлийг бууруулах, харилцагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлд зарим томоохон ажлууд хийгдсэн байна. Тухайлбал, Банкны тухай хуульд заасны дагуу банкны үйл ажиллагааны шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон банкинд албадлагын арга хэмжээг авахтай холбоотой журмууд батлагдав. Үүнээс гадна Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2018 онд баталсан “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”-т заасны дагуу банкны салбар дахь чанаргүй зээлийг шийдвэрлэх тогтолцоог сайжруулах зорилгоор Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Улсын бүртгэлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг боловсруулаад байна.

**Банк санхүүгийн тогтвортой байдлыг хангах, бэхжүүлэх чиглэлээр Төв банк / Монголбанк/-ны тухай хууль, Банкны тухай хуульд заасны дагуу холбогдох журмуудыг батлан, мөрдүүлж эхлээд байна.**

Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Банкны тухай хуулийн шинэчлэлтэй холбогдуулан 2019 оны 1 дүгээр улиралд Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам, Банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналттавих журам, Мөнгөугаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл

ажиллагааны журам, Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам, Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам, Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам, Банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлт, холбогдох баримт бичгийг хянан шийдвэрлэх заавар, Дахин хөрөнгөжүүлсэн банкнаас гаргах хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг, давуу эрхийн хувьцааны нөхцөлийн журам, Банкны чанаргүй активыг бууруулах удирдлага, тогтолцоо, тайлагнах үлгэрчилсэн журмыг тус тус батлан, мөрдүүлж байна.

**Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Улсын бүртгэлийн хууль тогтоомж болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулав.** Өр төлбөрийг шүүхийн журмаар албадан барагдуулах ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгох, чанаргүй активыг үр ашигтай шийдвэрлэх, барьцаа хөрөнгөтэй холбоотой бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлд хууль, эрх зүйн болон шүүхийн процесст шаардлагатай өөрчлөлт оруулж, сайжруулах зорилгоор Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Улсын бүртгэлийн хууль тогтоомж болон бусад холбогдох хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий Монголбанк, Сангийн яам, Монголын банкны холбоо, болон хуульч, өмгөөлөгчдийн төлөөлөл бүхий Ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2018 онд байгуулсан. Ажлын хэсгээс

Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд уг судалгааны үр дүнд үндэслэн хуулийн төслийг боловсруулаад байна.

Иргэний хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөд хуульд өөрөөр заагаагүй бол нэг этгээд оролцсон нь дуудлага худалдаа, уралдаан явагдаагүй гэж үзэх үндэслэл болохгүй байх, барьцаагаар хангагдсан үүргийн гүйцэтгэлийн шаардлагыг татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагын дарааллын 2 дугаарт хангах, цахим хэлбэрээр гэрээ хийх бол талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлснийг харилцан хүлээн зөвшөөрсөнөөр гэрээ байгуулсанд тооцдог байх зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд урьдчилсан хэлэлцүүлгийн шат бий болгох зохицуулалтыг тусгаж байгаа бөгөөд энэ нь тодорхой шалтгаанаар хурал хойшлуулдаг хүсэлтийг шүүх нэг дор хүлээн авч шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх юм. Түүнчлэн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгаанаас бусдаар хойшлуулахгүй байх оролцогчийн үүргийг нэмэх, оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчийг удаа дараа солих тохиолдлыг хязгаарлах, хэрэг

хянан шийдвэрлэх ажиллагааг хугацаанд нь, хэвийн явуулахад удаа дараа, санаатай саад учруулсан зохигчоос шүүх хугацаа алдсаны нөхөн төлбөрийг төлүүлэх зохицуулалтыг хуульд оруулахаар төсөлд тусгалаа.

**Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулан, хууль санаачлагчид уламжлав.** Монгол Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн 2 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгох зорилт туссан. Түүнчлэн, 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаас батлагдсан Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Монголбанкны үйл ажиллагааны чиглэлд шинээр “банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэсэн зохицуулалт нэмж орсон юм.

Иймд Дэлхийн банкнаас 2012 оны 10 дугаар сард гаргасан "Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн суурь боловсролын өнөөгийн байдлын оношлогоо дүгнэлт", Монголбанкнаас АХБ-тай хамтран 2017 онд хэрэгжүүлсэн "Санхүүгийн салбарын хөгжил, тогтвортой байдлыг дэмжих" төслийн бүрэлдэхүүн хэсэг болох "Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь" төслийн хүрээнд гаргасан тайлан болон АХБ-аас Монголбанк, СЗХ-д өгсөн зөвлөмжийн дагуу “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг боловсруулж, хууль санаачлагчид уламжлаад байна.

### 3.2 ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ

#### Их дүнтэй төлбөр тооцооны систем

Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог Монголбанкны “Банксүлжээ” системээр бодит цагийн горимоор гүйцэтгэж байгаа нь төлбөрийн системийн эрсдэлийг бууруулах, мөнгөн урсгалыг бодит цагаар хянах, мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах, заавал байлгах нөөцийг хангуулах боломжийг бүрдүүлдэг.


Их дүнтэй төлбөрийн системээр банкны, Сангийн яамны Төрийн сангийн газрын болон үнэт цаасны төлбөр тооцоог бодит цагийн горимоор гүйцэтгэхээс гадна бага дүнтэй төлбөрийн систем, төлбөрийн картын системээр дамжсан гүйлгээний үр дүнгийн тооцооллыг гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд Банксүлжээ системээр нэг өдөрт дунджаар 4.5 мянган ширхэг их дүнтэй

гүйлгээ хийгдэж буурсан дүнтэй байна. Энэ нь тус системээр дамжуулах гүйлгээний дээд хязгаарыг 2018 оны 12 сард өөрчилсөнтэй холбоотой юм.

#### Дүрслэл 3.1

Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт




Эх сурвалж: Монголбанк.

#### Бага дүнтэй төлбөр тооцооны систем

#### Дүрслэл 3.2

Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк.

Үндэсний цахим гүйлгээний төв нь бага дүнтэй төлбөрийн системийн болон төлбөрийн картын системийн гүйлгээг бодит цагийн горимоор дамжуулж, үр дүнгийн тооцооллыг Банксүлжээ систем рүү дамжуулж байна. Сүүлийн долоон жилийн байдлаар бага дүнтэй гүйлгээ нь төлбөрийн

системийн нийт гүйлгээний дүнгийн 2-6 орчим хувийг, харин гүйлгээний тооны 92-95 хувийг тус тус эзэлж байгаа юм. Олон тооны хэрэглэгч, өргөн хүрээг хамарч байдаг тул энэ системийн найдвартай, тасралтгүй ажиллагаа нь харилцагчдын банкинд итгэх итгэлд ихээхэн нөлөө үзүүлдэг. Үндэсний цахим гүйлгээний төв нь иргэд, аж ахуйн нэгжийн банк хоорондын төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай ажиллагаагаар 24/7 горимоор ханган ажиллаж байна.


Үндэсний цахим гүйлгээний төв нь 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нэг өдөрт дунджаар 26.7 тэрбум төгрөгийн 110.0 мянган ширхэг бага дүнтэй гүйлгээ дамжуулсан байна.

### Үндэсний төлбөрийн системийн талаарх бодлого зохицуулалт

Монголбанк нь Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийн тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлыг ханган, бэлэн бус төлбөр тооцоог дэмжих бодлого баримтлан ажилладаг.

#### Дүрслэл 3.3

Картын гүйлгээний нэг өдрийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк.

Монголбанк нь Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийн тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлыг ханган, бэлэн бус төлбөр тооцоог дэмжих бодлогын хүрээнд “Үндэсний төлбөрийн системийн хууль”-ийг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан. Тус хуулийн хэрэгжилтийн хүрээнд “Цахим мөнгөний журам”, “Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам”-ыг шинээр батлуулж, “Төлбөрийн картын журам”, “Бага дүнтэй төлбөрийн системийн журам”, “Их дүнтэй төлбөрийн системийн журам”-д тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан.

Түүнчлэн “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль”-д заасны дагуу “Үндэсний төлбөрийн системийн зөвлөл”-ийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдөр шинэчлэн байгуулж, 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зөвлөлийн анхны хурлыг Монголбанкнаас зохион байгуулсан. Уг зөвлөл нь төлбөрийн системийн оролцогч, хэрэглэгчийн эрх ашиг, сонирхол, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамгаалах, нэгтгэх, үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратегийн бодлогыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилготой байна.

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж төлбөр тооцоог хурдан шуурхай гүйцэтгэх, Монгол Улс дахь төлбөрийн системийн үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, ирээдүйн хөгжлийн талаар олон нийтэд таниулан сурталчлах, иргэд, хэрэглэгчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгын хүрээнд “Цахим эринд-цахим төлбөр тооцоо аян”-ыг 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Монголбанкнаас төлбөрийн системийн оролцогч, иргэдэд зориулан хэвлэмэл танилцуулга, богино хэмжээний дүрс бичлэг, мэдээ, мэдээлэл бүхий цахим хуудас ажиллуулах, төлбөрийн системийн хэрэглээ, хэрэгсэл, эрх зүйн орчны талаар хэвлэлийн мэдээ, ярилцлага, нийтлэл зэргийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон орон нутаг дахь салбаруудаараа дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллаа.



### Төлбөрийн системийн хяналт

Үндэсний төлбөрийн системийн нэгдмэл байдлыг хангах, тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, оролцогчдын тэгш, тэнцвэртэй оролцоог дэмжих, системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтлан төлбөрийн системд тавих хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу үндэсний мөнгөн тэмдэгтийг орлон төлбөр тооцоонд хэрэглэгдэх төлбөрийн хэрэгслийн зөвшөөрлийг олгон, хяналт тавин ажиллаж байна. 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар хоёр банкны төлбөрийн картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгаж, нэг банкинд ЮнионПэй төлбөрийн карт гаргах нэмэлт зөвшөөрөл олгосон бөгөөд нэг банк төлбөрийн карт гаргах, хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрлийг шинээр авсан байна. Түүнчлэн карт гаргагч, хүлээн авагчид техник, програм хангамжийн туслалцаа үзүүлэх процессорын зөвшөөрлийг “Гурван зуун жар финанс ББСБ” ХХК-д олгосон.

Төлбөрийн системийн оролцогчдоос банкны төлбөрийн картын болон хөдөлгөөнт банкны тайланг үнэн зөв ирүүлж байгаа эсэхэд хэсэгчилсэн шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг баталгаажуулж, төлбөр тооцооны болон клирингийн системүүдийн үйл ажиллагааны тайланг 7 хоногийн давтамжтайгаар гаргуулан, хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна. Ингэхдээ төлбөр тооцооны Банксүлжээ систем, Үндэсний цахим гүйлгээний төвийн хариуцан ажиллуулж буй Төлбөрийн картын клирингийн систем, бага дүнтэй төлбөрийн систем, Худалдаа хөгжлийн банкны картын свитчийн үйл ажиллагаанд мониторинг хийж, хяналтын тайланг сар бүрээр нэгтгэн удирдлагад танилцуулан, зохих үзүүлэлтийг хангаагүй зөрчил гаргасан оролцогчид цаг тухайд нь арга хэмжээ авч ажиллалаа.

### 3.3 САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27<sup>2</sup> дугаар зүйлд зааснаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн үндсэн чиг үүрэг нь Монгол Улсын санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахтай холбоотойгоор тогтолцооны шинжтэй эрсдэлийг илрүүлэх, хянах, бууруулах талаар хэлэлцэж, гишүүдийн үйл ажиллагааг уялдуулах явдал бөгөөд СТБЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь түүний ээлжит болон ээлжит бус хуралдаан байна гэж заасан байдаг.

Сүүлийн хагас жилийн хугацаанд СТБЗ 2019 оны 2 дугаар сарын 19 болон 5 дугаар сарын 14-ний өдрүүдэд ээлжит хуралдаанаа зохион байгуулж, санхүүгийн салбарт тулгамдаж буй цаг үеийн асуудлуудыг авч хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гарган ажиллаа. Тухайлбал, 2 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар (i) ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд банкны салбарт авч буй арга хэмжээний талаар; (ii) Санхүүгийн мэдээллийн албаны 2018 оны үйл ажиллагааны тайлан зэрэг асуудлуудыг хэлэлцлээ. 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит хуралдаанаар (i) Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг; (ii) ОУВС-гийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц; (iii) Капитал банкинд авч хэрэгжүүлсэн албадлагын арга хэмжээ; (iv) Санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчийн итгэлийн судалгаа зэрэг асуудлуудыг СТБЗ-ийн гишүүдэд танилцуулж хэлэлцүүлээ. Мөн тус хуралдаанаар “Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулийн төсөл” батлагдсанаар Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг үр дагаврын талаар авч хэлэлцсэн бөгөөд СТБЗ-өөс уг асуудалтай холбогдуулан зөвлөмж

гаргаж, Монгол Улсын Их Хурлын дарга, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо, Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөл, Монголын банкны холбоонд тус тус хүргүүлсэн болно.

Түүнчлэн СТБЗ нь шаардлагатай асуудлуудыг ээлжит хуралдаанаараа авч хэлэлцэхээс гадна 2019 оны 4 дүгээр сард санхүүгийн салбарын тэнцвэртэй хөгжил, тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г ажлын журмаар хамтарсан тушаалаар баталж, холбогдох байгууллагууд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2013 онд СТБЗ-өөс Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам бэлтгэн, олон нийтэд хүргэх үүрэгтэй, байнгын үйл ажиллагаатай нэгж бий болгохоор шийдвэрлэсний дагуу СТБЗ-ийн Ажлын албыг Монголбанкинд төвлөрүүлэн ажиллуулж байна.

СТБЗ-ийн Ажлын алба нь Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпорацийн холбогдох газруудтай хамтран ажиллаж, тайлан мэдээллийг хүлээн авч, “Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн эхний 12 дугаарыг нэгтгэн боловсруулж, хэвлүүлэн, Монголбанкны цахим хуудаст байршуулж, олон нийтийн хүртээл болгосон бөгөөд ийнхүү 13 дахь дугаарыг Та бүхэнд хүргэж байна.



## ТЭМДЭГЛЭЛ